

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө  
Монголын өнөөгийн байдал

(2005 оны 10-р сараас 2006 оны 10-р сар)

Гарчиг

1. Оршил

2. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа

Үндсэн Хууль

Олон улсын эрх зүй

2.1 Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба хэвлэл мэдээлэл

Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль

Олон нийтийн радио телевизийн тухай хууль

Эрүүгийн хуулийн 139-р зүйл

2.2 Хязгаарлалт

Төрийн нууц

Байгууллагын нууц

Гүтгэлэг, нэр төр, доромжлолтой холбоотой хууль тогтоомж

Бусад хязгаарлалт

2.3 Мэдээллийн эрх чөлөө

2.4 Сэтгүүлч нууц эх сурвалжаа хамгаалах нь

3. Хараат бус хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн эрхийн зөрчил

3.1 Сэтгүүлчдийн эсрэг дайралт

3.2 Мэдээлэл өгөхөөс татгалзах нь

3.3 Эх сурвалжаа илчлэхийг шаардах нь

3.4 Сэтгүүлчийн хувийн аюулгүй байдал

3.5 Хэвлэл мэдээллийн өмчлөл

3.6 Доромжпол , гүтгэлгийн хуулийг ашиглаж буй нь

3.7

4. Дүгнэлт

Хавсралт

Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн шилжилтийн үйл явц.

Мониторингийн тайлан

Хавсралт №1

Сэтгүүлчдийн биеийн эрх чөлөөнд халдсан хэргийн судалгаа

Г. Батжавын хэрэг

Хавсралт № 2.1

Б. Цэгмидийн хэрэг

Хавсралт № 2.2

Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэгт хийсэн судалгаа

Г. Дашрэнцэнгийн хэрэг

Хавсралт № 3.1

Д. Ганхуягийн хэрэг

Хавсралт № 3.2

Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооны мэдэгдлүүд  
4.4

Хавсралт № 4.1-

“Цагдан хяналтын эсрэг!!!” “Глоб Интернэшнл”  
төрийн бус байгууллагын уриалга

Хавсралт № 5.1

## I. Оршил

Бид анх удаа Монгол дахь хэвлэлийн эрх чөлөөний тайлан бэлтгэж, та бүхэнд толилуулж байна. Ийм тайлан бэлтгэх боломж олгосон Нээлттэй Нийгэм Форум (ННФ), Нээлттэй Нийгэм Хүрээлэн (ННХ)-гийн Хэвлэл мэдээллийн бүсийн хөтөлбөрт талархал илэрхийлье.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, ялангуяа хэвлэлийн эрх чөлөө нь ардчилсан нийгмийн салшгүй хэсэг юм. Чөлөөт, хараат бус хэвлэл мэдээлэл бол улс төрч, эрх баригчдаас ард түмэнд өгч буй бэлэг биш. Хэвлэлийн эрх чөлөө, хараат бус хэвлэл бол ардчилсан нийгэмд амьдарч буй хүний суурь эрхийн нэг юм.

Төрөөс хараат бус хэвлэл мэдээллийн улс төр, эдийн засаг, эрх зүйн таатай орчинг хэрхэн бүрдүүлж буй нь түүний иргэндээ үйлчлэх үргийн биелэлтийн хэмжүүр юм. Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээлэл, сэтгүүлчид төр, түүний эрх баригчдад бус олон түмэнд үйлчилж, нийгмийн хоточ нохой байж, эрх мэдлийг хянах үүрэг гүйцэтгэдэг.

Энэ тайлан нь Монголын сэтгүүлчид мэргэжлийн эрхээ хэрхэн эдэлж буй, тэдний олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа шударгаар биелүүлэх боломж нь аль хэр байгааг баримтад тулгуурлан монголын хэвлэлийн эрх чөлөөний өнөөгийн дүр төрхийг харуулах зорилготой юм.

Тайлан үндсэн хоёр бүлэгтэй. Эхний бүлэгт иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний баталгаа, мөн түүнийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн тухай мэдээллийг оруулсан болно.

Тайлангийн II бүлгээс сэтгүүлчдийн эрхийн зөрчлийн тухай жишээ баримтаас тусгав. Эдгээр нь 2005 оны 10-р сараас 2006 оны 10-р сарыг дуустал хийсэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторингийн дүнд үндэслэгдсэн юм. Мониторинг нь ННФ, ННХ-гийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг, хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь” төслийн нэг хэсэг юм. Ийм мониторинг урьд өмнө хийгдэж байгаагүй билээ. Мониторингийн сүлжээнд Улаанбаатар хот, Баян-Өлгий, Дархан-Уул, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Ховд, Хэнтий аймаг дахь бүсийн мониторчид хамрагдан ажилласан юм.

Энэ бүлэгт бид мөн дээр дурдсан төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт, семинар, уулзалт зэрэг арга хэмжээнд оролцсон сэтгүүлч, хуульчдын санаа бодол, эрх баригчдаас хэвлэл мэдээллийн чиглэлээр хэлсэн үг, хэвлэл мэдээллээр өгсөн ярилцлага, Иргэний хууль, Эрүүгийн хуулийг хэрхэн ашиглаж буйд хийсэн судалгаа зэргийг ашиглав.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын хуульчид анх удаа хэвлэл мэдээллийн эсрэг хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал, мөн сэтгүүлчдийн эрүүл мэндэд халдсан хэргийн үйл явцад судалгаа хийсэнийг энэ тайландаа бүрэн эхээр нь оруулсан болно.

Тайлангийн III бүлэгт ерөнхий дүгнэлт, цаашид хийвэл зохих зүйлийн тухай санал дэвшүүлсэн болно.

## **II. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа**

### **2.1 Үндсэн Хууль**

Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хамгаалж, дор дурдсан заалтаар баталгаажуулсан,

Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

16.16. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.

16.17. Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.

### **2.2 Олон улсын эрх зүй**

Монгол Улс НҮБ-ын гишүүний хувьд Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг хүлээн зөвшөөрсөн. 1974 онд Иргэний болон Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пактад нэгдэн орсон. Иймд Монгол Улс дээрх хоёр бичиг баримтын 19-р зүйлд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг олон улсын эрх зүйн дагуу хамгаалах үүрэгтэй.

Үүнийгээ Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд албан ёсоор хүлээн зөвшөөрсөн:

1. Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна.
2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.
3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.
4. Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй.

## **2.1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба хэвлэл мэдээлэл**

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний баталгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжин хэрэгжиж, хэвлэлийн эрх чөлөөг бодитой болгодог. “Эрх зүйт төрд хэвлэл мэдээлэл давамгайлах үүрэгтэй” тухай олон улсын олон бичиг баримтад заасан байдаг. Хэвлэлийн эрх чөлөө нь олон нийтэд өөрийн улс төрийн удирдагчдын үзэл санаа болон асуудалд хандах байр суурийг нээх хамгийн сайн арга хэрэгсэл болдог.

Европын Хүний эрхийн шүүх гэхэд “олон нийтийн сонирхолын бүх салбарт мэдээлэл түгээх нь хэвлэл мэдээллийн үүрэг” гэж заасан.

Хэвлэлийн эрх чөлөө нь “хөндлөнгийн нөлөөлөл, оролцооноос ангид чөлөөтэй байх яедал” (орч. Ц.Дашдондов) хэмээн Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо (ОУСХ) тодорхойлсныг НҮБ, олон улсын хүний эрхийн байгууллага, улс орнуудын засгийн газар хүлээн зөвшөөрсөн байдаг.

ОУСХ-ны 21-р их хурлаас баталсан “Ардчилсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн соёлын тунхаг”-т “Ардчилсан нийгэмд мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг онцгой өвөгмөц агаад тухайлсан үүргийг ухаарч сэхээрсэн тэр цагт ардчилал бүрнээ үнэ хүндтэй болох учиртай” (орч. Ц.Дашдондов) гэсэн байдаг.

### *Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль*

1998 оны 8 дугаар сарын 28-ны өдөр УИХ-аас Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль баталсан юм.

Хуулийн 1 дүгээр зүйл:

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, уг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажулахад оршино. (Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиас)

Энэ хуулийн 2-р зүйлээр хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглосон юм.

Хуулийн 3 дугаар зүйлээр “төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тавихыг хориглож, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ” гэж заасан ба 4-р зүйлээр “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно” гэжээ.

1998 оны 8-р сарын 28-ны “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх тухай” УИХ-ын 103 тоот тогтоолоор төрийн мэдлийн өргөн нэвтрүүлгийг олон нийтийн болгон өөрчлөн байгуулахаар заасан билээ.

#### *Олон нийтийн радио телевизийн тухай хууль*

Монголд олон нийтийн радио, телевиз байгуулагдсан нь эрх баригчдаас сүүлийн жилүүдэд хэвлэлийн эрх чөлөөг бататгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн өндөр ач холбогдол бүхий чухал арга хэмжээ байлаа.

1998 оноос хойш долоон жил saatсаны эцэст Улсын Их Хурлаас 2005 оны 1-р сарын 17-ний өдөр Олон нийтийн радио, телевизийн (ОНРТ) тухай хууль батлан гаргав.

ОНРТ-ийн тухай хууль 2005 оны 7-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн юм. Монголын Үндэсний Радио, Телевизийн Хэрэг эрхлэх газар татан буугдаж, оронд нь Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевиз (МООНРТ) байгуулагдан 2006 оны 2-р сарын 8-ны өдөр Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамны Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.

Засгийн газраас чөлөөт олон нийтийн радио, телевизийг байгуулах, хөгжүүлэх шилжилтийн үйл явцад “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагаас хийсэн Мониторингийн тайланг бүрэн эхээр нь Хавсралт 1-ээс үзнэ үү.

#### *Эрүүгийн хууль*

2002 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 139-р зүйлд сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийхийг гэмт хэрэг гэж үзсэн шинэ заалт орсон.

139.1. Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд тараах, эсхүл тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучин нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. (Эрүүгийн хуулиас)

2005 оны 11-р сарын 23-нд манай байгууллагаас зохион байгуулсан хуульчдын уулзалтын үер сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн бол гэмт хэрэг болохыг зүйлчилсэн Эрүүгийн хуулийн 139-р зүйлийг амьдралд хэрэгжих боломжгүй гэж үзсэн байна. Учир нь энэ зүйл заалт тодорхой бус, ойлгомж муутай учир тайлбар шаардлагатай ажээ. Тухайлбал, өмгөөлөгч Д.Оросоо, Э.Болорчулуун нар энэ заалтыг 2002 онд болсон “Газрыг шударгаар хувьчлах” иргэний хөдөлгөөний жагсаалын үеэр 24 цаг саатуулагдсан сэтгүүлчдийн гомдолд хэрэглэх гэж оролджээ. Гэвч Улсын Прокуророос “энэ хэрэгт гэмт хэргийн шинж байхгүй” гэсэн үндэслэлээр гомдолыг хэрэгсэхгүй болгосон байна. Сэтгүүлчдийг барьж саатуулсан цагдаа нар “Харанхуй байсан тул сэтгүүлчид гэж мэдээгүй, мөн цагдаагийн энэ ажиллагаа зөвхөн сэтгүүлчийн эсрэг чиглэгдсэн бус” гэсэн тайлбар өгсөн байна. Харин цагдаа нарын үйл ажиллагаа зөвхөн сэтгүүлчдийг барьж саатуулах зорилготой байсан бол гэмт хэрэг гэж болохоор байсан гэнэ. Мөн “тухайн жагсаал цуглаан нь хууль бус байсан” гэсэн тайлбарыг “Шүүх хэвлэлийн эрх чөлөөг хэрхэн хамгаалах вэ?” сэдэвт манай дугуй ширээний ярилцлагад оролцсон, энэ хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргасан прокурор бидэнд өгсөн юм.

139.2. Энэ хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгзээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш, зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. (Эрүүгийн хуулиас)

## 2.2 Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт

### Төрийн нууц

Монгол Улсад төрийн нууцыг Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар хамгаалдаг. Төрийн нууцын тухай хууль 1995 онд батлагдаж, хамгийн сүүлд 2004 оны 1-р сарын 2-нд нэмэлт өөрчлөлт оруулсан. Төрийн нууцын тухай хуульд: “Төрийн нууц” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийг томъёолол, дүрс зураг, дохио тэмдэг, техник-технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг.

Хуулийн 11-р зүйлд зааснаар “Төрийн нууцыг задруулснаас Монгол Улсын ашиг сонирхол, аюулгүй байдалд учирч болох хор уршгийн хэмжээнээс хамааран төрийн нууцын зэрэглэлийг тогтооно” гэсэн бөгөөд төрийн нууц нь онц чухал-маш нууц, маш нууц, нууц гэсэн гурван зэрэглэлтэй байна.

Төрийн нууцын тухай хуулиар төрийн нууцыг үндсэн 5 төрөлд ангилдаг. Мөн Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар 59 зүйлийн мэдээллийг,

тухайлбал үндэсний аюулгүй байдлын хүрээнд 19, батлан хамгаалах хүрээнд 14, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, технологийн хүрээнд 5, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд 15, бусад хүрээнд 6 зүйлийн мэдээллийг нууцлахаар тогтоожээ. Нийт 59 зүйлээр тогтоосон мэдээллийн 69.5 хувийг 40-60 жилээр, эсвэл байнга нууцалсан байна.

Нууцалсан зэрэглэлээр үзвэл онц чухал-маш нууц мэдээлэл 6, маш нууц мэдээлэл 24, нууц мэдээлэл 7 байна. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулинд шууд зааж өгөөгүй, нууцалсан зэрэглэлээр гэж ангилсан 25 мэдээлэл байгаа юм.

2004 оны 4-р сарын 23-нд нэмэлт оруулсан Төрийн нууцын жагсаалтын хуульд “Терроризмтой тэмцэх ажиллагаатай холбогдох мэдээ, баримт бичгийг бүхэлд нь нууцалсан зэрэглэлээр, байнга”-ын хугацаагаар нууцлах ажээ.

Эрүүгийн хуулийн 87.1 дүгээр зүйлд төрийн нууц задруулах гэмт хэргийг зааж өгсөн байдаг. Үүнд “Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг итгэмжлэгдэн хариуцсан буюу албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”, 87.2 дугаар зүйлд “Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан байдаг.

Тайлангийн хугацаанд төрийн нууцыг задруулсан хэргээр сэтгүүлч шийтгэл хүлээсэн тохиолдол гараагүй байна

### Байгууллагын нууц

1995 оны 5 дугаар сарын 16-ны өдөр баталсан Байгууллагын нууцын тухай хууль нь нууцын дэглэмийг байгууллагад хамруулсан. Үүнд байгууллагын нууц нь тухайн байгууллагын хамгаалалтад байна. Байгууллага нь нууцаа хамгаалах журмыг өөрөө тогтоож мөрдөнө гэж заасан /5.1/ Энэ хатуу заалтыг 6 дугаар зүйлээр зөвлүүлэх оролдлого хийж нууцлахыг хориглох мэдээллийн жагсаалтыг баталсан. Үүнд тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл бол, мөн тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээллийг нууцлахыг хоригложээ. Мөн гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээллийг байгууллага нууцалж болохгүй ажээ.

Эрүүгийн хуулийн 164-р зүйлээр санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааны нууцыг хууль бусаар олж авах, задруулбал торгохоос эхлэн гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэхээр заасан. Энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол дээд тал нь гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх юм байна.

## *Гутгэлэг, нэр төр, доромжлолтой холбоотой хууль тогтоомж*

Үндсэн хуулийн 16.17-д мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг бусдын "нэр төр, алдар хүндийг хамгаалах" үүднээс хязгаарлаж болно гэж заасан.

2002 оны 9 сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 110, 111-р зүйлээр нэр төр, алдар хүндийг доромжилсон, гутгэлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан бол гэмт хэрэг гэж үзсэн байдаг.

### **110 дугаар зүйл. Доромжлох**

110.1. Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр доромжилсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.  
(Эрүүгийн хуулиас)

### **111 дүгээр зүйл. Гүтгэх**

111.1. Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

111.2. Гүтгэлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд тараасан, эсхүл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

Мөн 111-р зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар "Хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэнээс хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ"

Монголд улс төрч, төрийн өндөр албан тушаалтан, албан хаагчдын шүүмжлэлд хүлээцтэй хандах талаар гаргасан эрх зүйн акт байхгүй. Харин энэ Эрүүгийн хууль батлагдахаас өмнө 1994 оны Иргэний хуулийн 7, 392 дугаар зүйлийг хэрэглэх тухай Улсын Дээд Шүүхийн зөвлөмж 2000 онд гарсан байдаг. Зөвлөмжийн 13-т "төр, засгийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтан нарын албаны үйл ажиллагаа, үзэл баримтлал, авч буй арга хэмжээг олон түмний зүгээс шүүмжилж байгаа явдал байгууллага, ажилтны нэр төрийг гутааж буй явдал биш болно. Гэхдээ хэм хэмжээнээс хэтэрсэн шүүмжлэл нь бусдын нэр төрийг гутаахад чиглэгдсэн буюу ийм байдалд хүргэсэн бол нэр төр гутаагдсан гэж үзнэ" хэмээжээ.

2002 оны Иргэний хуулийн 21 дүгээр зүйлээр иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан байна.

21.2. Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсэн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл,

**эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ.**

Иргэний хуулийн 497-р зүйлийн нэг дэх хэсэгт “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэл/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй” гэж заажээ.

Мөн “Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлсэн тохиолдолд (21.5) тухайн этгээд гэм хорыг арилгуулахыг шаардах эрхтэй.

### **Бусад хязгаарлалт**

Монголд үзэл бодлоо илэрхийлэх ба мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан бусад олон тооны хууль тогтоомж байдаг. “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын Лондон хотод төвтэй олон улсын 19-р зүйл (ARTICLE 19) байгууллагатай хамтран 2001 онд монголын 232 хуульд хийсэн судалгаагаар ийм хууль, хуулийн заалт 91 байсан.

Эрүүгийн хуулиар сэтгүүлчдийг шийтгэж болзошгүй зарим заалтыг энд дурдав.

Эрүүгийн хуулийн 136.1-д зааснаар “Хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцыг албаны болон мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа мэдсэн этгээд задруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ”.

Мөн хуулиар садар самоуныг сурталчилсан (123-р зүйл), иргэний захидал харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчсөн (135-р зүйл), шашны харгис үзэл номлолыг санаатай сурталчилсан буюу тараасан бол (144.1-р зүйл), Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хэргийн мэдээ баримтыг задруулсан бол (257.1-р зүйл) торгохоос нэгээс гурван сарын хугацаагаар баривчлах хүртэл ял шийтгэх ажээ.

Мөн олон нийтийн дунд дайн явуулахыг сурталчилсан, дайнд уриалсан бол (298.1-р зүйл) нэгээс гурван сар баривчлах ба энэ хэргийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах замаар буюу төрийн албан хаагч үйлдсэн бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

### **231 дүгээр зүйл. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох**

231.1. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан олны өмнө доромжилсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас нэг зуун тавин цаг хүртэл хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулиас

Энэ хуульд тайлбарласнаар “Төрийн албан хаагч” гэдэгт шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гааль, татварын албаны байцаагч, хууль тогтоомжоор тусгайлсан эрх олгосон улсын байцаагч нарыг хамруулан ойлгоно.

## 2.3 Мэдээллийн эрх чөлөө

Монгол Улсад төрийн, байгууллагын, хувийн нууцыг хуулиар хамгаалсан атлаа төрийн байгууллагаас мэдээлэл авах тухай хууль тогтоомж байхгүй.

“Глоб Интернэшил” төрийн бус байгууллагаас 2002 онд Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн (одоогийн ННФ), АНУ-ын Элчин Сайдын Яам, Австралийн Олон улсын Хөгжлийн Агентлагийн санхүүгийн дэмжлэгээр мэдээллийн эрх чөлөөний мөн чанар, үзэл баримтлал, зарчмуудыг түгээн дэлгэрүүлэх, ойлгуулах чиглэлээр өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулж, 2004 онд Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн анхны төслийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд танилцуулсан юм. Энэ хуулийг хэлэлцэж батлахаар УИХ-аас 2005 оны 11-р сард чуулганы хэлэлцэх асуудлын дэгд оруулсан байв. Гэвч энэ хууль өнөө хэр батлагдаагүй байна.

2006 оны 10-р сард Засгийн газрын хуралдаанаар энэ хуулийг УИХ-д өргөн барих асуудлыг хэлэлцсэн боловч мэдээлэл түгээх, мэдээллийн аюулгүй байдлын зохицуулалттай уялдуулан багцлан хэлэлцэхээр болж хойшлуулсан байна.

## 2.4 Сэтгүүлч нууц эх сурвалжаа хамгаалах нь

Монгол Улсад сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах тухай хууль тогтоомж байхгүй.

Улсын Дээд Шүүхийн иргэний хэргийн танхимиын 2000 оны 6-р сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталсан Зөвлөмжийн 8 дахь заалтаар сэтгүүлч “мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхтэй” болохыг хүлээн зөвшөөрсөн байдаг.

“Сэтгүүлчийн эх сурвалжийг хамгаалах нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах нэг үндсэн нөхцөл болдог” гэдгийг гадаадын улс орнууд хүлээн зөвшөөрч, хууль тогтоомжоор баталгаажуулсан байдаг. Эх сурвалжийн хамгаалалтыг сэтгүүлчдийн баримтлах зарчим, мэргэжлийн ёс зүйн дүрэм журмаар сэтгүүлчдэд эх сурвалжаа хамгаалах үүрэг ноогдуулсан байдаг.

Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн 2005 оны 3-р сарын 11-ний өдөр батлагдсан “Монголын сэтгүүлчдийн баримтлах зарчим”-ын 4 дэх зүйлд “Хүний итгэлийг хүлээж олсон мэдээллийнхээ эх сурвалжийг ямар ч тохиолдолд чанад нууцална” гэж заасан байна.

# 3. Хараат бус хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн эрхийн зөрчил

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагаас 2005 оны 10-р сараас эхлэн Нээлттэй Нийгэм Форум, ННХ-гийн Хэвлэл мэдээллийн бүсийн хөтөлбөрийн санхүүжилтээр үзэл бодлоо илэрхийлэх зөрчлийн мониторинг хийж эхэлсэн юм. Мониторингийн хугацаанд нийт 41 зөрчлийн тухай баримт мэдээ бүртгэгдсэн байна.

Манай оронд сэтгүүлчийн “мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулахыг гэмт хэрэг” гэж үзсэн, цагдан хяналт (цензур)-ыг хориглосон хууль тогтоомж байдаг ч амьдрал дээр огт хэрэгжихгүй байгаа юм.

Ажил үүргээ гүйцэтгэж яваа сэтгүүлчид элдэв төрлийн дайралтад өртөх, мэдээлэл олж авах явцдаа янз бүрийн саад бэрхшээлтэй учрах, тэднийг эх сурвалжаа илчлэхийг шаардах, тэр бүү хэл биеийн эрх чөлөөнд нь халдаж, эрүүл мэндээр нь хохироо зэрэг зөрчил илэрч байгаа Монголын сэтгүүлчдийн ажиллах нөхцөл амаргүй, түвштэй байгааг илтгэж байна.

Өөрсдийнх нь эсрэг шинэ дайралт ихсэхээс болгоомжлон тухайн тохиолдлыг олон нийтэд мэдээлэхийг хүсээгүй, эсвэл нэрийг нь дурдахаас татгалзсан сэтгүүлч цөөнгүй байгаа тул бид бүх зөрчлийн жишээ баримтыг энэ тайланд өгүүлж чадаагүй билээ. Тэр ч бүү хэл сэтгүүлч эмэгтэйг шүүмжлэлд өртсөн хүн нь хүчиндсэн ноцтой хэрэг гарсныг манай байгууллага судалж байна.

### **3.1 Сэтгүүлчдийн эсрэг дайралт**

Сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх оролдлого хийж, шахалт дарамт үзүүлж буй нь цагдан хяналт (цензур) бодитой байгаагийн илрэл юм.

Сэтгүүлчдийн эсрэг дайралт нь сурдуулэх, заналхийлэх, уг хэлээр дайран доромжлох, эд хөрөнгөд нь халдах, баривчлах, saatuuulan хорих зэрэг хэлбэрээр илэрч байна. Мөн сэтгүүлчдийн нийтлэл, нэвтрүүлгийн мэдээ баримтыг няцаан янз бүрийн мэдэгдэл гаргаж, олон нийтийг төөрөгдүүлэх нь Монголын эрх баригчдын түгээмэл арга болсон байна.

Хувийн хэвшилийнхэн, иргэд ч сэтгүүлчдийн эсрэг дайран довтолж, мэдээлэл цуглуулах, үйл явдлыг сурвалжлахад нь саад хийж байна.

Мөн манай оронд амьдарч буй гадаадын хөрөнгө чинээлэг иргэд ч өндөр албан тушаалтуудаар дамжуулан сэтгүүлчдийг дарамталсан тохиолдол гарч байгаа юм. Тухайлбал, Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж буй телевизийн нэг сувгийн сурвалжлагч Солонгосын бизнесмэнүүд зам тээврийн авто осол, хэрэг үйлдсэнийг газар дээрээс нь сурвалжлан бэлтгэсэн мэдээгээ тэдний дарамт шахалтаар үзэгчдэд хүргэж чадаагүй байна. Мөн телевизийн өөр бас нэг сувгийн сэтгүүлч бага насны хүүхдийг садар самуунд уруу татаж буй солонгос иргэдийн тухай бэлтгэсэн нэвтрүүлгийнхээ хальсийг арчихаас өөр аргагүй байдалд хүрчээ.

Монгол Улсын Үндсэн Хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрийн заалтыг хэлбэрэлтгүй биелүүлэх нь төрийг төлөөлж буй албан тушаалтан, албан хаагч, эрх мэдэлтний иргэдийнхээ өмнө хүлээсэн үүрэг юм.

Хуулиа дээдлэн хүндэтгэж, сэтгүүлчдийг олон нийтэд мэдээлэл түгээх үндсэн үүрэгт саад болсон гэм буруутай этгээдүүдэд хариуцлага хүлээлгэхийг “Глоб Интернэшнл” ТББ удаа дараа шаардан тухай бүрт

хэвлэлийн мэдэгдэл, албан захидал явуулсан билээ. Зарим жишээг дор дурдав.

Монголд алт олборлож байгаа Канадын зуун хувийн хөрөнгө оруулалттай “Бороо гоулд” компанийн үйл ажиллагааг эсэргүүцсэн иргэний хөдөлгөөний тэмцэгчид 2006 оны зургадугаар сарын 14-17-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Зүүнхараа сумын нутаг дахь тус компанийн олборлолтын талбай руу дайран орж, эсэргүүцлийн суулт хийжээ. Гэтэл тэднийг цагдаагийнхан нэг нэгээр нь машинд чихэж суулган баривчилж улмаар ажилчдын гэрт аваачин хорьж, байцаалт авч эхэлсэн байна.

Үйл явдлыг газар дээрээс нь сурвалжилж байсан “Өдрийн сонин”-ы сурвалжлагч Б.Болд “Тэмцэгчдийг хэний, ямар тушаалаар баривчлах болсон” учрыг тодруулахаар сэтгүүлчийнхээ үнэмлэхийг үзүүлжээ. Нэрээ хэлэхийг хүсээгүй цагдаагийн хошууч сэтгүүлчийн үнэмлэхийг хураан авч, шууд машинд суулган, тэмцэгчдийн хамт хоёр цагийн турш саатуулсан байна.

Сэтгүүлч Г.Ганчимэг 2006 оны 1-р сарын 1 өдрийн “Ховдын мэдээ” сонины №01-т “Болиоч дээ” буланд “Онгоцны тийз мөнхийн шүдний өвчин хэвээр байх уу, эсвэл...” гэсэн гарчигтай мэдээ бичжээ. Сэтгүүлч мэдээгээ Ховд-Улаанбаатарын чиглэлийн нисэх онгоцны тийз худалдан авахад зохиомлоор дугаар үүсгэж, тийзийн үнэ болох 76500 төгрөг дээр 5000-10000 төгрөг нэмж төлөхийг шаардан илүү бичсэн мөнгөө хувьдаа завшдаг тухай хүмүүсийн яриаг шалгаж нягтласны үндсэн дээр баримтад түшиглэн бичсэн байна. Гэтэл “Айро Монгол” компанийн Ховд аймаг дахь төлөөлөгч Б.Бүжинлхам, касс З.Булганчимэг нар “Мэдээллийн эх сурвалжaa хэл, үгүй бол шүүхэд хандана” хэмээн сурдуулжээ. “Мэдээгээ сонинд тавихаас өмнө бидэнд заавал үзүүлэх ёстой байсан” гэж тэд сэтгүүлчийг буруутгасан байна.

Булган аймгийн Цагдаагийн Газрын замын цагдаа Б.Соёл-Эрдэнэ долоо хоног тутмын “Булганы мэдээ” сонины эрхлэгч Г.Норжмоог баривчилна хэмээн 2005 оны сүүлийн хагаст тус сонины газар руу удаа дараа ирж сурдуулжээ. Тэрээр мөн өөрөө сонины редакц дээр ирж, Цагдаагийн Газрын олон нийттэй харьцах албаны ажилтныг явуулан дээрхи сурдуулгээ дөрвөн удаа давтсан байна. Сонины эрхлэгч эмэгтэйг сурдуулэх болсны учир нь “Замын цагдаа алаг үзээ” гэсэн мэдээ “Булганы мэдээ” сонины 2005 оны 25 дугаарт нийтлэгдсэнтэй холбоотой ажээ.

Орхон аймгийн “Шинэ мэдээ” сонины сурвалжлагч Д.Цэнд-Аюуш, Б.Дуламсүрэн нар нь, хүн амины хэрэгт сэжиглэгдэн хоригдож байгаа иргэн н.Маралын хэргийн талаар сурвалжлага хийхээр 2005 оны 12-р сарын 15-нд аймгийн прокурорын газар очжээ. Аймгийн хяналтын прокурор Ц.Алтангадас ямар ч тайлбаргүйгээр, дээрх хоёр сэтгүүлчид мэдээлэл өгөхөөс эрс татгалзан “Та нар наад бичлэгээ унтраачих, одоо гарцгаа! Гарахгүй бол би хүн дуудаад хүч хэрэглэж гаргуулна” хэмээн сурдуулсэн байна. Сурвалжлагчид уг хэргийг мөрдөж байгаа мөрдөн байцаагч Б.Мөнгөншагайгаас мэдээлэл авахыг хүсэхэд, мөн татгалзаж, түрэмгий авирлан тэднийг өрөөнөөсөө хөөсөн байна. Прокурор Ц.Алтангадасын сурдуулгийн үгийг сэтгүүлчид, хальсандaa бичиж авч үлджээ.

“Тус аймагт ямарваа хэргийг мөрдөх явц дэндүү хаалттай учраас, хүнийг яаж ч хилсдүүлж болохоор байгаа, түүнчлэн хэрэг мөрдөгдөх явцад хүний эрх зөрчигдвөл түүнийг мэдээлж, олон нийтэд хүргэх ямар ч боломжгүй” гэж сэтгүүлчид үзэж байна.

“Зиндаа” сонины 2006 оны № 9-т “Хоригдлуудаа хэт задруулж байгаа юм биш үү?” нэرتэй мэдээ нийтлүүлснийх нь төлөө, тус сонины Булган аймаг дахь сурвалжлагч Ж.Мөнх-Очирыг, 439 дүгээр хорих ангийн дарга Ж.Вячаслав “Яагаад худлаа бичээд байгаа юм. Хамаагүй ингэж мэдээ бичээд байвал шүүхээр арга хэмжээ авахуулдгийг мэдэх үү? Хуулийн дагуу ярина шүү! “ хэмээн сүрдүүлжээ. Аймгийн Засаг Даргын Тамгын Газар 2006 оны 3-р сарын 13-ны өдөр болсон аймгийн удирдах ажилтны уулзалтан дээр тэр ингэж авирлажээ.

Булган аймгийн нутаг дэвсгэрт байрладаг 439 дүгээр хорих ангийн нэгэн ялтан гадуур чөлөөтөй сэлгүүцэн **дураараа** машин барьж яваад автын зөрчил гарган хүн дайрч амь насыг нь хохиросон байна. Үүний өмнө бас нэг хоригдол нь хорих ангийн зарим ажилтантай хамт машин жолоодож яваад бусдын машинтай мөргөлдөн сууж явсан хүнийг нь бэртээжээ. Энэ тухай аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга Удирдах ажилтны зөвлөгөөн дээр мэдээлсэн байна. Албаны хүний бодитой эх сурвалжаас мэдээлэл авч бичсэн энэ мэдээнд буруу ташаа зүйл байхгүй, хэргийн мөрдөн байцаалтад сөргөөр нөлөөлөх ямар ч зүйл дурдаагүй, зөвхөн болсон явдлыг нь мэдээлсэн гэдгийг нь сэтгүүлч Ж.Мөнх-Очир Хорих ангийн даргад тайлбарласан боловч тэрбээр сэтгүүлчийг тийнхүү сүрдүүлсэн байна.

“Хорих ангийн даргын энэ авир нь, ялтан хүмүүжигчээ дураар нь задгай тавьсан дутагдлаа дээд удирдлагаасаа нуухын тулд уг машиныг ялтан биш, өөрийн байгууллагын хүмүүжүүлэгч ажилтнаа барьж явсан мэтээр булзааруулах гэсэн хэрэг” хэмээн зам тээврийн осол хэргийн зөрчлийг тухайн үед нь газар дээр нь илрүүлсэн цагдаагийн ажилтан Ганбат, Баярсайхан нар сэтгүүлчдэд ярьсан байна.

Завхан аймгийн Засаг дарга Л.Гансух, 2005 оны 12 дугаар сарын 31-ны өдөр, орон нутгийн хэвлэл “Завхан” сонины эрхлэгч Б.Идэр, Засаг даргын тамгын газрын хэвлэл мэдээллийн албаны дарга Д.Нацагмаа нарыг зарим сэтгүүлчдийн хамт өрөөндөө дуудаж загнажээ. “Завхан” сонин “Улиастай” зочид буудлыг дуудлага худалдаанд оруулах тухай Завхан аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас албан ёсоор ирүүлсэн зарыг 12-р сарын 20-ны өдрийн №35-т нийтлүүлсэн байна. Засаг дарга сонины эрхлэгч Б.Идэрийг зар мэдээгээ тавихдаа зөвшөөрөл авалгүйгээр сониндоо нийтэлсэн нь буруу тул яаралтай засаж, запруулах үүрэг өгсөн байна. Тэрээр тус сонинд нийтэлж байгаа зүйлийг хянаж цензурдаж байсангүй хэмээн ХМА-ныхаа даргыг буруутгажээ. Тэр ч бүү хэл “Иймэрхүү алдаагаа засаж запруулахгүй бол ажлаас чинь халж, сониньг чинь хаах хүртэл арга хэмжээ авна” хэмээн сүрдүүлжээ. “Завхан” сонин нь орон нутгийн хэвлэлийн сүлжээнд хамрагддаг тул уг зарлал Монгол улс даяар түгсэн хэмээн Засаг дарга бачуурчээ. Уг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Албадан дуудлага худалдааг эрхлэн хөтлөгч уг

худалдаа эхлэхээс 14 хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгслээр энэ тухай нийтэд мэдээлнэ” хэмээн заасан ажээ.

Дорнод аймгийн “Дорнод” сонины сурвалжлагч сэтгүүлч М.Одгэрэлийг Дорнод аймгийн Онцгой байдлын хэлтсийн дэд даргаар ажиллаж байсан Д.Сүхбаатар гэгч гар утас руу нь заналхийлсэн өнгө аястай “Чиний ар гэр, ах дүү нарыг чинь судалсан. Чамтай тооцоо бодно” гэж мессеж олноор бичин дарамталж байна. М.Одгэрэл өнгөрсөн онд “Дорнод” сониндоо “Сая саяын луйвар буюу Д.Сүхбаатарын хууль бус ажиллагага” гарчигтай шүүмжлэлт нийтлэл бичжээ. Сэтгүүлч нийтлэл бичихээр эрэн сурвалжлага хийх явцад Д.Сүхбаатар өөрийнхөө талаар сонинд гарах нь гэж мэдээд сонины редакцийн эрхлэгч Б.Туяа руу аймгийн зарим нэг албан тушаалтнаар дамжуулан уг өгүүллийг нийтлүүлэхгүй байх талаар яриулж нөлөөлөх гэж оролдож байжээ. Мөн Д.Сүхбаатар энэ үеэр сурвалжлагч бүсгүй М.Одгэрэлийг хоолонд урих, гар утасны нэгж их хэмжээгээр өгөхийг хүртэл оролдсон байна.

“Хөвсгөл геологи” компанийн захирал Л.Төмөрбаатарын тухай шүүмжлэлт материал нийтэлсэн Хөвсгөл аймгийн “Эрх чөлөө” сонины редактор Ю.Гэрэлтуяа байнгын дарамтад өртөх болжээ. Л.Төмөрбаатар эрхлэгчийг утсаар, мөн өөрөө ирж хэд хэдэн удаа заналхийлсэн байна. Энэ байдал нь улам даамжирч, “Би эрх мэдэл, мөнгөтэй хүн. Сонинг чинь хаалгана, чамайг Хөвсгөлд гишгэх газаргүй болгоно, ар гэрийг чинь газартай тэгшилнэ” гэх мэтээр тус сонины редакци, эрхлэгчийн гэр бүлийг хүртэл айлган заналхийлэх болжээ. “Гэр бүл, хамт олонд минь муу юм болох вий гэхээс би аиж байна. Бид хүчгүй. Гэхдээ үнэний төлөө би хэзээд явах болно” хэмээн Ю.Гэрэлтуяа хэлсэн юм.

УИХ-ын гишүүн Д.Арвин өөрийнх нь хувийн амьдралын тухай бичсэн “Монголчуудын амьдрал” сонины шинэ дугаарыг түгээлтийнх өмнө хураан авчээ. Тэрээр өөрийн бие хамгаалагч, цагдаа нарыг дагуулан “Монгол шуудан”, “Улаанбаатар шуудан” гэх мэт шуудан түгээх бүх компаниар орж сонинг хураасан байна. “Монгол шуудан” компанийн хэвлэл ялган боловсруулах тасгийн ээлжийн ахлагч Д.Оюунцэцэг “Тэр үед бүх сониноо боочихсон байсан учраас дахин задалж бооход хугацаа хэрэгтэй байсан. УИХ-ын гишүүнд энэ байдлыг хэлэхэд өглөө ирээд авъя гэсэн. Тэгээд өглөө нь 4927 ширхэг сонинг аваад явсан” гэж “Зууны мэдээ” сонины №79-д ярилцлага өгөхдөө хэлжээ.

УИХ-ын гишүүн Д.Арвин руу 2006 оны 3-р сарын 29-30-нд шилжих шөнө нэгэн танил нь гурав, дөрвөн удаа утасдаж, “Таны хувийн амьдралтай холбоотой нийтлэл “Монголчуудын амьдрал” сонинд нийтлэгдэх гэж байна. Та энэ сонинг тараалгахгүй байх талаар яаралтай арга хэмжээ авах нь зүйтэй” гэж зөвлөөд нийтлэлийн агуулгыг нь нэгд нэгэнгүй уншиж өгчээ. Уг нийтлэлд “хоёр жилийн өмнө эхнэр нь нас барсан Хэнтий аймгийн нийгмийн бодлогын хэлтсийн дарга асан Эрдэнэтөгстэй УИХ-ын гишүүн Д.Арвин хамт амьдарч байна” гэж бичжээ.

УИХ-ын гишүүн Д.Арвин хурааж авсан сониноо 2006 оны гуравдугаар сарын 31-ны өдөр шуудан компаниудад тоо ёсоор нь хүлээлгэж өгсөн байна.

Үүнийгээ Д.Арвин тайлбарлахдаа “Тэр үед маш их бухимдсан. Миний тухай сонин хэвлэлүүд янз бүрээр л бичдэг. Тэр бүхнийг би маш их тэвчдэг боловч энэ удаа миний хувийн амьдралд дэндүү эрээ цээргүй халдсан учраас тэвчээр алдагдсан. Тэгээд ч шөнө дунд байсан тул хэнтэй ч зөвлөж асуух боломж байгаагүй. Дараа нь би бодсон л доо. Өөрийнхөө эрх ашгийг нэгдүгээрт тавиад бусдын хэргийг хоёрдугаарт үзэх шалтгаан надад байхгүй. Сониноос гадна шуудан компанийн ажил гэж байна, түүнийг хүндэтгэх ёстой гэж бодоод хурааж авсан сониноо тоо ёсоор нь хүлээлгэн өгсөн. Харин уг нийтлэлийг олон нийтэд түгээсэн сонинг шүүхэд өгөөд байгаа” гэж хэллээ.

Сүхбаатарын талбайд 2006 оны 4-р сарын 5-наас эхлэн эсэргүүцлийн суулт хийж байсан иргэний нийгмийн хөдөлгөөний төлөөлөгчид, САПУ худалдааны төвд гарсан түймэрт эд хөрөнгөө алдсан хохирогч нарын өлсгөлөнд оролцогсдыг 2006 оны 5-р сарын 8-ны үүрээр 4 цаг 45 минутад цагдаагийн хүчээр тараажээ.

Үйл ажиллагааг сурвалжлахаар очсон Ийгль телевизийн сурвалжлах хэсгийнхнээс хамгаалалтад зогсч байсан цагдаагийн ажилтнууд “Зөвшөөрлийн бичиг авчир” хэмээн нэхжээ. Сэтгүүлч М.Батдорж “Бидэнд зөвшөөрөл авч байх цаг алга. Ер нь Сүхбаатарын талбайд сурвалжлага хийхэд ямарч зөвшөөрөл авах ёсгүй” гээд нэвтрэх гэтэл цагдаагийн ажилтнууд хориглож, ноцолджээ. Энэ завсар Ийгль телевизийнхэн нэг камераа дотогш оруулж амжсан бөгөөд нөгөө камераа оруулах гэж оролдох үеэр камер нь цохигдож эвдэрсэн байна. Хамгаалалтын цагдаа сэтгүүлч М.Батдоржийг заамдаж аваад хамгаалалтын бүсийн гадна гаргах гэж оролджээ. Мөн дотогш нэвтэрсэн сурвалжлагчийг зураг авахуулахгүй гэж энгийн хувцастай цагдаагийн ажилтнууд дөрөв, таваараа өмнө нь эгнэн зогсож камерийг нь халхалж, дуранг нь алгаараа хааж, арагш нь хүчтэй түлхэж байжээ. Сурвалжлага авахад яагаад саад учруулаад байгааг тодруулахыг хүсч цагдаагийн удирдах ажилтанд хандсан сэтгүүлч Т.Оргилыг цагдаагийн бусад ажилтнууд “Чи ямар санаатай цагдаатай маргалдах гээд байна вэ?” гэж өдөөн хатгасан үгсийг хэлж байжээ. Тэнд байсан дээд тушаалын офицерүүд ямарч тайлбар өгөхгүй булзааруулж, асуулт асуусан сэтгүүлчийн микрофоныг гараараа түлхэн зайлцуулж байсан байна.

Хэнтий аймгийн “Дөлгөөн Хэрлэн” олон нийтийн радиогийн захирал сэтгүүлч Б.Адъяахүү, Хэнтий аймгийн захиргааны хэргийн шүүхийн ажлын талаарх нэвтрүүлэг бэлтгэхдээ, түүн дотроо нэгэн нас барсан иргэний эзэмшилийн үл хөдлөх хөрөнгийг дамжуулан наймаалцсан хэргийг жишээ болгон авч нэвтрүүлсэнтэй нь холбогдуулан түүнийг тус аймгийн Өлзийт тосгоны “Чандаган” компанийн захирал Ш.Жамъяндорж гар утсанд нь залган загнаж, “шүүхэд өгнө” хэмээн сүрдүүлсэн байна.

2006 оны 4-р сарын 19-ний өдөр МҮОНТ-ийн ММ агентлагийн сурвалжлагч Ш.Ариунцэцэг, зураглаач Г.Дэлгэр нар халдлагад өртжээ. Тэд “Эрүүл нийгэм-иргэний хөдөлгөөн”, “Эрс шинэчлэл” хөдөлгөөн, “Монголын газар шороо” зэрэг иргэний хөдөлгөөнийхөн жагсаал цуглаан зохион байгуулахдаа оюутнуудыг мөнгөөр хөлсөлж оролцуулж байгаа тухай сурвалжилж байжээ. Тэднийг 1000 оюутны байрны гадаа зураг авах үед,

оюутнууд эсэргүүцэж, 15000 ам.долларын үнэтэй телевизийн камерыг эвдсэн байна. “Бид зарим нэг оюутнаас ярилцлага авсан. Нэрээ хэлэхийг хүсээгүй ч 5000 төгрөг авч жагсаалд оролцож байгаагаа бидэнд хэлсэн оюутны ярилцлагын дүрс бий. Автобус дотор сууж байсан оюутнуудын зургийт авах үед тэд дургүйцэж, камерыг булаан авахаар манай зураглаачийг тал талаас бүчин ноцолдсоор камерыг эвдэж хаясан юм. Мөн энэ үеэр сурвалжлага хийхээр очсон UBS телевизийн сурвалжлах хэсгийнхэн сурвалжлагч, зураглаач, жолооч З залуу уг байдлыг хараад камераа машинд үлдээн гартаа чулуу барьж, манай зураглаач бид хоёрыг хамгаалахаар гүйж ирснээр хөөрсөн оюутнууд биднийг орхисон юм. Бид цагдаагийн газарт буруутай эзнийг олж, хохирлыг барагдуулж өгөхийг хүссэн өргөдөл бичиж өгсөн байгаа” гэж сурвалжлагч Ш.Ариунцэцэг “Глоб Интернэшнл” ТББ-ын хуульчид ярив.

“Өдрийн сонин”-ы сурвалжлагчдыг цагдаа нар жагсаал цуглаан албадан тараах үедээ хууль бусаар баривчлан цагдаагийн хэлтэст аваачсан байна. Монголын чөлөөт ахмадын холбооны тэргүүн Г.Баасанг суллахыг шаардаж иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид 2006 оны аравдугаар сарын 26-ны өдрийн 13 цаг 30 минутаас Улаанбаатар хотын төв гудамжны замын хөдөлгөөнийг хааж гэр барьж жагсаал цуглаан хийжээ. Хууль хяналтын байгууллагынхан жагсаал цуглаан зохион байгуулагчдыг тараахыг удаа дараа шаардсан боловч биелүүлээгүй тул мөн өдрийн шөнө буюу 2006 оны аравдугаар сарын 26-27-нд шилжих шөнийн 00.50 минутаас цагдаагийн албан хаагчид албадан тараажээ.

Энэ үйл явцыг сурвалжлахаар албан үүргээ гүйцэтгэж явсан “Өдрийн сонин”-ны сурвалжлагч Г.Эрдэнэбат, Б.Хажидмаа, фото зургийн сурвалжлагч Я.Аранжинбаатар, “Ардын эрх” сонины фото зургийн сурвалжлагч Ш.Гэрэлсайхан нарын 5 сэтгүүлчийг хууль бусаар баривчлан саатуулжээ. Цагдаа нар сэтгүүлчдэд ажил үүргээ тайлбарлах зав өгөлгүйгээр жагсагчидтай хамт хоморголон баривчлахдаа хүч хэрэглэж, зодож занчин, аппарат хэрэгсэлийг нь эвдэн сүйтгэж, бичиг баримтыг нь хураан авчээ. Тэд нарыг хоёр цагийн турш хорьж байгаад суллан тавьжээ. Энэ тухай “Өдрийн сонин”-ны сурвалжлагч Г.Эрдэнэбат хэлэхдээ “Биднээс цагдаагийн нэг ч албан хаагч үнэмлэх бичиг баримтаа үзүүлэхийг шаардаагүй. Харин ч гаргаад үзүүлсэн бичиг баримтыг маань үл тоомсорлон авч хаяад, аппарат хэрэгслийг хураан авах гэж ноцолдож байгаад эвдэн сүйтгэсэн. Дараа нь биднийг жижиг оврын машинд чихэж авч явсан. Манай сонины эмэгтэй сурвалжлагч Б.Хажидмааг бороохойгоор зодож занчин нүүр ам биенд гэмтэл учруулсан” гэв. Цагдаагийн ерөнхий газрын Олон нийттэй харилцах хэлтсийн дарга хурандаа А.Даваахүү хэлэхдээ “Жагсаал цуглааныг хууль журмын дагуу тараасан. Ямар нэгэн хүч хэрэглэсэн зүйл байхгүй. Сэтгүүлчдийг хоморголон баривчилсан тал бий. Гэхдээ жагсагчдаас тэднийг тэр болгон яж ялгаж таних юм бэ? Ямар тэдний духран дээрээ сэтгүүлч гээд бичихсэн байгаа биш” гэж хэллээ.

### **3.2 Мэдээлэл өгөхөөс татгалзах нь**

Төр нь иргэндээ үйлчилдэг, иргэнийхээ эрхийг хүндэтгэдэг ардчилсан нийгэмд төр, түүний байгууллагын үйл ажиллагаа, баримт бичиг мэдээлэл олон түмэнд нээлттэй, ил тод байх учиртай. Монголд мэдээллийн эрх чөлөөг зохицуулсан тусгай хууль байхгүй ч иргэд Үндсэн Хуулиар баталгаажсан мэдээлэл олж авах, хайх, хүлээн авах, түгээх эрх, эрх чөлөөгөө чөлөөтэй эдлэх ёстой.

“Мэдээллийн эрх чөлөө нь хүний язгуур эрх бөгөөд...НҮБ-аас эрхэмлэдэг хүний бусад эрхийн үндсэн хэмжүүр мөн” хэмээн НҮБ-ын Ерөнхий ассемблейн анхдугаар чуулга уулзалтын 59-р тогтоолоор тунхагласан байдаг.

Олон нийтийн мэдээлэлтэй байх эрхийг хангадаг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчид мэдээлэл олж авахдаа байнга бэрхшээлтэй тулгарч байна. Төрийн байгууллагын албан тушаалтан, албан хаагчид олон нийтийн санаа зовж буй, тэдний ашиг сонирхолд нийцэж буй мэдээллийг сэтгүүлчдэд өгөхөөс татгалзах нь манай оронд түгээмэл, хэвийн үзэгдэл болжээ.

### Үндэсний татварын ерөнхий газар мэдээлэл өгөхөөс татгалзав

Сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр хадгаламжийн банкны хувьчлалын талаар янз бүрийн мэдээлэл цацагдаж буй. Түүнчлэн тус банкны улсын төсөвт төлсөн татварын хэмжээ буурсан гэх болсон билээ.

Эдгээр мэдээллийн үнэн бодитой эсэхийг тодруулахаар үндэсний татварын ерөнхий газрын мэдээлэл боловсруулалт, автоматжуулалтын хэлтсийн байцаагч Б.Батгэрэлтэй уулзаж хадгаламжийн банкны 2003-2005 онд улсад төлсөн татварын талаархи мэдээлэл авахыг хүссэн боловч татгалзсан хариу сонслоо. Хүсэлтээ албан бичгээр гаргах лүндэн буулгасныг ёсоор болговол”Манай даргаар гарын үсэг зуруулаад ир. Тэгвэл мэдээлэл өгнө” гэв. Улсын нууцад үл хамаарах хамгийн энгийн баримтыг журмын дагуу хүсээд тусыг эс олов. ҮТЕГ-ын удирдлага байгуулагадаа ийм хатуу дэг тогоосон хэрэг үү, эсвэл байцаагч Б.Батгэрэл хүнд суртал гаргаж байна уу?

Татварын газар мэдээлэл өгөхөөс татгалзсан

Эх сурвалж: “Өнөөдөр” сонин 2006.01.11 № 008

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Даштүдэв Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж, 2006 оны 6-р сарын 12-нд шалгалтын дүнг танилцуулах хурлын үеэр аймгийн радио, телевизийн хоёр сурвалжлагчийг хурлаас гаражыг шаардజээ.

Г.Даштүдэв шалгалтын дүнгийн зарим мэдээллийг нийтэд мэдээлэхгүй, нууц гэсэн нэрийдлээр Өвөрхангай аймгийн “Ноён-Уул” FM радиогийн сурвалжлагч С.Мөнхдалайгийн диктафоныг хоёр ч удаа унтрааж, хурлын явцыг сурвалжилж байсан аймгийн “Өвөрхангай” телевизийн сурвалжлагч

Г.Пунцагсүрэнг бичлэг хийлгүйгээр хуралд суух, эсвэл тэндээс гарахыг шаардсан байна. “Малчид малын хулгайчдын нэрийг хэлэхэд бэлэн байгаа тухай, мөн энэ хүмүүсийг илрүүлж хуулийн дагуу арга хэмжээ авах, Аймгийн цагдаагийн газрын бие бүрэлдэхүүн цаг хугацаандаа ирэхгүй хүлээлгэсэн зэрэг мэдээллийг Г.Даштүдэв нууц хэмээн тодорхойлжээ.

Өвөрхангай аймгийн төр захиргааны, олон нийтийн байгууллагын хуралд сэтгүүлчдийг оруулахгүй байх нь хэвийн үзэгдэл болжээ. 2005 оны 10-р сарын 22-ны өдөр Өвөрхангай аймгийн Засаг даргын Зөвлөл хуралдаж өвлийн бэлтгэл, цаг үеийн яаралтай ажлын талаар хэлэлцэхэд Засаг даргын орлогч Ч.Чинбат “Хурлын дараа мэдээлэл авч болно” гэж хэлээд сэтгүүлчдийг оруулаагүй байна. Үүнээс гурав хоногийн дараа уг хурлын талаар мэдээлэл авахыг хүссэн орон нутгийн радиогийн сурвалжлагчид Ч. Чинбат мөн “Даргад хянуулсны дараа хурлын протоколтой танилцаж болно” гэсэн хариулт өгчээ.

Дархан-Уул аймгийн “ОРХОН” радиогийн сурвалжлагч Т.Баярцогтыг 2006 оны 5-р сарын 24-нд, тус аймгийн Шарын гол сумын нутагт шохой боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг “Цавчирт” ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг сурвалжлахаар очиход нь менежер Ш.Мөнхцэцэг үйлдвэрлэлийн талбайдаа нэвтрэх зөвшөөрөл өгөлгүй буцаажээ. Гэтэл Улаанбаатараас очсон “ТВ-9” телевиз, “Зууны мэдээ” сонин, “МОНЦАМЭ” агентлаг, Дархан-Уул аймгийн “DBS”, “ЛХА” ТВ-ийн сурвалжлагчдад сурвалжлага хийх зөвшөөрөл олгожээ. “ОРХОН” радиогийн сурвалжлагч Т.Баярцогт нь бүрэн хүчинтэй сурвалжлах эрхийн үнэмлэхтэй байсан атал ялгаварлан үзсэн байна.

2005 оны 8-р сарын 19, 20-ны өдрүүдэд “ОРХОН” радиогийн бэлтгэсэн “Байгальд халтай цагаан утaa” нэrtэй радио нэвтрүүлэгт “Цавчирт”, “Дар-Ман” зэрэг аж ахуйн нэгж шохой олборлож авч байгаа газартаа нөхөн сэргээлт хийлгүй, байгаль орчинд хор учруулж байгаа тухай байгаль орчны мэргэжилтнүүд, орон нутгийн иргэдийн ярилцлага орсон байна. Энэ сурвалжлагын мөрөөр Дархан-Уул аймгийн Байгаль Хамгаалах Албанаас дээрх байгууллагуудад 2005.09.20-нд хариуцлагын арга хэмжээ авч, 100 000 - 150 000 төгрөгийн тorgууль ногдуулжээ. “Сурвалжлага хийх боломж олгоогүй нь үүнтэй холбоотой” гэж сэтгүүлч Т.Баярцогт үзэж байна.

Өмнөговь аймгийн засаг дарга М.Ядмаа 2006 оны 7-р сарын 27-нд болсон Засаг даргын тамгын газрын хэлтсийн дарга нарын хурлыг “Алтан.gov” телевизийн зураглаач М.Шинэхүү сурвалжилж байх үеэр цаашид энэ телевизэд мэдээлэл өгөхгүй байх үүргийг газар, хэлтсийн дарга нартаа өгчээ. “Алтан.gov” телевиз 2006 оны 7 сарын 26-ны өдөр тус аймагт махны үнэ хэт өсч байгаа тухай мэдээлэхдээ махны худалдагч Долгорын “Аймгийн засаг дарга өөрийн ах дүү нартаа мөнгө гарган өгч өөр аймгуудаас мах авчирч заруулсан” гэсэн утгатай ярилцлагыг оруулжээ. Энэ мэдээлэл ТВ-ээр цацагдсаны дараагийн өдөр аймгийн Засаг дарга М.Ядмаа тус телевизэд ярилцлага өгсөн махны худалдагч Долгорыг өрөөндөө дуудан, ярьсан зүйлдээ залруулга хийхгүй бол шүүхэд өгнө хэмээн хэлтсийн дарга нарынхаа хамтаар сүрдүүлжээ.

Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Н.Наранбаатар өнгөрсөн оны сүүлчээр Засгийн газрын хэрэг эрхлэх газраас Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг танилцуулах хурлаас сэтгүүлчдийг мөн хөөж гаргасан байна. Өмнө нь аймгийн засаг дарга байсан

С.Цэрэнбаяр “Алтанговь” телевизийн сурвалжлагч Б. Түвшинжаргал, зураглаач Б.Батгэрэл нарыг хоёр ч удаа хөөж, сурвалжлах эрхийн үнэмлэхийг шаардан, “Танай телевизийг хаах талаар би холбогдох хүмүүстэй ярьж байгаа. Та нар намайг сурвалжлах эрх байхгүй” хэмээн сурдуулж байжээ.

### 3.3 Эх сурвалжаа илчлэхийг шаардах нь

Монголд шүүхээс өмнө, шүүх дээр сэтгүүлчдээс эх сурвалжаа илчлэхийг шаардах нь энгийн үзэгдэл юм. “Хэн энэ мэдээллийг өгсөн бэ?” гэдэг нь сэтгүүлчдийн бичсэн шүүмжлэлт материалд эмзэглэн гомдол мэдүүлэгч, түүнийг өмгөөлөгч, шүүгчдийн хамгийн эхний асуулт юм. Эх сурвалжаа илчлэхийг шаардаж буй хүмүүс гол төлөв цагдаа, шүүх, баривчлахаар айлгаж, сэтгүүлчдийг сүрдүүлдэг. Мэдээлэл өгсөн хүнийг яах ч үгүй хэмээн амлалт өгч, эх сурвалжийг нь хэлүүлсэн тохиолдол ч гарчээ. Шүүхээс өмнө ийм дарамтад өртсөн сэтгүүлчид энэ тухай мэдээлэхээс айж байна.

Өдөр тутмын “Монголын мэдээ” сонины сэтгүүлчийг хүн амины хэргийг илрүүлсэн аргыг бичсэний төлөө “хэнээс энэ мэдээллийг авсан хэлэхгүй бол 6 цаг хүртэл хугацаагаар албадан saatuuulna” гэж цагдаагийнхан сүрдүүлжээ.

Өдөр хоног дутмын “Үнэн” сонины сэтгүүлчийг Чингис хааны дурсгалын цогцолборын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтын эцсийн дүнг гараагүй байхад баримт сэлт нийтэлсэн хэмээн Тагнуулын Төв Газрын ажилтан дуудаж, эх сурвалжаа илчлэхийг шаардсан байна.

Чөлөөт сэтгүүлч, судлаач Д.Ганхуягийн эсрэг Монгол банкны захирал О.Чулуунбаатарын гомдолтой хэргийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, прокурор нь хэд хэдэн удаа “мэдээллийг хаанаас авсан, эх сурвалжаа бидэнд гаргаж өг” хэмээн шаардаж байсан нь хавтаст хэрэгт авагдсан материалуудад байна.

Дэлхий даяар сэтгүүлчид өөрсдөд нь нууц байдлаар мэдээлэл өгдөг хүмүүсийг хамгаалахыг эрмэлздэг. Ингэхдээ сэтгүүлчид өөртөө онцгой эрх, статус эрдэггүй. Үүнийгээ тэд олон нийттэй, сэтгүүлчидтэй ярилцсаныхаа төлөө ноцтой үр дагавар бүхий эрсдэлтэй тулгарч буй тэр мэдээлэгчийн өмнө хүлээсэн үүрэг гэж үздэг. Ингэхгүй бол мэдээлэл нууц болж, ямагт мэдээлэл хүсдэг олон нийтийн хэрэгцээг хангаж чадахаа болино. Хэрэв нэг л мэдээлэгчийн нууц байдал алдагдвал чухал мэдээлэлтэй өөр бусад хүмүүс сэтгүүлчдэд хандахыг хүсэхээ болино.

Эх сурвалж, мэдээлэгч, “шүгэлдэгч”-ийн хувьд энэ нь түүний эрх гэдэг нь ойлгомжтой. Үүний анхны шалгуур нь энэ эрхийг нийгэм, хууль хэрхэн хүлээн зөвшөөрснөөр хэмжигдэнэ.

Шүүх, цагдаа, тагнуул зэрэг хүчний байгууллагын нэг хэсэг мэт ажиллахыг албадаж, нууцаа задлахыг, эсвэл тэднээс бичиг баримт, дүрс бичлэг зэрэг бусад хэлбэрийн нотолгоо шаардаж эхэлбэл сэтгүүлчид хараат бус байж үл чадна. Энэ нь сэтгүүлчдэд ноцтой аюул учруулна. Зарим мэдээлэгч тухайн сэтгүүлчийг үнэхээр хараат бус гэдгийг мэдсэн тохиолдолд л мэдээллийг дамжуулахыг

хүсдэг. Энэ нь үнэн мэдээллийг түгээх үүрэг бүхий сэтгүүлчдийн хариуцлагыг улам ач холбогдолтой болгож байгаа юм.

1987 оны 1-р сард батлагдсан “Хэвлэлийн эрх чөлөөний Харти”-н заалтууд чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийг дэмжихэд зайлшгүй зарчмуудыг агуулсан, хамгийн өргөн хүрээтэй хүлээн зөвшөөрсөн бичиг баримт юм. Хартийн 2-р заалтад: “Сэтгүүлчдийг нууц эх сурвалжаа хамгаалах эрхээр хангасан байх ёстой. Сэтгүүлчдийг нууц эх сурвалжаа хамгаалах, мэдээлэгчийг хамгаалах хууль байхгүй ч үүнийг сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн зарчим, олон улсын хэм хэмжээгээр зохицуулж өгвөл зохино” гэжээ. Манай сэтгүүлчдийн ёс зүйн зарчимд үүнийг баталгаажуулсан тухай өмнөх бүлэгт өгүүлсэн. Гэсэн хэдий ч сэтгүүлчдийг эх сурвалжаа илчлэхийг шаардаар байгаа нь тэднийг ёс зүйгээ зөрчихийг албадаж буй хамгийн бүдүүлэг үйлдэл юм.

### **3.4 Сэтгүүлчийн хувийн аюулгүй байдал**

Монголд сэтгүүлчдийн биеийн эрх чөлөөнд халдаж, эрүүл мэндийг хохироо явдал гарч байгаа нь сэтгэл түгшүүлж байна. Сэтгүүлчид цаашдын муу үр дагавраас аиж, энэ тухай олон нийтэд мэдээлэл түгээхийг зөвшөөрөхгүй байгаа нь бүр аюултай. Тухайлбал, орон нутгийн нэг сонинд ажилладаг сэтгүүлч Н... 2006 оны 2-р сарын 22-нд ээлжит сурвалжлагаа хийж явах үед нь шөнийн 23.50 цагт үл таних гурван залуу барьж авч хоолойг нь боомилон элэг рүү нь цохиж унагаад, өшиглөн зодож, фото зургийн аппаратыг нь эвдлэн зургийн хальсыг нь сугалж аваад зугтан зайлсан байна. Зодуулсан сэтгүүлч ухаан алдаж унажээ. Хэсэг хугацааны дараа тэрээр ухаан орж, гэртээ ирсэн байна.

Сэтгүүлч энэ халдлагын тухай Цагдаагийн Газарт 2006.02.23-ны өглөө эрт 8.20 цагт мэдэгдсэн боловч, зодсон этгээдүүд одоо болтол хэн болох нь тогтоогдоогүй байна. Сэтгүүлч мөн өдөр эмнэлэгт үзүүлэхэд, элэг бөөрний хүнд хэлбэрийн доргилттой гэсэн онош тавигдсан байна. “Харанхуй шөнө байсан учраас намайг зодсон хүмүүсийг таних боломж гараагүй” гэжээ.

2005 оны 2005 оны 12-р сарын 19-нөөс 20-нд шилжих шөнө Улаанбаатарт телевизийн сэтгүүлч Г.Батжавын хувийн автомашинруу гэрийнх нь гадаа байхад халдаж, цонхыг хагалж, толийг мулталж, доторх эд ангийг эвдэж сүйтгэжээ. Харин ямар нэгэн эд зүйлс аваагүй байна. Үүний өмнө 2005 оны 11-р сарын 9-ний өдөр Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн нутагт орших жижиг зоогийн газарт сэтгүүлч Г.Батжавыг үдийнхээ цайг уухаар сууж байхад үл таних гурван залуу орж ирээд нэг нь хоолойг нь боож, нөгөө нь элэг рүү нь цохиж, гурав дахь нь үүдэн шүдийг нь мултартал цохижээ. Сэтгүүлч Г.Батжав халдалгад өртөхөөс өмнө Нийгмийн даатгалын ерөнхий газар, Улсын татварын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газруудтай холбоо бүхий ноцтой баримтууд дээр тулгуурлан өөрийн ажилладаг “Ийгль” телевизээр эрэн сурвалжлах чиглэлийн цуврал нэвтрүүлэг бэлтгэн гаргахаар хоёр сарын турш ажиллаж байсан юм.

Энэ хэрэгт хийсэн манай хуульчийн судалгааг хавсралт №7-аас үзнэ  
үү.

Орхон аймгийн “Номин” телевизийн редактор, сурвалжлагч Б.Цэвэгмид 2006 оны 07-р сарын 7-ны орой, 23.30 цагийн үед байрныхаа орцонд үл таних хүмүүст зодуулжээ. Түүнийг төмөр трубагаар нуруу, цээжруү нь цохиод зугтан зайлжээ. Б.Цэвэгмидийн нэг хавирга нь хугарч, тархи нь доргисон байна.

Энэ хэрэгт хийсэн манай хуульчдын хийсэн судалгааг хавсралт №8-аас үзнэ үү.

Дархан-Уул аймгийн “Долоо хоног Дархан” сонины сурвалжлагч Т.Баясгаланг 2006 оны 9-р сарын 28-нд, Дархан сумын төв захын “Тун” хоршооны түрээсийн лангуун дээрх самрын наймааны талаар сурвалжлага хийх үеэр, тус хоршооны ажилчин В.Сандагдорж сурвалжлагчийн эрх чөлөөнд нь халдан, 20 гаруй минутын хугацаагаар барьж saatулжээ.

Сурвалжлагч нь түүнээс “Ойгоос самар түүх зөвшөөрлийг чинь үзэж болох уу?” хэмээн асууж, “Фургон” машинд ачиж авчирсан самар нь хэдий хэмжээтэйг нь нүдээр харья гэхэд В.Сандагдорж дургүйцэн татгалзаж, “Чи үзэх эрхгүй. Энэ бол манай байгууллагын нууц” хэмээн түүний хоёр гарыг мушгин ард нь барьж, энэ хооронд бусад хүмүүс нь, бүх самраа машиндаа ачин зугтаасан байна.

Сурвалжлагч Т.Баясгалангийн сурвалжлах эрхийн үнэмлэх нь ямар ч зөрчилгүй, эрхийн хугацаа нь бүрэн хүчинтэй байжээ.

Бидэнд мэдэгдсэн тохиолдлын аль нь ч өнөө хэр хуулийн байгууллагаар эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа нь сэтгүүлчдийн аюулгүй байдал ноцтой зөрчигдөж байгаагийн илрэл төдийгүй чөлөөт хэвлэлийг эсэргүүцэгчдийг улам өөгшүүлж, гааруулах нь мэдээж билээ. Нийгмийн сөрөг үзэгдэл, бузар бурай, буруу үйлдэл, гэмт хэргийг эрэн сурвалжилж мэдээлснийхээ төлөө сэтгүүлч амь бие, эрүүл мэндээр хэрхэвч хохирох ёсгүй билээ.

### **3.5 Хэвлэл мэдээллийн өмчлөл**

Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн 4-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар төрөөс олон нийтийн мэдээллийн хэрэгсэл өмчлөхийг хориглосон. Энэ хуулиас хойш Засгийн газрын мэдэлд хэвээр үлдсэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл бол мэдээллийн МОНЦАМЭ агентлаг юм. 1998 оны 8-р сарын 28-ны өдөр баталсан УИХ-ын 103 тоот тогтоолд МОНЦАМЭ агентлагийг татан буулгаж, Үндэсний нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болгон өөрчлөн зохион байгуулахаар заажээ.

2005 оны 12-р сарын 15-нд болсон Монгол Улсын Засгийн газрын ээлжит хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд ажиллаж буй Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг МОНЦАМЭ-г Гадаад хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд харьялануулж, одоогийн орон тоо, зардлын хамт шилжүүлэн Гадаад Хэргийн яамны дэргэдэх Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгон өөрчлөх саналыг дэмжиж, Улсын Их хурлаар хэлэлцүүлэхээр тогтжээ.

Гадаад хэргийн Яамны хэвлэл мэдээллийн хэлтсийн дарга Б.Дорж “Монгол Улсын гадаад сурталчилгаа, мэдээллийн ажлыг эрчимжүүлэх, гадаад сурталчилгааг нэгдсэн бодлоготой явуулахдаа МОНЦАМЭ агентлагийн хүчийг ашиглах нь зүйтэй гэсэн байр суурийг Гадаад Хэргийн яам барьж байгаа юм. 2002 оноос хойш уг агентлагийн ерөнхий захирал томилогдоогүй, энэ хугацаанд үүрэг гүйцэтгэгч энэ байгууллагыг удирдаж байсан ч нийтлэлийн бодлого нь алдагдаж ирсэн тул ийм шийдвэр гаргахад хүрсэн” гэж хэлсэн юм.

МОНЦАМЭ агентлагийн статусын асуудлын талаар өнөө хэр ямар нэг шийдвэр гараагүй байна.

Хэвлэлийн Хүрээлэнгийн судалгааны дагуу 2005 оны эцсээр Монголд нийт 325 хэвлэл мэдээллийн хэрэгсэл тогтмол үйл ажиллагаа явуулж байв. Өнөөдрийн байдлаар гэхэд зөвхөн Улаанбаатар хотод өдөр дутмын 9 сонин хэвлэгдэж, телевизийн 10 суваг ажиллаж байна. Хамгийн отгон телевиз болох NTV 2006 оны 9-р сарын 27-нд туршилтийн нэвтрүүлгээ эхэлсэн байна.

Монгол Улсад хэвлэл мэдээллийн өмчлөлийг зохицуулсан ямар нэг хууль тогтоомж байхгүй. Шинээр бий болсон ХМХ-ийн цаана нөлөө бүхий улс төрч, бизнес эрхлэгчид байгаа тухай олон нийтийн дунд янз бүрийн таавар байдаг.

#### Ц.Нямдорж

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл үрүү сарвуугаа хэт шургуулж байгаа нөхдийг би ойлгодоггүй. Шинэ телевизүүдийн ард дандаа улс төрчид байдаг юм билээ. Хувийнхаа нөлөөг нийгэмд хэвлэл мэдээллээр дамжуулан тогтоох гэж байгаа бол утгагүй хэрэг. Монголд хувийн 3-4 телевиз байхад л хангалттай. Хятадад 5-6 л байдаг шүү дээ

Эх сурвалж: “Өнөөдөр” сонин, №228(2882), 2006.09.29

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өмчилдөг тухайгаа ил тод зарласан хүн одоохондоо Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өөр байхгүй.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н. Энхбаярын ярицлагаас:  
Сэтгүүлч: -ТВ-9-ийн талаар асуумаар байна. МАХН, Гандантэгчинлэн хийдийн дунд өгсөн телевизийн студийг та Д.Чойжамц хамбад 60 сая төгрөг төлөөд хувьдаа авсан гэдэг гомдол байдаг?

Н. Энхбаяр: - Иймэрхүү юм ярихад гоё биш байна. Гэхдээ үнэнийг тайлбарлах ёстой. Би багаасаа буддын шашныг биширч, 1982 онд лам багштай болсон. “Ийгл” телевиз байгуулагдаж Ийсусийн ном гарч эхлэхэд л Д.Чойжамц хамба нартай Буддыг өгүүлэх телевизийн тухай ярилцдаг байлаа. Японы Агун шв гэдэг шашны байгууллага хамба бид хоёрыг буддын шашны ёслолд урихдаа телевизийн студи бэлэглэсэн юм. Тэгэхдээ “Н.Энхбаяр, Д.Чойжамц гэдэг хоёр хувь хүнд өгч байгаа юм шв” гэсэн. Ингээд л бид хоёр 110 мянган долларын тоног төхөөрөмжтэй Монголдоо ирдэг юм байна.

Гандангийнх ч биш, МАХН-ынх ч биш. Шууд телевиз байгуулчихъя гэтэл

суваг олдож өгөхгүй, хэцүү байсан. Студийнхээ техникийг нэг хэсэг Бэтүб хийдэд, дараа нь МАХН-ын байранд хадгаллаа. Сонгуулийн үеэр намын нөхөд сурталчилгаанд ашиглая гэж камер гүйна, өгөхгүй. Би япончуудад амласан болохоор чадаагүй. Тэгж байтал нэг өдөр Ц.Мөнх-Оргил “Надад суваг, танд студи байгаа шүү дээ” гэдэг юм. Тэгээд л ТВ-9 байгуулагдсан хэрэг.

Бид Чойжамц, Амгалан хамба нарын дунд 60 гаруй сая төгрөг ёслол төгөлдөр өгсөн. Би өмнө нь хамбад наргиан болгож “Студи маань 100 мянган доллар байх аа” гэхээр Д.Чойжамц гуй “Яалаа гэж дээ, 110 мянга шүү дээ” гэнэ. Ой сайтай хүн л дээ, ийм байж номоо цээжилдэг байлгүй. Хамба мөнгөө сумийн барилгын эх уусвэрт зарцуулна гэсэн.

ТВ-9-өөр Чойжамц хамба дуртай цагтаа гардаг гэж сонссон. Би узэж амждаггүй юм. Ц.Энхбат захирал сайн ажиллуулж байгаа гэдэг. Зарим улстөрч “Танайх МАХН-ыг алж байна аа” гэж утасдах нь ч бий. Би телевизийн ажилд оролцож чаддаггүй ээ.

**“Өнөөдөр” сонини 2006 оны 5-р сарын 5-ны 104(2758)**

Монголд үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай цорын ганц хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь АНУ-ын И-Би-Си буюу Ийгл телевиз юм. Хоёр жил завсарласны дараа 2004 онд үйл ажиллагаа сэргээсэн Ийгл телевиз мэдээллийн дагнасан суваг юм. Сүүлийн үед Монголд идэвхтэй өrnөж буй иргэдийн тэмцлийг өргөн сурвалжилж, үзэгчдийн санаа бодлыг шууд нэвтрүүлдэг.

“Монгол улсыг хагалан бутлах зар сурталчилгаа явуулдаг гадаадын хөрөнгө оруулалттай мэдээллийн хэрэгсэл байж болно гэж үү? ....Юм бүхэнд тодорхой хил хязгаар байх ёстой” гэж УИХ-ын дарга Ц.Нямдорж өнгөрсөн хаврын чуулган дээр хэлсэнийг телевизийн удирдлага түгшин хүлээн авсан.

Ноён Ц.Нямдоржийн хийсэн мэдэгдлийн дараа Монголын хэвлэлийн хүрээлэнгээс 2006 оны 6 сарын байдлаар телевиз үзэгчдийн дунд хийсэн судалгааны тайлан гарчээ. Ийгл телевиз нь даваа гаригаас баасан гариг хүртэл хамгийн их үзэгчидтэй телевиз, мөн хамгийн ойр өрсөлдөгчөөсөө хоёр дахин илүү их үзэгчидтэй телевизээр шалгарсан юм.

Дэлгэрэнгүйг <http://terrycom.net> сайтаас авч болно.

### **3.6 Гүтгэлэг, нэр төр, доромжлолтой холбоотой хуулийг ашиглаж буй нь**

Сэтгүүлчид нэр төр, алдар хүнд, доромжлол, гүтгэлэгтэй холбоотой хэрэгт байнга холбогддог.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын хуульчдын хийсэн судалгаагаар 2001-2005 онд гүтгэлэг, нэр төр, доромжлолтой холбоотой 187 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Үүнээс 178 нь иргэний, 9 нь эрүүгийн хэрэг

байжээ. Хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн эсрэг хэрэг 151 байснаас 146 нь иргэний, 5 нь эрүүгийн хэрэг байна.

Эдгээр хэргийн 92 буюу 59.6 хувь нь улс төрч, өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллагын нэхэмжлэлээр шийдвэрлэгджээ.

Иргэний хэргийн 45 нь олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, тэдний санааг зовоосон асуудлаар, 32 нь улс төрч, албан тушаалтан, албан хаагчдын буруу үйлдэл, авилга, хээл хахуултай холбогдуулан, 10 нь тэдний хувийн амьдралын нь тухай бичиж нийтэлсэн материал байжээ.

Эрүүгийн 5 хэргийн дөрөвт нэхэмжлэгч нь УИХ-ын гишүүн байна. Шүүхийн шийдвэрээр хоёр эмэгтэй сэтгүүлч 23 хоногоос 6 сарын баривчлах ялаар шийтгүүлсэн юм.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн 9.6 хувьд хэвлэл мэдээллийн хэрэгсэл ялсан бол 59.6 хувьд ялагдсан байна. 31.5 хувьд нэхэмжлэгч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл хоорондоо эвлэрчээ.

Баянзүрх дүүргийн шүүхийн 2006 оны 9-р сарын 28-ны өдрийн шүүх хурлын шийдвэрээр сэтгүүлч Г.Дашрэнцэн ноён Ш.Адьшаа 300 мянган төгрөг/ 260 орчим ам.доллар/ төлөх, мөн сонинд залруулга гаргах шийтгэл хүлээсэн байна.

Харин Баянзүрх дүүргийн шүүхийн шийдвэрээр нэр төрөө сэргээсэн гаалийн ажилтан Ш.Адьшаа дээрх явдлаас хойш тун удалгүй Мөрдөн байцаах газраас явуулсан мөрдөн шалгах ажиллагааны дүнд баривчлагдан улмаар авилгалын хэрэгт буруутгагдан шалгагдаж эхэлжээ. Энэ хэрэг одоогоор эцэслэн шийдэгдээгүй байна.

“Глоб Интернэшнл” ТББ нь бичиж нийтлүүлсэн зүйлийнхээ төлөө сэтгүүлчид Эрүүгийн хуулиар ял шийтгүүлэх ёсгүй хэмээн удаа дараа мэдэгдэж, байнга сануулдаг билээ.

Гүтгэлгийн хэргээр Эрүүгийн хуулиар ял шийтгүүлж, Өршөөлийн хуулиар ялаас чөлөөлөгдсөн хоёр сэтгүүлчийн хэргийн судалгааг хавсралтаас үзнэ үү.

Г. Дашрэнцэнгийн хэрэг. Хавсралт №

Д. Ганхуягийн хэрэг. Хавсралт №

Олон улс оронд хувь хүний нэр төрийг хамгаалах нь хувь хүнд чиглэгдсэн байдаг. Олон улсын хэм хэмжээ, эрх зүйгээр “Гүтгэлгийг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэх нь хүний нэр төрийг хамгаалахад онцын шаардлагагүй байдаг бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарладаг учраас хүлээн зөвшөөрөх боломжгүй” гэж үздэг. Олон улс оронд эрүүгийн хуулийн ийм заалтыг эрх мэдэлтэй албан тушаалтууд хүмүүсийн шүүмжлэлийг хорьж хязгаарлах, маргааныг таслан зогсоохын тулд буруугаар ашигладаг. Үүнийг хүлээн зөвшөөрсөний үндсэн дээр олон улсын шүүхүүд Засгийн газруудад хүний эрхийг хязгаарлахдаа эрүүгийн шийтгэл хүлээлгэхээс түдгэлзэхийг зөвлөсөн.

2000 оны 12-р сарын 1-нд НҮБ-ын тунхаг гаргаж, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн чөлөөт урсгал, санаа бодлын асуудал дэлхийн олон оронд хямралт байдалд байна. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний явцад нь сэтгүүлч, бусад хүмүүс рүү дайрч давшлах (цензурдэх), гутгэлэг, доромжлолын хатуу хуулиар хохигох гэсэн хоёр хэлбэрээр илэрч байна” гэсэн бөгөөд “Гишүүн орнууд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрхийг үл хязгаарлах байдлыг хангахын тулд гутгэлгийн эсрэг хуулиа эргэн нягталж, үүнийгээ олон улсын өмнө хүлээсэн үүрэгтээ нийцүүлэхийг” уриалсан байdag.

#### 4. Дүгнэлт

Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөөг хамгаалсан нааштай хууль тогтоомж байгаа хэдий ч амьдрал дээр хэвлэл мэдээллийн эрх чөлөө, сэтгүүлчдийн мэргэжлийн эрх зөрчигдсөөр байна. Сэтгүүлчийн мэргэжлийн эрх ийнхүү зөрчигдөх нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж, сэтгүүлчид үнэн мэдээлэл түгээж чадахгүйд хүрч, ардчилал, нийгмийн эрх ашигт бодитой хор хохирол учруулна.

Монгол Улсад цагдан хяналт (цензур)-ыг хуулиар хориглосон ч ил болон далд хэлбэрээр байсаар байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоож, сэтгүүлчдийн өөртөө үйлчлэхийг шаардах нь ардчиллын мөн чанар, хэм хэмжээ, зарчмаас гадуур үл тэвчиж болох үйлдэл юм.

Улс төрч, албан тушаалтан, албан хаагчид Эрүүгийн хууль, Иргэний хуулийн заалтуудыг цензур болгон ашиглах нь түгээмэл байна. Монголын шүүх нэр төр, гутгэлэгтэй холбоотой хэргийг шийдвэрлэхдээ олон нийтийн үнэн мэдээлэлтэй байх хууль ёсны эрх ашгийг нь авч үзэлгүй өрөөсгөл хандаж байгаа нь шүүхийн шударга, хараат бус байдалд эргэлзээ төрүүлж байна.

Эрх баригчид өөрийн эрх мэдэл, албан тушаалыг ашиглан шударга шүүмжлэлийг няцаах, өөрсдийн буруутай үйлдлийг ард иргэдээс нуун дарагдуулахын тулд үнэн мэдээллийг саармагжуулах нь нийгмийн эрх ашигт ноцтой хор учруулна.

Монголын сэтгүүлчид өнөө хэр төрийн байгууллага, албан тушаалтан, албан хаагчдаас мэдээлэл олж авч чадахгүй, төрийн байгууллагын бичиг баримтыг олж үзэх боломжгүй байгаа нь төрийн байгууллагын олон нийтэд ил тод, нээлттэй байх ёстой ардчилсан зарчим алдагдаж, иргэдийн үнэн мэдээлэл олж авах эрх хөсөрдөхөд хүргэж байна. Энгийн мэдээлэл олж авах төдийд эрх нь зөрчигдөж буй сэтгүүлчид далд нуугдмал буй мэдээлэл, баримт мэдээг эрэн сурвалжилж олон түмэнд мэдээлэхэд туйлын хүндрэлтэй байгааг илтгэж байна.

Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл нийтэд ил тод бус байгаа нь олон ургальч үзлийг хөхиүлэн дэмжих бус, харин тэдгээрийн далд эздийн үзэл бодол, нэг талыг барьж туйлширсан мэдээллээ олон түмэнд тулган нийгмийг төөрөгдүүлэн будлихад хүргэж байна. Монголын олон нийт хэн нь үнэн ярьж байгааг ойлгохоо байж, хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдэд итгэл алдрах нь нийгмийн шударга ёсыг уландаа гишгиж буй хэрэг юм.

Сэтгүүлчид янз бүрийн дарамт шахалт дор эх сурвалжаа илчлэх нь мэдээлэгчдийн аюулгүй байдалд ноцтой хор учруулах төдийгүй хэвлэл мэдээлэл ард иргэдийн өмнө хүлээсэн хяналтын үүргээ хөсөрдүүлэхэд хүргэнэ. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн ач холбогдол, үнэ цэнэ алга болбол нийгэм хэзээ ч цэвэршиж, ариусахгүй.

Үнэнийг хэлэх гэсэн, хэлснийх нь төлөө сэтгүүлчдийг дайрч давшлах, далайлган сүрдүүлэх, айлан занахийлэх, өмч хөрөнгө, бие эрхтэнд халдах нь хэрхэвч байж болохгүй ноцтой үйлдэл, гэмт хэрэг юм. Монголын цагдаа, шүүх буруутныг илрүүлэн үнэн мөнийг тогтоож, хариуцлага хүлээлгэх үүргээ зохих ёсоор биелүүлж чадахгүй байгаа нь харамсалтай.

## 5. Цаашид яах вэ?

Хэвлэлийн эрх чөлөө хэзээ ч зүгээр ирдэггүй. Үүнийг тэмцэж олдог.

Нэгдүгээрт, хэвлэл мэдээлэл сэтгүүлчдийн эсрэг аливаа дайралтыг илрүүлэн баримтжуулж, олон нийтэд ил тод мэдээлэх нь чухал. Бид гагцхүү иргэний нийгмийн байгууллага, олон нийт, хэвлэл мэдээллийн хамтын нягт харилцаа, тэмцлийн дунд ийм дайралтыг сөрөн зогсож чадна.

Хоёрдугаарт, сэтгүүлчид өөрийн эрх зөрчигдэж буйг далдан нууцлах нь үүнээс илүү уршигт үр дагавартайг ухамсарлан ойлгох нь чухал байна. Зөрчлийг илчилж байж нөхдийнхөө эрсдлийг бууруулна гэдгийг ойлгох нь зүйтэй.

Гуравдугаарт, сэтгүүлчид өөрсдийн эсрэг дайралтыг эсэргүүцэн хүчээ нэгтгэж, эв нэгдэлтэй тэмцэх нь чухал юм. Гагцхүү эв нэгдэл биднийг өөрийн хөдөлмөрлөж буй нөхцөл, улс төр, эдийн засаг, эрх зүйн орчинг таатай болгох, эрх баригчдын дайралтыг эсэргүүцэн тэмцэхэд голлох үүрэг гүйцэтгэнэ. Хэвлэлийн эрх чөлөө нь Монголд үйл ажиллагаа явуулж буй сэтгүүлчдийн, хэвлэн нийтлэгчдийн эвлэл холбоодын гол эрх ашиг байх ёстай.

Дөрөвдүгээрт, Монголд сэтгүүлчдийн эрх хэрхэн зөрчигдэж буйг дэлхий нийтэд мэдээлж, түгээх нь чухал. Гагцхүү дэлхийн хамтын нийгэмлэгийн дэмжлэг, донор, засгийн газар хоорондын, олон улсын хүний эрхийн байгууллагын хүчээр бид хэвлэлийн эрх чөлөөг илүү бодитой болгож чадна.

ОЛОН НИЙТИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН  
ШИЛЖИЛТИЙН ҮЙЛ ЯВЦ

Хавсралт №1

МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

## ОРШИЛ

Монгол Улсад олон нийтийн өргөн нэвтрүүлэг байгуулагдсан нь сүүлийн хоёр жил эрх баригчдаас үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, ялангуяа хэвлэлийн эрх чөлөөг бататгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн өндөр ач холбогдол бүхий чухал арга хэмжээ билээ.

Монгол Улс ардчиллын шилжилтийн эхний жилүүдэд олон нийтийн өргөн нэвтрүүлгийн мөн чанар, үзэл баримтлал, зарчимтай танил болсон юм. Энэ нь 15 жилийн турш хэвлэлийн эрх чөлөөг дэмжигч, хэвлэлийн мэдээллийн мэргэжилтэн, улс төрчдийн санаа зовоосон асуудал байв. Энэ хугацаанд Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, Засгийн газар, улс төрийн намууд хэд хэдэн төсөл боловсруулсан байлаа.

2004 оны УИХ-ын үр дүн нь улс төрчдийг олон нийтийн өргөн нэвтрүүлэг байгуулах талаар нэгдсэн ойлголцол, тохиролцоонд хүрэх нөхцөл байдлыг бий болгож, эрх зүйн орчинг бүрдүүлэх шийдвэр гарсан билээ.

“Глоб Интернэшнл”, Нээлттэй Нийгэм Форум, Хэвлэлийн Хүрээлэн зэрэг төрийн бус байгууллага Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн сүлжээ, ЮНЕСКО, Конрад Аденуэрын сан, Фридрих Эбертийн сан, олон улсын бусад байгууллагын дэмжлэгтэйгээр олон нийтийн өргөн нэвтрүүлгийн мөн чанар, үзэл баримтлал, зарчим, олон улсын хэмжээг түгээн дэлгэрүүлэх, зохих хууль тогтоомж боловсруулах, батлуулах, Үндэсний Зөвлөлийг бүрдүүлэх чиглэлээр идэвхтэй ажилласан юм. Тухайн үед төрийн мэдэлд байсан радио, телевизийн ажилтнууд ч дээрх хэлэлцүүлэгт үнэтэй хувь нэмэр оруулсан билээ. Олон нийтийн өргөн нэвтрүүлэг бол олон хүний хамтын үр дүн юм.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага хуулийн төсөл боловсруулах явцад мэргэжлийн зөвлөгөө өгсөн боловч бидний зарим санал, зөвлөмж, санамж хуульд тусгагдаагүйг бас тэмдэглэх нь зүйтэй.

Олон нийтийн өргөн нэвтрүүлэг нь мөн чанар, үзэл баримтлалаараа олон нийтэд зориулагдсан, олон нийтэд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ явуулж, тэдний ашиг сонирхолд нийцсэн хөтөлбөр нэвтрүүлэг бэлтгэн дамжуулах цорын ганц үүрэгтэй. Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үзэл баримтлал үндсэн зарчмуудаар тодорхойлогдоно. Үүнд:

- Олон нийтийн төлөөлөл бүхий удирдлагатай
- Олон нийтийн санхүүжилттэй
- Олон нийтийн хяналт дор үйл ажиллагаа явуулдаг.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 1-р зүйлд хуулийн зорилтыг “Монголын ард түмэнд үйлчлэх олон нийтийн радио, телевизийг үүсгэн байгуулж, түүний зорилго, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тогтоож, хөтөлбөрийн бодлогын үндсийг тодорхойлно” гэсэн байдаг.

### Зүйл 3.1

Олон нийтийн радио, телевиз энэ хуулийн дагуу байгуулагдаж, гагцхүү олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээд мөн.

### Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиас

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага Олон нийтийн радио, телевизийн тухай хууль хэрэгжихээс эхлэн шилжилтийн үйл явцыг анхааралтай ажиглан мониторинг хийж байлаа. Мониторинг нь Монголд олон нийтийн өргөн нэвтрүүлгийн шилжилтийн үйл явц хэрхэн өрнөж буйг хөндлөнгөөс ажиглан дүгнэлт өгөх зорилготой байв. Мониторинг хийхдээ бид шилжилтийн үйл явц олон нийтийн өргөн нэвтрүүлгийн мөн чанар, олон улсын хэм хэмжээ, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн үзэл баримтлал, зарчмуудыг удирдлага болгосон билээ. Мониторингийн явцад ярилцлага авах, хэсэгчилсэн уулзалт хийх, Үндэсний Зөвлөлийн хуралд оролцох, сонин хэвлэлд нийтлэгдсэн материалууд, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт, зохих хурлын тэмдэглэл, батлагдсан дүрэм, журам, гэрээ, албан бичиг баримтыг нягтлан дүгнэх зэрэг аргыг ашигласан болно. Олон нийтийн радио, телевизийн шилжилтийн үйл явцын тухай бид [www.globeinter.org.mn](http://www.globeinter.org.mn) and [www.monitoring.mn](http://www.monitoring.mn) вэб сайтаар байнга мэдээлж байлаа.

Бид мониторингийн үр дүнг нэгтгэсэн тайланг толилуулж байгаадаа баяртай байна. Тайланд шилжилтийн явцад Монголын үндэсний олон нийтийн радио, телевизэд болж буй хэрэг явдлын талаар олон нийтэд аль болох бодитой мэдээлэл өгөхийг зорьсон юм. Тайланг илүү бодитой болгохын тулд үнэтэй санал зөвлөгөө өгсөн хүмүүст талархал илэрхийлье

Энэ нь Нээлттэй Нийгэм Форум, ННХ-гийн Хэвлэл мэдээллийн бүсийн хөтөлбөрийн дэмжлэгээр хэрэгжүүлж буй үзэл бодлоо илэрхийлэх эрхийн зөрчилд хийж буй манай мониторингийн төслийн нэг хэсэг юм.

Тайлангийн I бүлэгт ерөнхий мэдээлэл өгч, II бүлэгт мониторингийн явцад илүү анхаарал татсан, шилжилтийн үеийн тулгамдсан бэрхшээлийн тухай өгүүлэв. III бүлэгт дүгнэлт, холбогдох газруудад хандсан зөвлөмжийг багтаасан болно.

Энэ тайлан Монголд олон нийтийн өргөн нэвтрүүлгийг жинхэнэ нь утгаар нь хөгжүүлэхэд цаашид хэрэгцээтэй, суурь баримт бичиг болбол бид баяртай байх болно.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага мониторинг хийх явцдаа 2005 оны 1-р сарын 11-нд тухайн үед үүсээд байсан хямралт байдлын талаар байр сууриа илэрхийлсэн Хэвлэлийн мэдэгдэл гаргаж, “Олон нийтийн радио, телевизийн тухай хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц ил тод байх тухай олонтаа сануулж байсан. Гэтэл одоогийн Үндэсний зөвлөлийн гишүүдийн 9-ийг Төрийн бус байгууллагуудын нэгдсэн чуулганаас санал болгосон хүмүүсээс сонгож, үлдсэн б хүний нэрийг ямар төрийн бус байгууллага, хэн санал болгож, ямар шалгуураар сонгож, нэр дэвшүүлсэн нь өнөө хэр тодорхой бус байна. Хоёрдугаарт, хуульд Үндэсний зөвлөлийн гишүүний сонирхлын зөрчлийн тухай заасан боловч хувийн радио эрхэлдэг хүн орсон байна. Ерөнхий захирлын сонгон шалгаруулалтыг зарлахдаа шалгуурт нь сонирхлын зөрчлийг хаах заалт оруулсан бол өнөөдөр ийм хямралт байдалд хүрэхгүй байсан байх. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй Үндэсний Зөвлөл өөрөө хуулиа зөрчихгүй байх, олон нийтийн хяналт дор үйл ажиллагаа явуулах ёстой Үндэсний зөвлөл яаралтай нээлттэй хурал хийж, тулгамдсан асуудлаа олон нийтийн өмнө шийдвэрлэх нь чухал ” гэсэн билээ.

## I. ТАНИЛЦУУЛГА

1998 оноос хойш долоон жил saatсаны эцэст Улсын Их Хурлаас 2005 оны 1-р сарын 17-ний өдөр Олон нийтийн радио, телевизийн (ОНРТ) тухай хууль батлан гаргав. 1998 оны 8-р сарын 28-ны “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх тухай” УИХ-ын 103 тоот тогтоолоор төрийн мэдлийн өргөн нэвтрүүлгийг олон нийтийн болгон өөрчлөн байгуулахаар заасан билээ.

ОНРТ-ийн тухай хууль 2005 оны 7-р сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн юм. Монголын Үндэсний Радио, Телевизийн Хэрэг эрхлэх газар татан буугдаж, оронд нь Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевиз (МООНРТ) байгуулагдан, 2006 оны 2-р сарын 8-ны өдөр Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамны Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.

### УИХ-ын дарга Ц.Нямдорж

...олон нийт, төр хоёр нэг ойлголттой байх ёстой. Монголын үндэсний радио, телевиз олон нийтийнх болсноор хэд хэдэн ажлын чанар сайжрах ёстой гэж ойлгогдож байгаа. Хуулийн үзэл санаа нь ч гарч байгаа шийдвэрийн үзэл санаа нь ч тийм юм. Нэгдүгээрт, радио нэвтрүүлгийн чанар, хараат бус байдал нь сайжрах ёстой, хоёрдугаарт, техник тоног төхөөрөмж нь сайжрах ёстой. Гуравдугаарт, ажиллаж байгаа хүмүүсийнх нь амьдрал ахуй дээшилсэн байх ёстой. Дөрөвдүгээрт, энэ байгууллага санхүүгийн хувьд одоо байгаагаас илүү сайжирсан байх ёстой гэдгийг хэлэх ёстой. Энэ гол чиглэлүүдэд хүсэн хүлээсэн өөрчлөлт гарах юм бол энэ хуулийн зорилт биелжээ гэж төр, олон

нийт үнэлэх ёстой гэдгийг хэлье.

2006 оны 10-р сарын 13-нд УИХ-ын чуулганы  
хуралдаан дээр хэлсэн угнээс

Шинээр байгуулагдсан ОНӨН-ийн удирдах байгууллага нь төрийн бус байгууллагуудыг төлөөлсөн 15 гишүүнтэй. Удирдах байгууллага нь Үндэсний Зөвлөл(ҮЗ) нэртэй, 2005 оны 10-р сарын 13-ний өдөр УИХ-аас томилогдсон байна. Дөрөв хоногийн дараа буюу 10-р сарын 17-нд ҮЗ анхныхаа түүхэн уулзалтыг хийж, МҮЭ-ийн ерөнхийлөгч, 2000-2004 онд МАХН-ыг төлөөлсөн УИХ-ын гишүүн байсан Н.Содномдоржийг даргаараа сонгожээ.

ОНРТ-ийн тухай хуулиар ҮЗ-ийн гишүүдийг төрийн бус байгууллагууд санал болгох ёстой. Төрийн бус 140 гаруй байгууллага зохион байгуулалтад орж, 2005 оны 7-р сарын 14-нд зохион байгуулсан ТББ-ын нэгдсэн чуулганаас 32 хүний нэрийг Еөнхийлөгч, УИХ, Засгийн газарт санал болгожээ.

#### Зүйл 21.6: Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, түүнийг томилох тухай

Үндэсний Зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар түүх уламжлал, ёс заншил, соёл урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчид, эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгал орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Улсын Их Хуралд, эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Засгийн Газарт тус тус санал болгоно.

#### ОНРТ-ийн тухай хуулиас

Хуулийн дагуу ТББ-ын санал болгосон хүнээс Ерөнхийлөгч 4, УИХ 7, Засгийн Газар 4 хүнийг сонгон УИХ-д нэр дэвшүүлэх эрхтэй. УИХ нь ҮЗ-ийг томилно.

Ерөнхийлөгч ТББ-ын нэгдсэн чуулганаас санал болгосон хүнээс 2, УИХ- 5, Засгийн газар- 2, нийт 9 хүнийг сонгон нэр дэвшүүлжээ. Үлдсэн 6 хүнийг төрийн бус байгууллагуудаас нэр дэвшүүлэгч этгээдүүдэд шууд хандан санал болгосон хүмүүсээс сонгож, нэр дэвшүүлсэн байна.

Шинэ хуулиар МҮРТ-ийг олон нийтийн болгон өөрчлөхөөс гадна орон нутагт олон нийтийн телевизийн байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн юм.

*Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевиз*

Шилжилтийн энэ явцад төрийн өмч олон нийтийн мэдэлд шилжсэн, МҮОНРТ-ийг албан ёсоор бүртгүүлсэн, байгууллагын дүрэм, олон тооны баримт бичиг, журам батлагдсан, тодорхой хэмжээнд телевизийн техникийг шинэчилсэн, сэтгүүлч, бусад мэргэжлийн хүмүүсийг гадаад, дотоодын сургалтад хамруулсан, радио, телевизийн хөтөлбөрийн бүтцэд өөрчлөлт хийсэн, техникийн иж бүрэн шинэчлэл хийх чиглэлээр Японы талтай тохиролцоонд хүрсэн, нэвтрүүлгийн бодлого, хүний нөөцийн бодлого, хөрөнгө оруулалт, техникийн шинэчлэлийн гэсэн гурван чиглэлээр 2007 хүртэлх үндсэн зорилтоо тодорхойлсон зэрэг чухал ач холбогдол бүхий дэвшил гарчээ.

МҮОНРТ нь радио, телевизийн болон радиогийн гадаад өргөн нэвтрүүлэг эрхэлдэг. Радиогийн салбар өдөрт 33 цагийн нэвтрүүлгийг хоёр сувгаар дамжуулж, гурван цагийн гадаад өргөн нэвтрүүлэг бэлтгэж байна.

Телевизийн салбар нь нэг сувагтай, өдөрт 16 цагийн нэвтрүүлэг бэлтгэж, үндэсний хэмжээнд дамжуулдаг.

Телевизийн мэдээний “Монголын Мэдээ” агентлаг МҮОНРТ-ийн бүтцэд байдаг. Радиогийн мэдээний “Хурд” агентлаг нь радиогийнхаа бүтцэд байдаг ажээ.

МҮОНРТ-д 700 шахам сэтгүүлч, бусад мэргэжлийн хүмүүс ажилладаг.

МҮОНРТ нь 2006 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангаа “Өдрийн сонин”-ны 2006 оны 8-р сарын 4-ний дугаарт хэвлүүлсэн байна. Энэ тайланд тусгасан хөтөлбөрийн бүтэц, гарсан өөрчлөлтийг доор үзүүлэв.

### **Радио( %)**

	2005 оны 12-р сард	2006 оны 7-р сард
1. Мэдээ, мэдээллийн	28	28
2. Нийгэм, эдийн засгийн	11	11
3. Боловсрол, танин мэдэхүйн	4	8
4. Түүх, соёл урлаг	8	10
5. Цэнгээнт	25	28
6. Зар сурталчилгаа*	4	2
7. Бусад	20	13

Тайлбар: \* Нийгмийн зар сурталчилгаа

### **Телевиз ( %)**

	2005 оны 12-р сард	2006 оны 7-р сард
1. Мэдээ, мэдээллийн	11.59	13.2
2. Нийгэм, эдийн засгийн	10.8	7.9
3. Боловсрол, танин мэдэхүйн	8	9.4
4. Түүх, соёл урлаг	21.4	6.4
5. Цэнгээнт	12	9.4
6. Кино	23.7	25

7. Төлбөрт, захиалгат

31.7

28.7

Үндэсний зөвлөл МҮОНРТ-ийн түр бүтцийг баталсан байна. Үүний дагуу МҮОНРТ нь одоо радио, телевизээс гадна MN агентлаг, Гадаад харилцаа, хүний нөөцийн газар, Санхүү, орлого бүрдүүлэлтийн газар, Стратеги төлөвлөлтийн газраас бүтэж байна.

#### **Орон нутгийн олон нийтийн өргөн нэвтрүүлэг**

ОНРТ-ийн тухай хуулийн “Орон нутгийн олон нийтийн өргөн нэвтрүүлэг” гэсэн 5-р бүлгийн 32.1-р заалтаар орон нутагт олон нийтийн радио, телевиз байгуулж болохыг хуульчилсан. Уг хуулийн 33.2-р зүйлийн дагуу орон нутгийн радио, телевизэд олон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж болно. Мөн “орон нутгийн радио, телевиз нэвтрүүлгийн онцлог, нэвтрүүлэх цагаас хамааран үйлчилгээний хөлсийг өөрсдөө тогтоох” (33.3) ба МҮОНРТ-ийн нэгжтэй хамтран ажиллаж болохыг заажээ.

Хуулиар бол орон нутгийн иргэд өөрийн орон нутгийн олон нийтийн радио, телевиз, МҮОНРТ хоёрт давхар хураамж төлөхөөр байна. Орон нутагт кабелийн суваг үздэг хүмүүсийн хувьд байдал илүү хүндрэлтэй ажээ. Тэд кабелийн сувгаар МҮОНРТ-ийн нэвтрүүлгийг хүлээн авдаг учирүйлчилгээний хураамжийг давхардуулж төлөхгүй гэж маргалдах тохиолдол байнга гардаг. Эрх зүйн орчин бүрдээгүй тул кабелийн телевиз, МҮОНРТ-ийн хоорондын санхүүгийн харилцааг зохицуулахад нэлээн бэрхшээл тулгардаг байна.

Хөдөөгийн долоон бүсэд ажиллаж байгаа манай мониторчдын мэдээлж байгаагаар орон нутгийн хэд хэдэн телевиз санхүүгийн шалтгаанаар үйл ажиллагаагаа зогсоожээ. Аймгийн төсөвт орон нутгийн олон нийтийн өргөн нэвтрүүлгийг дэмжих хөрөнгө хуваарилагдаагүй байна.

2005 оны 2-р сарын 17-18-ний өдрүүдэд Улаанбаатарт болсон Орон нутгийн хэвлэл мэдээллийн форумаас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу орон нутагт ИТХ-ын мэдэлд байгаа телевизийг менежментийн хувьчлалаар хувьчлан авахыг сэтгүүлчдэд уриалсан байна. Энэ нь ОНРТ-ийн тухай хуультай огт зөрчилдөхгүй байгаа юм.

Баян-Өлгий аймгийн хувьд байдал арай өөр. 1998 оны УИХ-ын 103 тоот тогтоолын дагуу Баян-Өлгийн радио станц МҮОНРТ-ийн салбар болох ёстой. Аймгийн ИТХ-аас түүнийг олон нийтийн болгохоор тогтоол гаргасан боловч аймгийн Мэдээлэл технологийн газрын дарга, аймгийн дарга хоёр МҮОНРТ-ийн салбар болгох талаар МҮОНРадиогийн удирдлагатай тохиролцжээ. Радиогийн удирдлага Баян-Өлгийд санхүү, техник шинэчлэлийн тусламж үзүүлж чадахгүй тухай бидэнд хэлсэн юм. Баян-Өлгийн телевизийн үйл ажиллагаа түр зогссон. Радио өргөн нэвтрүүлгийн станцын тоног төхөөрөмж хуучирсан, сэлбэл хэрэгслийн олдоц муу тул байдал хүнд байна.

#### **II. ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН ТУЛГАМДСАН АСУУЛТУУД**

Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн шилжитийн үеийн асуудалд Монголын хэвлэл мэдээлэл онцгой анхаарал тавьж байгааг тэмдэглэх ёстой. Хэвлэл мэдээлэл олон нийтэд тэдэнд хамаатай мэдээллийг хүргэж байгаа нь сайн хэрэг. Гэхдээ сонин хэвлэл, нэвтрүүлгийн мэдээллүүд гол төлөв нэг талыг барьсан хоорондоо зөрүүтэй байна.

## 2.1 Хараат бус байдал, Үндэсний Зөвлөл(ҮЗ), ерөнхий уур амьсгал

Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн тогтолцоонд шилжсэнээр улс төрийн шууд нөлөө багассан гэдэгтэй олон сэтгүүлч санал нэгтэй байна. Гэхдээ тэдний үзэж байгаагаар шууд бус нөлөө ҮЗ-ийн гишүүд, удирдах албан тушаалтнуудаар дамжин ирж байгаа ажээ. “Хэн чухам хэнийг төлөөлж байгааг бид мэнднэ” гэж зарим нь хэлэв.

Олон хүн МҮОНРТ Засгийн газраас хараат бус болсоноор байдал хуучнаасаа дордож байгаа гэсэн бодолтой байна. “Энд ажиллаж буй хүмүүсийг зорижуулсан тодорхой өөрчлөлтийг мэдрээгүй байгаа” гэж тэд хэлж байсан. Цалин хөлс нэмэгдээгүй, техник технологи шинэчлэгдээгүй, шийдвэр хүлээсээр байтал нэвтрүүлэг үйлдвэрлэлийн явц сунжирч байгаа гэнэ. Зарим нь хуучин тогтолцооны үед ажиллахад хамаагүй дээр байсан гэж үзэж байна.

Сэтгүүлчдийн дунд шууд цагдан хяналтад байсан хуучин үеэ санагалзах хандлага их байгаа нь түгшүүр төрүүлэв.

Хамт олны ҮЗ-д хандах хандлага сөрөг, хардаж сэргээн байдалтай. Нэгдүгээрт, тэд ҮЗ-ийн гишүүдийг улс төрч, эрх баригчидтай ойр дотно холбоотой гэж үздэг. Хоёрдуугаарт, ҮЗ-ийн хэд хэдэн гишүүнийг арилжааны телевизийн зарим сувагтай холбоотой гэж үздэг.

Нэгэн сэтгүүлч эмэгтэйн хэлсэн нь ерөнхийдөө хамт олны хандлагыг тодорхойлж байсан гэж болно. Тэрээр “ ҮЗ-ийн 15 хүн нэвтрүүлэг гэж юу вэ, нэвтрүүлэг бэлтгэх гэж юу болохыг мэдэхгүй гаднаас ирсэн хүмүүс. Бид цалингаа нэмүүлэхийг тэднээс шаардаагүй. Бид хэзээ ч баян байгаагүй, харин сэтгэл зүрхээ ажилдаа зориулсан улс. Би урагшаа явмаар байна. Гэтэл өмнө байснаасаа ухарч байна. Тэд бидэнтэй уулздаггүй, өрөө тасалгаагаар явж, бидний ямар нөхцөлд ажиллаж буйг харддаггүй. Бид тэднийг телевизийн дэлгэцээр л хардаг. Тэдний яах гэж энд ирснийг ойлгохгүй юм. Тэд бидний бэрхшээлийг ойлгохыг хүсэхгүй байна. Биднийг тэнэг, өөрсдийгөө ухаантай гэж бodoх юм” гэсэн юм.

МҮОНРТ-д үүссэн анхны зөрчил анхны Ерөнхий захирал томилохоос эхэлжээ. Энэ үйл явц ҮЗ-ийн дотор ч хагарал үүсгэж, олонхи (10) , цөөнх (5) болон хоёр хуваагдсан байна. Аль аль тал бие биенээ аль нэг улс төрийн хүчний нөлөөлөлд автсан хэмээн буруутгаж байв. Жишээ нь, ҮЗ-ийн гишүүн, цөөнхийн төлөөлөгч Ж.Занаа: “ҮЗ-ийн дарга хурлын үеэр байнга утсаар хэн нэгний зааврыг авдаг” гэсэн бол олонхийг төлөөлж буй О. Мөнгөнтуул: “Бидэнд хэн ч нөлөөлөөгүй, зарим гишүүн ёс зүйтэй баймаар байна” гэж мэдэгдэж байв.

ҮЗ-ийн дотоод зөрчил хурцдаж, Ерөнхий захирал томилохтой холбогдсон маргаан 3 сар үргэлжилж, асуудлаа шүүхээр шийдвэрлэхэд хүргэжээ. Тэд ганцаанаас гарах арга хайж, даргаа өөрчилж, дахин сонгууль хийжээ. ҮЗ-ийн анхны даргыг радиод ажиллаж байсан, одоо Монголын

Зохиолчдын Эвлэлийн гүйцэтгэх захирал хийж буй Х.Чилаажаваар сольсон байна.

## 2.2 Үндэсний Зөвлөл ба Түр Хорооны тэмцэл

2005 оны 11-р сарын 23-нд МҮОНРТ-ийн ажилтнуудыг төлөөлсөн Хамт олны зөвлөл байгуулагдаж, анхныхаа Сонордуулгыг ҮЗ-д илгээж, ерөнхий захирал сонгон шалгаруулах явц өнгөн дээрээ ардчилсан мэт боловч хэрэг дээрээ улс төрийн хүчний гар хөл болж байгаад санаа зовниж буйгаа илэрхийлжээ. Сонордуулгад: “Монголын нийгмийн өмнө хариуцлага хүлээх гол зангилаа хэрэгслийн хувь заяаг шийдэхдээ бүр эхнээс нь ийнхүү нэг намын бодлогод баригдаж, өрөөсгөлөөр шийдвэр гаргах юм бол үр дагаварт нь ардчиллын үнэт зүйл, хууль ёс хохирч, нийгэм олон түмний хүлээлт хөсөр хаягдах болно. Хараат бус мэдээллийн хэрэгсэл болгох эхлэлийг аль нэг хүчний тулгалтаар хийхгүй байх гэдэгт итгэж, Монгол улсын түүхэнд бий болж буй мэдээллийн салбарын шинэ эргэлтэд Үндэсний зөвлөл өөрөө саад болохгүй гэдэгт найдаж байна “гэсэн байв. Хамт олны төлөөлөгчид ҮЗ-ийн хуралд ажиглагчаар оролцож байв.

2006 оны 1-р сарын 5-ны өдөр Хамт олны зөвлөл 11 хүний бүрэлдэхүүнтэй, “Түр Хороо” нэртэй болж өөрчлөгдсөн байна. Түр Хорооны гишүүн Г.Бадамсамбуу: “Засгийн Газар МҮРТ-ийг хэдэн жилийн турш өөрийн дуу хоолой байлгасан. Олон нийтийн радио, телевиз байгуулагдах хөрсийг бэлтгэж өгөх нь Засгийн Газрын үүрэг. Бид радио, телевизийнхээ ирээдүй, санхүүгийн тогтвортой байдалд маш их санаа зовж байна. Бид МҮОНРТ-ийн салшгүй нэг хэсэг байж, программын, техник шинэчлэлийн бодлогод нөлөөлж ажиллана” гэж “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын сурвалжлагчид ярьсан юм.

Түр Хорооны гишүүн Б.Ганбаатар “ҮЗ-ийн дотоод зөрчилд их санаа зовж байна. ҮЗ-ийн гишүүд улс төрийн намуудтай холбоотой нь ил харагдаж байхад бие биетэйгээ маргалдаж, нэн тулгамдаж буй асуудлаар шийдвэр гаргах чадваргүй гэдэг нь илт байна” гэсэн юм.

Түр Хороо үндсэн гурван асуудлыг хөндөж байгаа ажээ.

### 1. Шударга бус сонгон шалгаруулалт

Түр Хороог төлөөлөн 4 гишүүн дэд захирал, радиогийн захирал, Хүний нөөц, хамтын ажиллагааны газар, Санхүү, орлого бүрдүүлэлтийн газар, Стратеги төлөвлөлтийн газрын захирлын сонгон шалгаруулалт хийгдээгүй, хууль зөрчсөн учир шийдвэрийг хүчингүй болгох шаардлагатай гэж үзэн Баянгол дүүргийн шүүхэд хандсан байна. 2006 оны 7-р сарын 17-ны өдөр Баянгол дүүргийн шүүхээс дээрх захирлуудыг томилсон Ерөнхий захирлын .2006 оны 12-р сарын 15-ний өдрийн 11 тоот тушаалыг хүчингүй болгох шийдвэр гаргажээ.

ҮЗ уг шийдвэрийг эс зөвшөөрч, 2006 оны 7-р сарын 17-ний өдөр Нийслэлийн шүүхэд давж заалдсан байна. Гэсэн ч Нийслэлийн шүүх 2006 оны 9-р сарын 22-ний өдрийн шүүх хуралдаанаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн давж заалдсан гомдлыг хэрэгсэхгүй болгожээ.

## 2. Бүтэц

Түр Хороо нь Үндэсний зөвлөлийн гишүүдийн баталсан түр бүтэц нь тэдний хууль зөрчсөн асуудалтай холбоотой гэж үзэж байна. Дээрх нэр бүхий газрыг ҮЗ-ийн гишүүд наиз нөхөд, хамаатан садандаа зориулан зориуд санаатай байгуулсан гэж Түр Хорооныхон хардаж байгаа ажээ.

2006 оны 8-р сарын 26-нд Түр Хороо “Санал, тайлбар уламжлал тухай” гэсэн агуулгатай захидалыг ҮЗ-д илгээжээ. Үүндээ ” Энэ байгууллага олон түмэндээ нэвтрүүлэг сонсгох, үзүүлэх нэг л үндсэн үүрэгтэй. Гэтэл үндсэн үйлдвэрлэлээ эрхэлдэг хоёр гол нэгжийг зориудаар хүчгүйдүүлэн сулруулж, ....ажил үүрэг нь тодорхой бус, оновчгүй бүтэц бий болгон хуульчилжээ.

...Нийтлэл нэвтрүүлэг, техник аж ахуй, санхүү захиргааны ажлын харилцан уялдаа холбоо сулран, технологийн чанартай шуурхай зохицуулалтыг шаардлагын хэмжээнд хийхэд түвэгтэй байна” гэжээ.

## 3. ҮЗ-ийн дотоод бүтэц

Түр Хорооныхон ҮЗ дотроо Гадаад харилцаа, хөрөнгө оруулалтын хороо (ГХХҮХ), Удирдлага, зохион байгуулалт ёс зүйн хороо (УЗБЁС) байгуулсан нь МҮОНРТ-ийг бүртгүүлэх үед батлагдсан дүрэмд байгаагүй, хуулиас давсан гэж үзэж байна. ҮЗ өөрийн эрх мэдлийг ашиглаж, хувийн сонирхолд үйлчлэх гэж хоёр хороог санаатай байгуулж, сүүлд дүрэмдээ тусгасан хэмээн тэд сэжиглэж байгаа ажээ.

МҮОНРТ-ийн дүрэмд хоёр хороог ҮЗ байгуулж, ажиллах журмыг батлахаар заасан бөгөөд хороо тус бүр 3 гишүүнтэй. Гишүүд нь ҮЗ-ийн бүрэлдэхүүнээс сонгогдон ажиллаж байгаа ажээ.

### 4.6: Гадаад харилцаа, хөрөнгө оруулалтын хороо

Монголын үндэсний олон нийтийн гадаад харилцаа, хөрөнгө оруулалт, техник технологийн шинэчлэлийн талаарх бодлогыг боловсруулж, Үндэсний зөвлөлөөр батлуулах

МҮОНРТ-ийн дүрмээс

### 4.7: Удирдлага зохион байгуулалт, ёс зүйн хороо

Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн бүтэц, зохион байгуулалтын бодлогыг тодорхойлох чиг үүрэг бүхий Удирдлага, зохион байгуулалт, зохион байгуулалт, ёс зүйн хороог Үндэсний зөвлөл байгуулж, түүний ажиллах журмыг батална.

МҮОНРТ-ийн дүрмээс

УЗБЁЗ-ын хороо нь дүрэмд өөрчлөлт оруулах санал боловсруулах, ерөнхий захирал, дэд захирал, албан нэгжийн дарга нарыг сонгон

шалгаруулах, чөлөөлөх, бүтэц, хүний нөөцийн бодлого боловсруулж батлуулах, ажиллагсдын ёс зүйн дүрэм боловсруулж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих зэрэг нэлээн өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах ажээ. МҮОНРТ-ийн дүрмийн 4.7-р зүйлийн 8 дахь заалтаар УЗБЭЗ-ын хорооны гишүүд “...сонгон шалгаруулах, ажлаас чөлөөлөх комисст “орж ажиллах боломж олгосон нь Түр Хорооны хардлагыг илүү төрүүлж байгаа бололтой юм.

Түр Хороо энэ асуудлаар ХЭДХЯ-нд хандсан байна. Тус яамны Бодлогын хэрэгжилт, зохицуулалтын газрын дарга Д.Мөнхгэрэлийн гарын үсэг зурсан, 2006 оны 7-р сарын 26-ний өдрийн албан бичигт ҮЗ-өөс “дээр нэр дурдсан хоёр хороог дүрэмдээ шинээр тусгаж, улсын бүртгэлд бүртгүүлэхийг хүсч, 2006 оны 5-р сарын 12-ны өдрийн 14 тоот албан бичгийг хянаж үзээд, Олон нийтийн радио, телевизийн хуулийн холбогдох заалтуудтай нийцүүлэх шаардлагатай гэж үзэж, бүртгэхээс татгалзаж хариу өгсөн болно“ хариу өгсөн байна.

2006 оны 8-р сарын 26-ны Түр Хорооны захидалд байгууллагын бүтцийг дахин авч үзэх, удирдлагын багийг дахин бүрдүүлэх, илүү орон тоог цэгцлэх, Ерөнхий захирлыг шалгаруулахдаа эдийн засгийн мэдлэг, менежерийн чадвар, салбар чиглэлийн мэргэжлийн түвшин, хэлний бэлтгэл зэргийг гол үзүүлэлт болгох, улс төр, бизнесийн бүлэглэлээс ангид байх зэрэг асуудлыг хөнджээ. Түр Хороо ҮЗ-тэй яаралтай нүүр тулсан уулзалт зохион байгуулахыг санал болгосон байна. Мөн Түр Хорооны бүрэлдэхүүнд эрх ашгийн зөрчилтэй хүмүүс байгаа, тэд хамт олныг төлөөлөх чадваргүй гэж ҮЗ үзэж байгаа бол шинэчилж болохыг мэдэгджээ.

Түр Хорооны шаргуу хүсэлтийн дагуу УИХ ОНРТ-ийн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг байгуулсан байна. Ажлын хэсэг ажлаа дуусгасан боловч дүгнэлтийг олон нийтэд мэдээлээгүй байна. Ажлын хэсгийн дарга, УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл: “Бид шилжилтийн үйл явцад шууд оролцмооргүй байна. Ингэх нь улс төрийн зорилготой үйлдэл, санаархал мэт ойлгогдож болзошгүй. Би хувьдаа ОНӨН-ийн дотоод асуудлыг шийдвэрлэхэд УИХ-ын эрх мэдлийг ашиглах буруу жишиг тогтох вий гэж эмээж байна. Энэ нь угтаа хуулийн үзэл баримтлалын эсрэг юм” хэмээн “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын тэргүүнтэй уулзахдаа хэлсэн билээ.

Түр Хороо ҮЗ-ийг УИХ эгүүлэн татах хэрэгтэй гэж үзэж, энэ тухайгаа байн байн мэдэгдэж байгаа юм. “Хуулиа зөрчиж байгаа ҮЗ хамт олны ашиг сонирхолд нийцсэн зөв шийдвэр гаргах чадваргүй” гэж тэд үндэслэлээ тайлбарлаж байна.

ОНРТ-ийн тухай хуулиар бол ҮЗ-ийн гишүүдийг эгүүлэн татах заалт хатуу хязгаарлалттай. Хуульд зааснаар эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлж өгөхийг хүссэн өргөдлийг Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн гаргасан, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон, мөн энэ хуулийн 21.3-т заасныг зөрчсөн, эсхүл уг зүйлд заасан ажил, албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон, ҮЗ-ийн хуралдаанд 6 сараас дээш хугацаагаар биечлэн оролцоогүй тохиолдолд ҮЗ-ийн дарга, гишүүнийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө эгүүлэн татах боломжтой.

ҮЗ-ийн гишүүн “төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагч, улс төрийн намын удирдах албан тушаалтан, бусад радио, телевизэд

ажиллаж байгаа, түүнчлэн ажилладаггүй боловч хөтөлбөрийн бодлогыг тодорхойлоход оролцдог этгээд байж болохгүй" гэж хуулийн 21.3-д заасан байдаг юм.

Үндэсний Зөвлөл энэ хугацаанд нийт 39 удаа хуралджээ. ҮЗ хэлэлцсэн асуудлаар нийт 95 шийдвэр гаргаж, нийт 20 дүрэм журам баталсан байна.

Дотроо зарчмын зарим асуудлаар зөрчилтэй, анхны Ерөнхий захирал томилох явцад хямралт байдал үүссэн гэдгийг ҮЗ нуухгүй байгаа. Тэд ямар ч тохиолдолд хурал хаяхгүй гэдэг тохиролцоонд хүрчээ.

Ерөнхийдөө тэд Түр Хороонд эргэлзсэн байдлаар ханддаг. Зарим гишүүн Түр Хороо бүх хамт олныг төлөөлж чадахгүй, дотроо зөрчилдөөнтэй гэж үздэг байна. Түр Хороо өөрсдийнх нь сонирхол хөндөгдөх, тухайлбал ерөнхий захирал томилогдох үеэр идэвхжэдэг гэж зарим нь хэлж байсан.

ҮЗ-ийн дарга "Энэ бүтэц бол түр батлагдсан. Анхны Ерөнхий захирал томилогдох явцад бий болсон хямралт байдлаас гарахын тулд, ажлыг урагшуулахын тулд бид баталсан юм. Цаашид илүү үр дүнтэй бүтэц шаардлагатай гэдгийг бид ойлгож байгаа" гэсэн юм.

Маргаантай байгаа хоёр хорооны тухай тэрээр:" ҮЗ-ийн гишүүдийн ачааллыг тэнцвэржүүлэхийн тулд ийм хоёр хороо байгуулсан. Өнгөрсөн хугацаанд гишүүдийн зарим нь дүрэм журам боловсруулахад хэт их ачаалалтай ажиллаж, зарим нь огт идэвхгүй байсан. Хэрэг дээрээ энэ хоёр хороо зөвлөх эрхтэй, шийдвэр гаргах эрх мэдэлгүй" хэмээн тайлбарласан юм.

Хоёр хорооны асуудлаар ҮЗ дотор ч өөр байр суурьтай гишүүд байдаг ажээ.

## 2.2 Ерөнхий захирал

Хуулийн 31.1-р зүйлд зааснаар Ерөнхий захирлыг ҮЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар нууц санал хураалтаар томилно. 31.2-р зүйлийн дагуу Ерөнхий захирлыг сонгон шалгаруулах замаар томилж болно. Ерөнхий захирал дээд боловсролтой, ял шийтгэлгүй, улс төрийн намын гишүүн бус байх ёстой (31.3).

31.5-р зүйлд: "Ерөнхий захирал бусад байгууллага, албан нэгжийн удирдах бүрэлдэхүүнд хавсран ажиллаж болохгүй" гэж заажээ.

Үндэсний зөвлөл МҮОНРТ-ийн анхны ерөнхий захирлаар С.Мягмарыг 2005 оны 11-р сарын 26-ний өдрийн 15 тоот тогтоолоор томилжээ. С.Мягмар өмнө нь Монгол төлөвийн хүүхэлдэйн киноны зураач, найруулагчаар ажиллаж байсан, зар сурталчилгаа гол төлөв хийдэг хувийн "Боролдой" студийн эзэн байв.

Ерөнхий захирал томилсон шийдвэр ҮЗ-ийн гишүүдийн дунд үл ойлголцол үүсгэж, хямралт байдал бий болсон юм. С.Мягмарыг өмнө нь Монгол төлөвийн ажиллаж байхдаа хөрөнгө шамгигдуулсан, өр төлбөрөө барагдуулах тухай шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй учир ОНРТ-ийн өмч хөрөнгийг итгэж өгөх ёс суртахуунгүй хүн хэмээн буруутгаж байсан юм. Харин С.Мягмар хэвлэл мэдээлэлд өгсөн хэд хэдэн ярилцлагадаа үүнийг эрс няцааж байв.

ҮЗ-ийн дөрвөн гишүүн томилолтыг шударга бус гэж үзэн шүүхэд хандсан байна. 2005 оны 12-р сарын 14-ний өдөр Баянгол дүүргийн шүүх

түүнийг ерөнхий захирлаар томилсон ҮЗ-ийн 15 тоот тогтоолын биелэлтийг хориглосон шийдвэр гаргажээ. Үйл явц хоёр сар сунжирч, байгууллагын өдөр дутмын үйл ажиллагаанд нөлөөлж эхэлсэн байна. ҮЗ гацаанаас гарах арга эрэлхийлэн дахин дахин хуралдаж, нэгдсэн тохиролцоонд хүрсэний эцэст нь 2006 оны 1-р сарын 26-нд ҮЗ С.Мягмарыг томилсон шинэ шийдвэр гарсан байна.

С.Мягмарыг 2006 оны 8-р сарын 3-нд ҮЗ-ийн шийдвэрээр гэрээний заалтыг ноцтой зөрчсөн гэж үзэн ажлаас нь чөлөөлжээ.

МООНРТ-ийн шинэ захирал М.Наранбаатар 2006 оны 8-р сарын 31-нд Ерөнхий захирлаар томилогджээ. М.Наранбаатар МООРТ-д “Өглөө” хөтөлбөр нийлүүлдэг хувийн студийн захирал байв. “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын тэргүүнтэй уулзахдаа “Студиэ татан буулгана” гэж байсан. Томилолтын явцад, мөн дараа нь сонин хэвлэлд түүний тухай “Ардчилсан намын Удирдах зөвлөлийн гишүүн байсан, авто машины осол гаргасан, Хятадын нэг компаний их хэмжээний зээлийн гэрээ байгуулсан” гэх мэтийн мэдээлэл гарч байв. Түүнийг эсэргүүцсэн МООРТ-ийн 150 орчим хүний гарын үсэгтэй бичиг ҮЗ-д очиж, шаардлагыг хүлээн авахгүй бол огцрохыг шаарджээ.

Бидэнд мэдээлснээр ҮЗ зээлийн гэрээтэй холбоотой асуудлыг шалгаж байгаа ажээ. Түүнийг мөн хоёр нэвтрүүлэг хаасан тухай Түр Хорооны зарим гишүүн мэдээлсэн юм. “Нэг нэвтрүүлэг нь хувийн студийн танин мэдэхүйн нэвтрүүлэг бөгөөд “байгууллагатай хийсэн гэрээ олдохгүй байсан тул түр хаасан” гэж М.Наранбаатар тайлбарлав. “Хоёр дахь нэвтрүүлэг нь МООНРТ-ийн нэвтрүүлгийн тухай олон нийтэд мэдээлдэг байсан. Би олон нийтэд мэдээлэл хүргэхийн эсрэг биш. Гэхдээ долоо хоног бүр өөрсдийн тухай ярих нь тохиромжгүй гэж бодож байна. Энэ нэвтрүүлгийн агуулга, бүтцийг бид дахин ярилцах ёстой” гэж тэр хэлсэн юм.

## 2.3 Эдийн засгийн хараат бус байдал

Эдийн засгийн хараат бус байдал үгүй бол улс төрийн хараат бус байдал хангагдахгүй гэсэн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн зарчим байдаг. Аливаа Засгийн газрын хэвлэлийн эрх чөлөөнд хандах хандлагын үндсэн шалгуур нь түүний олон нийтийн өргөн нэвтрүүлгийн эдийн засгийн хараат бус байдлыг хэрхэн хангаж байгаагаар хэмжигддэг.

МООНРТ-д үйлчилж буй санхүүгийн харилцаа, механизм ОНРТ-ийн хуулийн үзэл баримтлалын эсрэг байна. Гэхдээ үүнийг Монголын Засгийн Газраас олон нийтийн өргөн нэвтрүүлэг, тухайлбал хэвлэлийн эрх чөлөөнд хандаж буй жинхэнэ хандлага гэж бид үзэхгүй байна. Засгийн газар, МООНРТ хоёрын санхүүгийн харилцаа хэзээ ч таагүй орчин үүсгэх ёсгүй билээ.

МООНРТ бол олон нийтийн санхүүжилттэй, ашгийн төлөө бус этгээд билээ. Санхүүгийн гол эх үүсвэр нь үйлчилгээний хөлс, зар сурталчилгаа, улсын төсвийн дэмжлэг, хандив, тусламж, бусад орлого (ОНРТ-ийн тухай хуулийн 17-р зүйл) юм. Мөн хуулийн 13.1-р зүйл арилжааны болон далд сурталчилгааг хориглосон. Арилжааны бус зар сурталчилгааны нийт хэмжээ тухайн өдрийн нэвтрүүлгийн цагийн хоёр хувиас хэтрэхгүй байхаар хуульчлагдсан (ОНРТ-ийн тухай хуулийн зүйл 13.3)

МООНРТ-ийн 2006 оны төсвийн орлого 5,2 тэрбум төгрөг ажээ. Үүний 4 тэрбум нь улсын төсвийн дэмжлэг ба 1.2 тэрбум нь үйлчилгээний хэлс, бусад орлогоос бүрдэж байна. Улсын төсвийн дэмжлэгийн 45 хувь нь цацах дамжуулах зардал ажээ.

Өнөөгийн байдлаар санхүүгийн механизм 2002 оны 6-р сарын 27-нд батлагдсан Төсвийн удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар зохицуулагдаж байна. Засгийн Газар энэ хуулийг хэрэгжүүлэхдээ 2002 оны 5-р сарын 24-ний өдрийн тогтоолоор Санхүү, Эдийн Засгийн Яамны(СЭЗЯ) Төрийн сангийн газар байгуулжээ. Төрийн аливаа байгууллага зөвхөн төрийн санд данстай ажээ.

МООНРТ бас төрийн санд данстай, санхүүгийнхээ асуудлаар мөн СЭЗЯ-ны Төсвийн бодлого, зохицуулалтын газартай харилцдаг байна. МООНРТ-ын төсөв, түүний зарцуулалтыг энэ газар хянадаг юм байна. Энэ нь МООНРТ-ын сэтгүүлч, бусад ажиллагсдын цалингийн хэмжээг тогтооход ч нөлөөлж байна. Тэд одоо төсвийн байгууллагын ажилчдын цалингийн сүлжээгээр цалинждаг ажээ.

Төсвийн бодлого, зохицуулалтын хорооны ажилтан эмэгтэй: "Төр МООНРТ-д 4 тэрбум төгрөг олгож байгаа нь маш их мөнгө. Төсөв аль хэр бодитой хийгдсэнийг шалгахын тулд бид гүйцэтгэлд нь хяналт тавихаас аргагүй" гэсэн билээ.

МООНРТ-ийн 2006 оны хагас жилийн тайланда “Арилжааны банкинд шинээр данс нээж, статсууаа тодорхой болгосон” гэж мэдээлжээ.

МООНРТ хуулиар төрийн байгууллага биш болсон. Энэ бол өөрийн хуулийн хүрээнд “гагцхүү олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээд” (ОНРТ-ийн тухай хуулийн 3.1-р зүйл) юм. МООНРТ-ын хараат бус байдал бие даасан хуулийн этгээдийн хувьд өөрийнх нь ҮЗ-ийн бүрэн эрх, эрх мэдлээр дамжин хэрэгжих ёстой.

ҮЗ-ийн бүрэн эрхийг ОНРТ-ийн тухай хуульд байгууллагын “үйл ажиллагааны үндсэн зорилт, стратеги төлөвлөгөө, тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, Монгол Улсын төсөвт (батлуулах бус) тусгуулах (24.1.1), “зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг товоох(24.1.6.), “үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж, батлах” (24.1.10) гэх мэтчилэн заасан байна. ҮЗ орон тооныхоо дээд хязгаарыг тогтоодог мөртөө цалингийн хэмжээг тогтоохгүй, цалингийн сангаа батлах эрхгүй байгаа нь энэ хуулийн нэг хийдэл юм.

ҮЗ өөрөө төсвөө хэлэлцдэг хэрнээ батлах эрхгүй, санхүүгийн тайлангаа баталдаг мөртөө үүнийг нь төрөөс хянадаг зэрэг нь ҮЗ-ийн бүрэн эрхийг утгагүй, зохисгүй хязгаарлаж буй хэрэг гэж бид үзэж байна.

МООНРТ бие даасан хуулийн этгээд тул төсвөө өөрөө баталдаг, гүйцэтгэлээ өөрөө хянадаг байх нь ОНРТ-ийн хуулийн үзэл баримтлал, зарчимд нийцнэ.

Нөгөөтэйгүүр, үйлчилгээний хэлс бол олон нийтээс өөрийн радио, телевизэд өгч буй төлбөр болохоос төсвийн санхүүжилт биш, төрийн санд хамаарахгүй орлого. ОНРТ-ийн хуулийн 18-р зүйл МООНРТ өөрөө үйлчилгээний хураамжийг улсын хэмжээнд хурааж төвлөрүүлэх үүрэг бүхий нэгжийг байгуулж болохыг, мөн түүний үйл ажиллагаа, санхүүжилтийн журмыг тогтоох эрхийг ҮЗ-д нь олгожээ.

МООНРТ нь нийслэл хот, орон нутагт үйлчилгээний хөлсийг цуглуулж төвлөрүүлэх маркетингийн албатай. Логикийн үүднээс авч үзсэн ч МООНРТ-ийн бүтцэд байдаг энэ алба хураасан хөлсөө төрийн санд төвлөрүүлж, тэндээсээ буцааж авах нь утгагүй хэрэг.

Улсын төсвийн дэмжлэг нь төсвийн шууд санхүүжилт бус бөгөөд МООНРТ-ын нийт санхүүжилтийн нэг хэсэг юм. Үлэмж хэсэг гэдэгтэй бид санал нийлж байна. Гэсэн ч МООНРТ хараат бус хуулийн этгээдийн хувьд төрийн дэмжлэгийг өөрийн дансанд төвлөрүүлэх ёстой бөгөөд төсвөө өөрөө захируулан зарцуулдаг байх нь зүйд нийцнэ. МООНРТ-ийн төсөв, түүний гүйцэтгэлд хяналт тавих эрх бүхий Хяналтын зөвлөл байгуулахыг хуульчилсан байгаа.

ҮЗ-ийн баталсан төсвийг баталж, өөрийн олгож буй дэмжлэгээ аль болох түргэн шуурхай, хүнд сурталгүйгээр МООНРТ-ийн дансанд шилжүүлэх нь л Засгийн Газрын цорын ганц үүрэг байх ёстой. Энэ нь МООНРТ-ийн санхүүгийн хараат бус байдлыг илүү хангаж, төр засгаас хараат бус байхад нь илүү тустай гэж бид үзэж байна

## 2.4 Олон нийтийн өргөн нэвтрүүлэг ба бие даасан студи

Одоогийн байдлаар МООНРТ-тэй гэрээтэй ажиллаж, телевизийн нэвтрүүлгээр хангадаг бие даасан 10 студи байгаа ажээ. Эдгээр студи телевизийн хөтөлбөрийн 70 шахам хувийг нийлүүлдэг байна. Ийм уламжлал бүр 1997 оноос тогтох, 2004 онд эрх зүйн хувьд баталгаажсан ажээ.

Эдгээр студи ХЗДХ-ийн яаманд бүртгэлтэй, өөрийн данс, тамга тэмдэгтэй, өөрийн бүтэц, ажилчидтай. Нэвтрүүлгээ МООНРТ-ийн захирал, студийн захирлын гарын үсэг зурсан гэрээний үндсэн дээр нийлүүлдэг.

Студиуд гол төлөв мэдээллийн тусгай хөтөлбөр, урлаг соёл, поп хөгжим, реалити шоу зэрэг зугаа цэнгэлийн нэвтрүүлэг бэлтгэж нийлүүдэг байна. МООНРТ-ийн телевизийн салбар өөрийн бүтцэд хүүхэд, боловсрол, нийгмийн нэвтрүүлэг бэлтгэдэг гурван редакцитай ажээ.

Студиуд МООНРТ-ийн байранд байрладаг, түрээсийн мөнгө төлдөггүй. Нэвтрүүлэг бэлтгэсний хөлсөнд ойролцоогоор нэг минутад 2500-4000 төгрөг авдаг. ОНӨН байгуулагдааас өмнө өөрийн олсон зар сурталчилгааны орлогын тодорхой хувийг телевизэд оруулдаг байв.

Студийн захирлуудын хэлсэнчлэн, эдгээр студи телевизийн чанартай нэвтрүүлэг бэлтгэх ганцхан зорилготой байгуулагджээ. Эдийн засгийн хувьд нэвтрүүлэг бэлтгэх хөлс, цалин, нийгмийн даатгал, харилцаа холбооны төлбөр гээд олон зардлаа хэмнэх боломжийг телевизэд олгож байгаа гэж тэд үздэг. Мөн “телевиз нэвтрүүлэг худалдаж авах үнээ анхныхаасаа хоёр дахин бууруулсан” гэж гомдоллож байв.

Гэвч МООНРТ-ын зарим хүмүүс студиуд зөвхөн ашиг олохын төлөө байгуулагдсан гэж үздэг байна. Үүнтэй телевизийн зарим захирал ч санал нийлж байв. Уран бүтээлийн студи, продакшнтай байрны түрээсийн гэрээ байгуулан ажиллах талаар хэлэлцэж, гэрээ хийж байгаа тухай МООНРТ-ийн 2006 оны эхний хагас жилийн тайланд дурджаэ.

Эрх зүйн үүднээс харвал студиуд МООНРТ-ийн гадна байдаг, бие даасан хуулийн этгээд байна.

Студи, МҮОНРТ-ийн эрх ашгийг тэнцвэржүүлэх нь одоо удирдлага, ҮЗ-ийн толгойны өвчин болж байна. ҮЗ-ийн даргын хэлснээр МҮОРТ, студиудын харилцааг зохицуулахад цаг хугацаа хэрэгтэй бололтой.

## 2.5 Хяналтын Зөвлөл

ОНРТ-ийн хуулийн 28-р зүйл Хяналтын зөвлөл байгуулж, ажиллах журмыг батлахыг ҮЗ-д үүрэг болгожээ. Хяналтын зөвлөл нь “хөтөлбөрийн бодлогоос бусад асуудлаар гарсан ҮЗ-ийн шийдвэрийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаа, менежментэд хяналт тавих” чиг үүрэгтэй(28.1). ҮЗ нь Хяналтын зөвлөлийг анхны хуралдаанаар байгуулах, ажиллах журмыг батлах, гишүүдийг сонгох (28.2) эн тэргүүний үүрэгтэй. Уг хуулийн 29.1.1-д зааснаар Хяналтын зөвлөл ҮЗ-ийн дарга, гишүүнийг эгүүлэн татах зөвлөмж гаргах нэлээн том эрхтэй.

Тус хуульд энэ зөвлөл ҮЗ-ийн бүтцэд байж, зөвхөн ҮЗ-ийн зөвлөлийн гишүүдээс бүрдэх тухай онцгойлон заагаагүй. Одоогийн Хяналтын зөвлөл ҮЗ-ийн гурван гишүүнээс бүрддэг ажээ.

Хяналтын зөвлөлийг зохицуулж буй уг хуулийн заалтууд хоорондоо зөрчилтэй байна. Хуулийн 31.7-р зүйлд зааснаар Ерөнхий захирал хувь хүн, бусад байгууллага, албан нэгжтэй гэрээ хийхдээ яагаад хяналтын даргын зөвшөөрөл авах ёстой нь ойлгомжгүй юм. Нөгөөтэйгүүр, өөрөө зөвшөөрөл өгчихөөд хяналт тавих нь зохимжгүй. Дээрх заалтаар бол баярын нэвтрүүлгийн тайзны эскиз хийлгэх, радиогийн хөгжим бичих гэх мэт өдөр дутмын үйлдвэрлэлийн явцад Ерөнхий захирал тухай бүр гэрээгээ барин Хяналтын зөвлөл үрүү гүйх хэрэг гарч байна.

Ер нь ҮЗ олон нийтийн өмнө эцсийн хариуцлага хүлээх ёстой. Ерөнхий захирлын эрх хэмжээгээр хязгаарлагдсан, эсхүл заавал тендер зарлаж шалгаруулан гүйцэтгүүлэх ёстой, өндөр үнэтэй ажил үйлчилгээний гэрээнд гарын үсэг зурах эрхийг ҮЗ өгдөг байхад хангалттай. Харин тухайн ажил үйлчилгээний сонголт, тендерийн шалгаруулалт зэрэг нь шударга байсан эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах эрх үүрэг нь Хяналтын зөвлөлд байвал зохино.

Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд ҮЗ-ийн гишүүд оролцохгүй байвал илүү үр дүнтэй, ил тод, ёс зүйтэй ажиллах нөхцөл бүрдэнэ гэж бид үзэж байна.

## 2.6 Өргөдлийг шалгах хороо

ОНРТ-ийн хуулийн 30-р зүйл Өргөдлийг шалгах хороо байгуулах үүргийг ҮЗ-д ноогдуулсан байна. Хуулийн дагуу энэ хороо хоёр үндсэн үүрэгтэй. Нэгд, “нэвтрүүлгийн агуулгатай холбогдуулан ҮЗ-д ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх”, хоёрт “олон нийтийн санаа бодлыг судлах. Тус хуульд энэ хорооны гишүүдийн тоог тогтоогоогүй, харин бүрэлдэхүүний хувьд ҮЗ-ийн гишүүн, хүний эрх, сэтгүүл зүй, эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хүмүүсийг оруулахаар заажээ. Мөн бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах журмыг ҮЗ батлахаар хуульчилсан байна.

Өргөдлийг шалгах хороо долоон гишүүнтэй байхаар Y3-өөр батлагджээ. Одоогийн байдлаар дөрөв нь томилогдсон бөгөөд бүгд Y3-ийн гишүүд байна. Улдсэн гурван гишүүнийг томилохоор ярилцаж байгаа ажээ.

Олон улсын хэм хэмжээгээр иргэний гомдлыг хүлээн авч, барагдуулах ийм хороо нь олон нийтийн хариу өгөх эрхийг батлагажуулахын тулд байгуулагддаг. Иймэрхүү хороо нь аль нэг нэвтүүлэг, мэдээний хөтөлбөрөөр өөрийнх нь тухай аливаа худал мэдээлэл, баримт сэлтийг нэвтрүүлсэн гэж үзсэн, сэтгүүлчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол маргааныг шүүхийн өмнөх шатанд хэлэлцэж, шийдвэр гаргах эрх бүхий хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын чухал хэлбэрийн нэг юм. Ийм хороо иргэний гомдлыг шалгаж, шийдвэр гаргадаг. Хороо Y3-ийн дэргэд бус МҮОНРТ-ийн бүтцэд байх нь зүйтэй юм. Гомдол гаргасан хүн Хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол дотоодод Y3-д давж заалдаж болно. Y3 тухайн иргэний асуудлаар гаргасан Хорооны шийдвэр зөв буруу эсэхэд дүгнэлт гаргана. Хэрэв иргэн Y3-ийн шийдвэртэй санал нийлэхгүй бол шүүхэд хандах эрхтэй. Иргэний ийм гомдол нэвтрүүлгийн агуулгатай бус тухайн нэвтрүүлгээр гарсан мэдээлэл, баримттай илүү холбоотой байдаг ба энэ нь гол төлөв гүтгэлэг, нэр төр, алдар хүнд, нэр хүнтэй холбоотой маргаан байдаг.

Нэвтрүүлгийн агуулга, чанарын тухай гомдол мэдүүлэх нь үйлчилгээний хөлс төлж буй иргэн бүрийн үүрэг. Үүнийг шийдвэрлэх арга хэлбэр, механизмыг МҮОНРТ тогтооно.

### III. ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ

Y3 ба Түр Хороо, Y3 ба хамт олон, Түр Хороо ба хамт олны хоорондыг харилцаанд юуны өмнө хүмүүсийн хоорондын харилцаа, сэтгэгдэл, хардалт илүүтэй нөлөөлж байх шиг санагдав. Бидний үзэж байгаагаар ОНӨН-ийн шилжилтийн явцын өөр өөр шатанд зарим алдаа гарсан байна.

1. ТББ нэгдсэн чуулганаа хийж байхдаа МҮЭ-ийг оруулж, түүнийг төлөөллийг санал болгосон нь алдаатай байжээ. Энэ нь цаашдын хямралт байдалд нөлөөлсөн гэж үзэж байна. МҮЭ нь Засгийн газрын бус байгууллага боловч шинж байдлаараа төрийн бус байгууллага биш юм. МҮЭ нь Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулиар зохицуулагддаг хуулийн этгээд. ТББ бас өөрийн хуулиар зохицуулагддаг. МҮЭ-ийн ерөнхийлөгч, МАХН-ын гишүүн, УИХ-ын гишүүн байсан хүн Y3-д орсон нь тус намын удирдлага ОНӨН-ийн байгууллагад хяналт тавих гэсэн оролдлого хийж байгаа, томилолтуудад гол үүрэг гүйцэтгэж байгаа гэсэн ойлголт төрүүлсэн байна. Одоо ч олон нийт, хамт олон ийм түгээмэл ойлголттой байна.

2. УИХ, Ерөнхийлөгч, Засгийн Газар Y3-ийн гишүүдэд нэр дэвшүүлэх үйл явц нээлттэй, ил тод байсангүй. Тэд ТББ-ын чуулганаас санал болгоогүй зургаан хүнийг сонгож, нэр дэвшүүлсэн. ОНРТ-ийн хуулиар төрийн бус байгууллагууд өөрийн хүнийг ТББ-ын нэгдсэн чуулганаас гадуур шууд санал болгохыг хориглоогүй. Гэхдээ тэдгээр хүмүүсийг сонгох, нэр дэвшүүлэх үйл явц олон нийтэд ил тод бус, нээлттэй бус байсан тул тухайн хүмүүсээр дамжуулан УИХ, Ерөнхийлөгч, Засгийн Газар өөрийн хяналт нөлөөллийг хадгалж үлдэхийг оролдож байна гэж сэжиглэх үндэслэл

болжээ. Олон нийт өнөө хэр тэдгээр гишүүнийг ямар шалгуураар, ямар ТББ санал болгосон тухай мэдэхгүй байна. Иймд УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар үүнийгээ олон түмэнд тайлбарлах ёстой гэж бодож байна.

3. УИХ ҮЗ-ийг томилохдоо 2006 оны 6-р сарын 21-ний өдөр баталсан УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай 61 тоот тогтоолоо зөрчсөн байна. Энэ тогтоолын 11.2-р заалтын дагуу УИХ-аас байгуулагдаг байгууллагын бүрэлдэхүүнийг томилохдоо хүн нэг бүр дээр нээлттэй санал хураах ёстой атал УИХ ҮЗ-ийн гишүүдийг бөөнд нь санал хураан томилжээ. Ийм хариуцлагагүй алхам нь УИХ өөрийн баталсан хуулийн үзэл баримтлалыг үгүйсгэж, олон нийтийн хүлээлт, хүсэл, итгэлийг хөсөрдүүлсэн хэрэг болжээ. Бид 2006 оны 10-р сарын 13-ны чуулганы хуралдааны тэмдэглэлийг сонин хэвлэлд нийтлэхийг шаардаж байна. Олон нийт үүнийг олж мэдэх эрхтэй билээ. УИХ алдаагаа засах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Эцэст нь тэмдэглэхэд, өнөө хэр МҮОНРТ-д үргэлжилж байгаа хямралын төлөө УИХ, Ерөнхийлөгч, Засгийн Газар хариуцлага хүлээх ёстой.

4. МҮОНРТ-д үүсэж бий болсон хямралт байдалд санаа зовж, Ажлын хэсэг байгуулсан УИХ-ын санаачилгыг бид сайshaаж байна. Гэхдээ Монголд жинхэнэ ОНӨН бий болгоё гэсэн тэдний хүсэл эрмэлзэл дуугүй байснаар хязгаарлагдах ёсгүй. Ажлын хэсгийн тайлан олон нийтэд ил болж, сонгогчид өөрсдийнх нь төлөөлөгчид энэ байдалд хэрхэн хандаж буй, ямар байр суурьтай байгаа, ямар алхам хийх гэж олж мэдэх нь туйлаас чухал.

5. МҮОНРТ-ийн анхны ҮЗ хүнд хэцүү, түүхэн үүрэг гүйцэтгэж, ОНӨН-ийн шинэ соёл бий болгохын төлөө хамт олон, олон түмний өмнө асар их хариуцлага хүлээж байгаа билээ. Шилжилтийн үеийн ярвигтай, чухал үед ҮЗ-ийн гишүүдийн үүргээ ухамсарлаж, чин хүсэл эрмэлтэй ажиллаж буйг бид ойлгож байна. Гэхдээ ҮЗ-ийн үйл ажиллагаа илүү ил тод, нээлттэй байж, бодлогын баримт бичиг, байгууллагын дүрэм, бусад журам боловсруулах, хэлэлцэх явцдаа хамт олныг илүүтэй татан оролцуулах ёстой байжээ. Анхны Ерөнхий захирлыг томилох хоёр дахь шатны явцыг телевизээр үзүүлсэн, үйл ажиллагааныхаа тайланг сонинд хэвлүүлсэн, ҮЗ-ийн хурал нээлттэй байлаг, дарга, гишүүд радио, телевизээр байнга ярилцлага өгч, нийтэд мэдээлэл хүргэж байсан зэрэг ил тод байдлыг дэмжсэн алхмуудыг бид үгүйсгээгүй. Гэхдээ хамт олон, ҮЗ-ийн хамтын, нэгдсэн хүч чармайлтаар сайн үр дүнд хүрнэ гэдгийг ойлгох ёстой. Зорилгодоо хүрэхийн тулд МҮОНРТ-д хамгийн таатай орчин бүрдүүлэх нь ҮЗ-ийн үүрэг билээ. Алдаагаа ухамсарлах, түүнийхээ төлөө харицлага хүлээх хэзээд амаргүй байдаг ч нэгдсэн зорилгын төлөө зоримог алхам хийх нь та бүхний нэр төрийн хэрэг байх ёстой.

6. ҮЗ нь өөрийн эн тэргүүний зорилтыг буруу тодорхойлсон гэж бодож байна. Байгууллагын болон хөтөлбөрийн стратеги бол МҮОНРТ-ийн бүтэц зохих хэмжээнд үр дүнтэй байх гол тулгуур нь юм. ҮЗ нь хөрс сууриа бэлдээгүй байж, яаравчлан бүтцээ баталсан нь хариуцлагагүй явдал болжээ. Нөгөөтэйгүүр, ҮЗ нь дүрэм журмаа өөрсдөө гардан боловсруулж, гүйцэтгэх эрх мэдлийн ажлыг хийж байгаа нь буруу юм. Энэ нь мөн хамт

олонд өөрт нь итгэдэггүй, эсвэл тэднийг доогуур үнэлдэг гэсэн ойлголт төрүүлж буйг анхааралдаа авах нь чухал. ҮЗ бол бодлого барьж, шийдвэр гаргадаг, томоохон эрх мэдэл бүхий этгээд билээ.

7. ҮЗ нь Ерөнхий захирлыг сонгон шалгаруулах журамдаа сонирхлын зөрчлийг хааж өгөөгүйг бид өмнө нь ч хэлж байсан. Дэд захидал, бусад захирлыг сонгон шалгаруулахад гүйцэд хяналт тавиагүй нь ч бас ҮЗ-ийн алдаа байсан гэж үзэж байна.

Дээрх дүгнэлтийг үндэслэн бид дараах зөвлөмжийг гаргаж байна.

## **УИХ, Засгийн Газарт**

Улс төр, эдийн засгийн хараат бус байдлыг илүү хангах, ил тод, нээлттэй байдлыг хөхиулэн дэмжих, хариуцлага, тайлагнах чадварыг дээшлүүлэх чиглэлээр Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийг (цаашид хууль гэх) сайжруулж, боловсронгуй болгох шаардлагатай байна. Энэ чиглэлд доорхи зөвлөмжийг анхааралдаа авахыг уриалж байна.

## **ЗӨВЛӨМЖ**

### *Монголын Үндэсний Радио Телевиз*

1. МҮОНРТ-ийн эдийн засгийн хараат бус байдлыг нэн яаралтай хуульчлан бататгах. Хуулийн үзэл баримтлал, мөн чанарын хувьд МҮОНРТ хэзээ ч төрийн сангийн нэг хэсэг байж болохгүй.
2. МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөл өөрийн төсөв, цалингийн санг баталж, ажиллагдынхаа цалин хөлсний хэмжээг тогтоодог байх нь зүйд нийцэх тул хуульд зохих өөрчлөлт оруулах. Засгийн Газар ямар ч хэлбэрээр МҮОНРТ-ийн үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөх ёсгүй.
3. Үндэсний Зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох явц ил тод, нээлттэй байх ёстой тухай манай байгууллага өмнө нь байнга сануулж байсан. Олон нийт МҮОНРТ-тэй холбоотой аливаа алхам, шийдвэрийн тухай зохистой мэдээлэлтэй байж гэмээнэ жинхэнэ ёсоор хяналт тавих боломж нь бүрдэнэ. МҮОНРТ-ийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь нэн тэргүүний зорилтын нэг юм.
4. Хуулийн 26-р зүйлд зайлшгүй нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай. ҮЗ-ийн бүрэлдэхүүнд байн байн халдах нь тогтвортой, хараат бус ажиллахад буруугаар нөлөөлөх нь мэдээж. Гэсэн ч ҮЗ-ийн гишүүдэд хүлээлгэх хариуцлага илүү чанга байвал зохино. Тухайлбал, “энэ хуулийн заалтуудыг ноцтой зөрчсөн” үед дарга, гишүүнийг, “аливаа асуудлаар турван хурал дараалан

шийдвэр гаргаж чадахгүй” бол ҮЗ-ийг бүрэлдэхүүнээр нь эгүүлэн татах” гэсэн заалтыг нэмж оруулах, хуулийн 26.1.5-д заасан “ 6 сараас дээш хуралд биечлэн оролцоогүй бол” гэснийг 3 сар болгож богиносгох нь зүйтэй.

5. Гэхдээ эгүүлэн татах дээрх нөхцөл Хяналтын зөвлөлийн үндэслэлтэй зөвлөмжийн үндсэн дээр хэрэгжих ёстой. Хяналтын зөвлөлийн гишүүдийн тоог нэмэгдүүлж, нийгмийн янз бүрийн бүлэг, хамт олноос бүрдүүлэх нь чухал.
6. Хяналтын зөвлөлд ҮЗ-ийн гишүүдийг оролцуулахгүй байхаар хуульчлах, уг зөвлөлтэй холбогдох харилцааг зохицуулж буй зөрчилтэй заалтуудыг өөрчлөх.
7. Хуулийн 27-р зүйлд заасан Гомдол шалгах хорооны эрх үүрэг, үйл ажиллагааны зохицуулалтыг түүний мөн чанар, олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн өөрчлөх .
8. Хуулийн 31.6.5-р зүйлийг сонгон шалгаруулалт нь зөвхөн “дэд захирал, бусад захиралд” хамаарч байхаар өөрчлөх ёстой. Зохион байгуулалтын нэгж гэдэг нь хэтэрхий ерөнхий томъёолол учир бүх редакци, үйлдвэрлэлийн нэгж, алба, тэр бүү хэл, үйлчлэгч, жолооч нарыг нэгтгэсэн нэгж байдаг бол тэдгээрийн даргыг ч сонгон шалгаруулах мэт ойлгогдож байгааг анхаарна уу.
9. ҮЗ ажиллагсдын ёс зүйн дүрмийг боловсруулах тухай хуулийн 24.1.1-р зүйлийг эргэж үзэх шаардлагатай. Угтаа ажиллагсдын ёс зүйн дүрэм гэдэг нь буруу томъёолол гэж үзэж байна. Ёс зүйн дүрэм нь сэтгүүлч, тухайлбал мэдээлэл цуглуулах, боловсруулах, түгээх ажил эрхэлдэг хүмүүст илүү хамаатай. Хэрэв техникч, үйлчлэгч, жолооч зэрэг бусад ажил мэргэжлийн хүмүүсийн ёс зүйн асуудлыг ихээхэн ноцтой гэж үзэж байгаа бол хөдөлмөрийн гэрээгээр зохицуулж болно. Ер нь Ёс зүйн дүрмийг ҮЗ батлана гэдэг нь эргэлзээтэй. Ёс зүйн дүрэм бол мөн хэвлэл мэдээлийн өөрийн зохицуулалтын нэг хэлбэр тул сэтгүүлчид өөрсдөө баталж даган мөрдөх ёстой. Ес зүйн дүрмийг боловсруулах, батлах зэргээр ҮЗ хутгалдан оролцох нь үүнийг хэт албадлагын шинжтэй болгож, уг хуулиар баталгаажсан сэтгүүлчийн хараат бус байдалд удирдлагаас ноцтой нөлөөлөх, дарамт шахалт үзүүлэх нөхцөл бүрдүүлж болзошгүй. Гомдол шалгах хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй иргэний маргааныг хэлэлцэх, шийдвэрлэхдээ ҮЗ тухайн сэтгүүлч Ёс зүйн дүрмээ баримталсан эсэхээр дүгнэлт гаргахад л хангалттай.
10. ҮЗ-ийн бүрэлдэхүүнийг санал болгох, нэр дэвшигүүлэх харилцааг зохицуулсан уг хуулийн 21.6 зүйлийг хасахыг бид дахин шаардаж байна. Бидний өмнө өгч байсан саналыг хүлээн авч УИХ-аар хэлэлцсэн хуулийн төслөөс хассан ч Ерөнхийлөгчийн хоригийн

дараа дахин оруулж баталсан нь харамсалтай байна. Гишүүд тодорхой чиглэлээр мэргэшсэн байх нь зүйтэй боловч ийм мэдлэг боловсрол, дадлага туршлага хөтөлбөрийн бодлого боловсруулахад илүү чухал юм. Ийм ч учраас олон улсын хэмжээ, бусад орны практикт ийм шинжээчдээр бүрдсэн Зөвлөх хороо байгуулдаг. Жишээ нь, Би-Би-Си, Эн-Эйч-Кей нь тус бүр 110 хүний бүрэлдэхүүнтэй Зөвлөх хороотой байдаг.

ҮЗ-ийн гишүүд бол харин удирдлага, эдийн засаг, сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн чиглэлээр мэргэшсэн, иргэний нийгэмд ажилласан туршлагатай байх нь зүйтэй.

Дээр дурдсаныг үндэслэн хуулийн 8.5-р заалтыг заавал Зөвлөх хороотой байхаар өөрчлөх. Гишүүдийн тоог нэмэх нь зүйтэй.

11.Хуульд улс төрийн намын төлөөллийг хязгаарласан тодорхой заалтыг зайлшгүй нэмж оруулах нь зүйтэй. Жишээ нь, Японы Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн удирдах зөвлөлд нэг намын төлөөллийг 30 хувиар хязгаарласан байдаг.

#### *Орон нутгийн өргөн нэвтрүүлэг*

12. Хуулийн 5-р бүлгийг бүхэлд нь хасах санал тавьж байна. Үүний оронд МҮОНРТ орон нутагт салбартай байх, эдгээр салбар орон нутагтаа өргөн нэвтрүүлэг эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн хуулийн заалт хэрэгтэй.

#### *Арилжааны өргөн нэвтрүүлэг*

13. Арилжааны, кабелийн болон бусад хэлбэрийн өргөн нэвтрүүлгийн эрх зүйн орчныг яаралтай бүрдүүлэх шаардлагатай байна. Эдгээртэй холбоотой олон асуудал орон нутгийн түвшинд, үндэсний хэмжээнд ч хуриимлагджээ. Ялангуяа орон нутаг дахь кабелийн суваг, МҮОНРТ-ийн хоорондын санхүүгийн харилцааны асуудлыг яаралтай шийдвэрлэх нь зүйтэй байна. Ингэхгүй бол орон нутагт үйлчилгээний төлбөр хураах, төвлөрүүлэх нь улам хүндрэлтэй болж, МҮОНРТ-ийн эдийн засгийн байдалд бодитой хохирол учирч болзошгүй байна.

Дээр дурдсан нэмэлт өөрчлөлтийг хийхдээ мэргэжлийн болон төрийн бус байгууллага, МҮОНРТ-ийн удирдлага, хамт олонгийн зөвлөлдөж, анхааралтай, нягт нямбай ажиллахыг зохих байгууллагуудад зөвлөж байна.

#### **Монгол Улсын Дээд Шүүхэд**

Одоо үйлчилж буй хуулийн маргаантай байгаа зарим зүйл заалтыг Дээд Шүүхийн тайлбараар шийдэж болно гэж бодож байна.

Дээд Шүүх хуулийн Мэдээлэл олж авах, мэдээллийн эх сурвалжийг нууцлах тухай 34-р зүйлд бүхэлд нь тайлбар гаргахыг зөвлөж байна. Хуулийн заалтууд ОНРТ-ийн хуулийн үзэл баримтлал, зарчим, зорилго, зүйл заалтыг хэрэгжүүлэх, ялангуяа МҮОНРТ-ийн сэтгүүлчдийн хараат бус үйл ажиллагааг баталгаажуулахад нэн чухал билээ. Гэвч бусад оронд тусгай хуулиар баталгаажуулдаг эдгээр эрхийг энэ хуульд нэлээн тунхаг маягтай хуульчилж, нарийн зохицуулалт хийгээгүй нь амьдралд хэрэгжихэд хүндрэлтэй юм.

### **Үндэсний Зөвлөл, Түр Хороонд**

Бие биедээ дайсагнасан, үл эвлэршгүй, хөндий хүйтэн харилцаа хэзээ ч МҮОНРТ-ийг хөгжил цэцэглэлтэд хүргэж чадахгүй гэдгийг Үндэсний Зөвлөл, Түр Хороо ойлгож, ухамсарлана гэдэгт итгэж байна. Гагцхүү олон нийтийн эрх ашгийн төлөө хамтран зүтгэж, харилцан бие биедээ итгэх нь шилжилтийн энэ ээдрээтэй нөхцөлд голлох үүрэг гүйцэтгэнэ. Та бүхний салангид байдал, үл ойлголцол нь МҮОНРТ-д төдийгүй та бүхний мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх, зугаацуулан цэнгүүлэх ёстой тэр олон нийтэд хор хохирол учруулна.

#### Үндэсний Зөвлөлд

- Бид та бүхнийг хоёр хороог баталсан дүрмийн асуудлаар Түр Хороотой нэгдсэн ойлголтод хүрэхийг уриалж байна.
- Дэд захирал, газрын захирлуудыг томилсонтой холбоотой маргааныг ҮЗ нэн даруй анхааралдаа авч, шүүхийн шийдвэрийг хүндэтгэхийг зөвлөж байна.
- Хяналтын зөвлөлийн гишүүдээ нэн яаралтай эгүүлэн татаж, ҮЗ-ийн гишүүн бус хүмүүсээр бүрдүүлэхийг эрхэмлэн үйл ажиллагааг нь зөв гольдролд оруулна гэдэгт гүнээ итгэж байна.
- ҮЗ, МҮОНРТ-ийн удирдлага үйл ажиллагаандaa хамт олны, олон нийтийн оролцоог илүүтэй хангаж, ойрын хугацаанд байгууллагынхаа ойрын болон хэтийн стратегийг боловсруулж батлахыг зөвлөж байна.

#### Түр Хороонд

Бид МҮОНРТ-д ажиллагсдыг эрхийг гүнээ хүндэтгэж байна. Гэхдээ та бүхэн хуулиар олгогдсон хараат бус байдал, эрх чөлөөгөө ухамсарлан ойлгох ёстой.

Та бүхний өөрсдийн асуудлыг улс төрчдийн оролцоотойгоор шийдвэрлэх гэсэн аливаа нэг бодлогогүй алхам ирээдүйд хортой үр дагавар учруулж болозошгүй. Өөрсдийнхөө асуудлыг өөрсдөө шийдвэрлэх зохистой, ухаалаг өөр арга зам олдоно гэдэгт итгэж байна.

Та бүхнийг зүгээр нэг асуудал үүсгэж бужигнуулахыг урьтал болголгүй, илүү зохион байгуулалттай, мэргэжлийн түвшинд ажиллаасай

гэж хүсэж байна. Түр Хорооны шаардлага нь тодорхой, ямар нэг цуурхал, хардалтад бус харин тодорхой баримтад үндэслэгдсэн байх ёстай.

МООНРТ-ын удирдлага, бие даасан студиуд өөр өөрийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлсэн гэрээ хэлцээ, тохиролцоонд хүрч чадна гэдэгт бид бас итгэж байна. Гэхдээ ийм гэрээ хэлэлцээнд олон нийтийн ашиг сонирхол жин дарах ёстайг сануулъя..

Та бүхэн иргэний нийгмийн салшгүй хэсэг болсон олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд ажиллаж байгаа билээ. Ийм учраас ОНМХ-ийн үүрэг зорилт, хүсэл зориг, үйл ажиллагаа, удирдлагын үндсэн зарчим нь иргэний нийгмийн байгууллагуудтай адил төстэй байдаг. ОНМХ жинхэнэ хараат бус, тогтвортой байж гэмээнэ нь олон нийтийн хоточ нохой байх үүргээ зохих хэмжээнд гүйцэтгэж чадна.

Шилжилтийн энэ ээдрээт үеийг нэр төртэй, гарз хохирол багатай даван туулж, амжилтад хүrnэ гэдэгт бид итгэж байна.

#### **Донор болон олон улсын бусад байгууллагад:**

Олон улсын, Засгийн газар дундын, мөн донор байгууллагуудад хандан МООНРТ-ын шижлтийн энэ хүнд үед дараахь чиглэлээр тусlamж үзүүлэхийгuriалж байна.

- Техник технологийн шинэчлэл хийх
- Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, лоббидох
- Дээд шүүхийн тайлбар гаргах
- Мэргэжлийн сургалт зохион байгуулах, стратеги боловсруулах, маркетингийн судалгаа хийх, хөтөлбөр төлөвлөлт зэрэг тодорхой чиглэлээр олон улсын зөвлөх ажиллуулах зэргээр удирдлага, хамт олны чадавхийг дээшлүүлэх
- Ажиллагсдын эрх ашгийг хамгаалах хүчтэй үйлдвэрчний байгууллага байгуулах
- Хуулийн хэрэгжилт, үйл ажиллагаа, нэвтрүүлгийн бодлогод олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх
- Олон нийтийн анхаарлын төвд байдаг нийгмийн тулгамдсан асуудлаар томоохон цар хүрээтэй нэвтрүүлэг бүтээх
- Гадаадын бусад өргөн нэвтрүүлэгч байгууллагатай мэдээлэл туршлага солилцох

Улаанбаатар хот. 2006 оны 10-р сар.

#### **Сэтгүүлчдийн биеийн эрх чөлөөнд халдсан хэрэгт хийсэн судалгаа**

Хэргийн судалгаа

Хавсралт № 2.1

Г.Батжав  
“Eagle” телевиз

“Eagle” телевизийн сурвалжлагч Г.Батжавыг 2005 оны 11 сарын 10-ны бямба гарагт 12 цагийн үед “Аура” ресторанд үйдийн цайгаа ууж байтал үл таних хүмүүс зодож танхайран үүдэн талын доод хоёр шүдийг нь унагаж гэмтээсэн байна. Дараа нь буюу 2005 оны 12 сарын 19-20-нд шилжих шөнө гэрийнхээ гадаа тавьсан суудлын машиныг нь эвдэлж, эд хөрөнгийн хохирол учруулжээ. Машиныг нь эвдэлсэн этгээдүүд машинаас нь ямар нэг эд зүйл огт хулгайлж аваагүй, мөн зодож гэмтээсэн этгээдүүд түүнээс ямар нэгэн эд зүйл, мөнгө төгрөг нэхээгүй байна.

“Өдрийн сонин” сонины 2005 оны 12 сарын 24-ний өдрийн дугаарт гарсан **“Тагнуул, татвар, нийгмийн даатгалын хэлтэсийнхэнтэй холбоотой нууц материалыг олонд дэлгэнэ”** гарчигтай (ярилцлага) нийтлэлд сэтгүүлч Г.Батжав: “...**“Аура” ресторанд 12 цагийн үед ганцаараа хоол идэхээр сууж байсан юм.** Гэтэл араас хэн нэгэн хоолой боосон. Бачимдаад амьсгаа ч авч чадахгүй болоход элэг рув нэг цохисон. Дараа нь нүүр рув цохисон. Энэ явдал маш богино хугацаанд 30-40 секундэд болж өнгөрсөн. Тэр хүн **“Наад хийж байгаа ажлаа боль”** гэдэг угийг хэлчихээд гарч явсан, ...**2005 оны 12 сарын 19-20-нд шилжих шөнө гэрийнхээ гадаа тавьсан машиныг маань хүн харахын эцэсгүй болгочихсон байсан.** Хоёр талын толиийг нь хугалж жолоочийн талын шилийг нь хага цохичихсон. Машин доторх урд талын салоныг хага цохихыг нь цохиж, хугалахыг нь хугалж найгүй болгочихсон. Жолоонд холбоотой цахилгаан утсуудыг нэг нэгээр нь тасалчихсан гэх мэтээр ямар ч асах боломжгүй болгосон байсан. Машины гадна талыг, нь хүртэл хүнд зүйлээр цохиж хорлосон. Ингээд тэр даруйд нь цагдаад хандсан. Дөрвөн хүний хурууны хээ илэрсэн гэсэн” гэж уг ярилцлагад хэлжээ.

<http://www.olloo.mn/modules.php?name=News&file=article&catid=200&sid=18812>

Сэтгүүлч Г.Батжав бусдад зодуулсан асуудалдаа цагдаагийн байгууллагад гомдол гаргаагүй, харин машиныг нь эвдэлсэн үйлдэлд гомдол гаргасан байна. Энэ хэргийг СБД-ийн Цагдаагийн хэлтэст Эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа. Тус цагдаагийн хэлтсийн Хэрэг бүртгэх тасгийн дарга хошууч Г.Эрдэнэбаяатарын хэлснээр “ЭБШХ-ийн 205.1.1-д зааснаар Яллагдагчаар татагдвал зохих этгээд тогтоогдоогүй гэсэн үндэслэлээр хэргийг түдгэлзүүлсэн” байна. Тухайн эрүүгийн хэргийг хэдийд, ямар зүйлээр үүсгэсэн тухай холбогдох албан тушаалтнуудаас албан ёсны мэдээлэл авахыг хүссэн боловч татгалзсан хариу өгсөн юм. Хэрэг бүртгэх тасгийн дарга хошууч Г.Эрдэнэбаяатар “тухайн хэргийг **шалгаж байгаа хэрэг бүртгэгч ахмад Баттөмөрөөс асуу**” гэв. Ахмад Баттөмөр “**хяналт тавьж байгаа прокурор Хүдэрцэцэгээс зөвшөөрөл ав**” гэв. Прокурор Хүдэрцэцэг “**эрүүгийн хэргийн мэдээ баримт нь хувь хүний нууцад хамаарч болох үндэслэлтэй тул хэлэх боломжгүй**” гэсэн хариунуудыг өгсөн учраас үүнийг мэдэх боломж мухардсан.

Эдгээр үйл явдал болохоос өмнө тэрээр Нийгмийн даатгал, Татвар, Тагнуулийн салбарын хууль бус үйл ажиллагаа, хээл хахуулийн тухай эрэн сурвалжилж, телевизийн нэвтрүүлэг хийхээр бэлтгэж байжээ.

“Өдрийн сонин” сонины 2006 оны 02 сарын 10-ны №035 (2169)-т “Г.Батжав гэмт халдлагад өртсөн болж жүжиглэн, бусдыг гүтгэсэн үү” гарчигтай Нийгмийн даатгалын газрын дарга С.Эрдэнэтэй хийсэн ярилцлага гарч, уг ярилцлагын өмнөтгөлд “...түүнийг С.Эрдэнэ ч юм уу **хэн нэгэн бусдыг хөлсөлж зодуулсан биш**, харин ч тэрбээр амрагийн холбоотой хүүхнийхээ дүүд зодуулсан, машиныг нь мөн **хэн нэг нь сүйрүүлсэн бус зүгээр л хулгайд ганц нэг эд ангия алдсан** нь нотлогдож байгаа гэнэ. Харин тэр **сэтгүүлч гэх залууд ийнхүү сенсаац дэгдээх шалтгаан нь MAXH-аас авсан 10 сая төгрөгт** байгааг эх сурвалж нуусангүй...” гэжээ. Үүний дараагаар “Eagle” телевиз сэтгүүлч Г.Батжавыг 10 сая төгрөгийн шан харамж авсан эсэхийг шалгах зорилгоор ажлын хэсэг байгуулан ажилласан. Уг ажлын хэсэг “Глоб интернэшнл” ТББ-ыг уг ажилд хөндлөнгийн ажиглагчаар оролцохыг хүссэн. Энэ баг тус мэдээллийг хийсэн “Өдрийн сонин” сонины сэтгүүлч С.Энхтуулыг нийтлэлийнхээ үнэн бодитой эсэх, хаанаас энэ мэдээллийг олсон эсэхийг тодруулахад тэрээр “мэдээллийнхээ эх сурвалжийг нууцлана, миний хийсэн мэдээлэл үнэн бодитой” гэсэн байр суурийг илэрхийлсэн.

Г.Батжавын бэлтгэсэн нэвтрүүлэг дэлгэцэнд гараад удаагүй байтал буюу 2006 оны 01 сарын 09-нөөс 02 сарын 01-нийг хооронд Нийгмийн даатгалын байгууллагад Нийслэлийн 9 дүүргийн 2005 оны үйл ажиллагааны хүрээнд **“Нийгмийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, төсвийн хөрөнгийн ашиглалт”** гэсэн Аудитын шалгалтыг Нийслэлийн аудитийн газраас хийсэн байна. Энэхүү “аудитын шалгалтын ерөнхий дүгнэлт нь Сангийн орлого өмнөх оноос 16,4%-иар өссөн ч орлого нэмэгдүүлэх боломжуудыг бүрэн ашиглаагүй байна” гэж гарчээ. Аудитын тайлангаас дурдвал нийслэл дүүргийн хэмжээнд 200000 гаруй иргэдийн тэтгэврийн нэрийн дансанд зохих сангийн мөнгө байхгүй, шимтгэлийн өрөнд зах зээлийн үнээс хэт өндөр үнэтэй, хэрэгцээ шаардлага хангахгүй, борлогдохгүй бараа, эд хөрөнгө авч, улсыг хохироодог, зарим хөрөнгийг бүртгэлд тусгадаггүй, өрөнд авсан орон сууцуудыг байцаагч нарт хуваарилан өгсөн боловч мөнгийг хураан авч сандаа төвлөрүүлээгүй зэрэг маш олон зөрчил дутагдууд илэрсэн байна.

<http://www.city.audit.mn/index.php?huudas=subcontent&id=55>

Ийнхүү нийгмийн даатгалын байгууллагад аудитын шалгалт хийж санхүүгийн ноцтой зөрчил дутагдууд байгааг тогтоосны дараа тус байгууллагын дарга С.Эрдэнэ өөрөө сайн дураараа албан тушаалаасаа огцорсон.

2005 оны 12 сарын 10-нд энэ хэргийн тухай “Eagle” телевизийн захирал Том Терригийн веб сайтад “сэтгүүлч Г.Батжавыг гэмт халдлагад өртөж эрүүл мэнд болон эд хөрөнгөөрөө хохирсон” гэсэн мэдээ гарсан байсан. Гэтэл хэсэг хугацааны дараа “Батжавыг өөрийн хийж байсан

мэргэжлийн үйл ажилгаатайгаа холбоотой бус ахуйн сэдэлттэй маргааны улмаас бусдад зодуулсан юм байна” гэсэн тайлбарыг хийсэн нэмж байна. <http://terrycom.net>

Хэрвээ Батжавын эрх чөлөөнд халдсан этгээдүүд түүний хийж байсан мэргэжлийн ажилтай нь холбогдуулан гэмт үйлдэл хийсэн бол Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 139 дүгээр зүйлд заасан сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийх гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангасан байх үндэслэлтэй юм. Сэтгүүлч Батжавын эрх чөлөөнд халдсан этгээдүүдийг олж тогтоогоогүй, мөн түүний эрх чөлөөнд халдсан сэдэлт, зорилгыг тогтоогоогүй байхад хэн нэгнийг түүний эсрэг зохион байгууллалттайгаар ажил мэргэжилтэй нь холбогдуулан халдаж гэмт хэрэг үйлдсэн эсэх дээр хөндлөнгийн дүгнэлт өгөх боломжгүй байна.

Хуульч Г.Даваахүү

Хавсралт № 2.2

Хэргийн судалгаа

**Бямбадоржийн Цэвэгмид, сэтгүүлч  
2006 оны 07 сарын 06-ны өдөр,  
үзэл бодлоо илэрхийлсний төлөө халдлага**

Орхон аймгийн “Номин” телевизийн редактор, сурвалжлагч Бямбадоржийн Цэвэгмидийг 2006 оны 07-р сарын 05-06-нд шилжих шөнийн 24 цагаас 01 цагийн үед ажлаа тараад гэртээ орохоор явж байхад орцонд нь үл таних хүн зодож эрүүл мэндийг нь ноцтой хохироосон байна.

Сэтгүүлч Б.Цэвэгмид тухайн шөнө маш их айсан бөгөөд цагдаагийн байгууллагад маргааш өглөө нь гомдол гаргасан байна. Түүний гомдлыг үндэслэн цагдаагийн байгууллага Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйл<sup>1</sup>-ээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205.1 дүгээр зүйлд зааснаар “яллагдагчаар татагдвал зохих этгээд тогтоогдоогүй” гэсэн үндэслэлээр хэргийг түдгэлзүүлсэн байна.

“Номин” телевизийн сэтгүүлч Б.Цэвэгмид нь цаг үеийн мэдээ, сурвалжлага, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төрлөөр дагнан ажилладаг бөгөөд Эрдэнэтийн хүүхэд залуучуудын Паркийн шинэчлэл, Эрдэнэтийн нэгдсэн эмнэлэгийн морг, Эрдэнэтийн Уулын Баяжуулах Үйлдвэрийн 9000 ажилчны хөрөнгө оруулалтын эрхийн бичигтэй холбоотой хууль бус үйл ажиллагаануудын тухай “Үзэхийг хориглоно” нэртэй нэвтрүүлэг бэлтгэж

<sup>1</sup> Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйл. Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх. Өөрийн болон бусдын ашиг сонирхолыг хөндсөн аливаа мэдээ, мэдээллийг тараах болон тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучин нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

“Номин” телевизийн сувгаар гаргажээ. Тэрээр Эрдэнэтийн Уулын Баяжуулах Үйлдвэрийн 9000 ажилчны хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн тухай нэвтрүүлгийг бэлтгэж байхдаа дээрх үйлдвэрийн ажилчдын хөрөнгө оруулалтын эрхийн бичгийг хадгалж байсан Орхон аймгийн “Эрдэнэс” брокерийн компанийн захирал асан Амаржаргалаас ярилцлага авахад “Та нар бодит мэдээлэл цацах ёстой, хамаагүй юм мэдээлж байж алуулав, энэ чинь их хэцүү асуудал шүү” гэж заналхийлснийг уг нэвтрүүлгээрээ гаргасан байна. Үүнээс хойш түүнийг үл мэдэгдэх хүмүүс хоёр ч удаа утсаар заналхийлжээ. Мөн түүнийг утсаар заналхийлсний дараа гэртээ орохоор шөнө 23.00 цагийн үед явж байтал орцонд нь хоёр залуу барьж аваад “Ясан сүрхий юм бичдэг юм бэ, чи гээд зодох гэж дайрсан тэр агшинд доороос хүн орж ирэх чимээгээр тэд үйлдлээ зогсоогоод зугтаасан” гэж “Шинэ мэдээ” сонини 2006 оны 07 сарын 14-ний өдрийн №27-д бичжээ.

Тус хэргийг Монголын ардчилсан нийгэм дэх хэвлэлийн эрх чөлөөний эсрэг маш ноцтой хэрэг гэж үзэн “Глоб интернэшнл” ТББ-ын хуульчид Орхон аймгийн Эрдэнэт хотод очиж газар дээр нь уг хэргийн талаар судалсан билээ. Судалгааг хийх явцад уг хэргийн талаар мэдэх болон холбогдох байгууллагын албан тушаалтуудтай уулзаж асууж тодруулсан юм. Үүнд “Номин” телевизийн захирал И.Баасанжав:

- “Сэтгүүлч зодуулснаасаа болж нэг хавирга нь хугарсан, тархины 1-р зэргийн гэмтэлтэй, нугаснаас ус авах шаардлагатай гэсэн оноштойгоор Орхон аймгийн Гэмтлийн эмнэлэгт эмчлүүлсэн. Энэ хувьцаатай холбоотой сэдэв бол манай телевизэд арай ахадсан асуудал юм байна. Энэ сэдвийг манайхаас илүү хүчтэй хэвлэл мэдээллийн байгууллагуудын хийх ажил юм шиг санагдсан, гэхдээ манай сэтгүүлч Б.Цэвэгмид өөрөө зориглоод хувьцаатай холбоотой асуудлаар ажиллана гэвэл бид татгалзахгүй” гэв.

Шүүх эмнэлгийн шинжээч эмчийн дүгнэлтэнд “гавал тархины битүү гэмтэл, тархины эдийн нэгдүгээр зэргийн няцрал, цээжний баруун талд суганы арын шугамаар дөрөвдүгээр хавирганы хугарал гэмтэл учирсан байх бөгөөд энэ нь гэмтлийн хөнгөн зэрэгт хамаарна” гэсэн байна. Гэхдээ Орхон аймгийн хэмжээнд Гэрэлмаа эмч шүүх эмнэлгийн шинжээч эмчийн ажлыг ганцаараа хариуцан ажилладаг. Тухайн хэрэг гарах үед шинжээч эмч Гэрэлмаа өөрөө ээлжийн амралттай байсан бөгөөд түүнийг орлож өөр эмч ажиллаж байсан гэж Гэрэлмаа эмч хэлсэн. “Глоб интернэшнл” ТББ-ын хуульч Г.Даваахүү “дээрх гэмтэл биед нь учирсан хүнд хэрвээ та шинжээч эмчийн дүгнэлт гаргасан бол ямар дүгнэлт гаргах байсан бэ?” гэж асуухад Гэрэлмаа эмч “хэрвээ би өөрөө дүгнэлт гаргасан бол хүндэвтэр гэмтлийн зэрэгт хамааруулж болно. Гэхдээ хавирганы хугарлын хэр хэмжээг нарийн судалсны эцэст хөнгөн эсхүл хүндэвтэр гэмтлийн зэргийн алийг сонгохоо шийдэх байсан” гэж байлаа.

Сэтгүүлч Б.Цэвэгмид хэлэхдээ “үнэний төлөө явсан хүн өөрөө ямар нэг золиос төлдөг юм байна гэдгийг ойлгосон, гэхдээ би одоо айхгүй, цаашид энэ хувьцааны тухай сэдвийг үргэлжлүүлэн судалж нэвтрүүлгээ бэлтгэх болно, тухайн үед орц харанхуй байсан учраас хэдэн хүн байсан болон өөрийг нь зодсон хүний гадаад дүр төрхийг харж чадаагүй” гэсэн.

“Цаг үеийн гал цогтой мэдээ, сурвалжлага, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төрлөөр дагнан шударга хөдөлмөрлөж явсан сэтгүүлч маань юуны учир ийнхүү эрүүл мэндээрээ хохирох хэмжээнд хүрэв гэдэгт Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл /МСНЭ/-ийн Орхон аймаг дахь салбар дүгнэлт хийн “Энэ бол яах аргагүй үнэний төлөө тэмцэгч сэтгүүлчийн дуу хоолойг боомилох гэсэн балмад халдлага” гэж үзжээ. Тиймээс 7 сарын 6-ний өдөр аймгийн Тамгын газрын ажлын танхимд Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй бүх хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтнууд, Цагдаагийн газрын олон нийттэй харилцах албаны дарга х/ч Д.Оросоо, Цагдаагийн газрын хэв журмын тасгийн дарга х/ч Ц.Амаржаргал нарыг байлцуулан хэвлэлийн бага хурал хийсэн бөгөөд цагдаагийн байгууллагын зүгээс “...олны анхаарал татсан, эгзэгтэй асуудлыг хөндсөн нийтлэл, нэвтрүүлэг, явуулах бүрийд сэтгүүлчдийн байгууллагын хүсэлтээр цагдаагийн газар тухайн уран бүтээлчдийг хараа хяналтдаа авч ийм балмад үйлдлийг дахин давтагдуулахгүй байхад онцгой анхаарна” гэжээ (Шинэ мэдээ сонин, 2006.07.14, №27).

“Сэтгүүлчид ... хүний нэр төрд бүдүүлгээр огт халдаагүй, гужирдэж гүтгээгүй бөгөөд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн зарчмаар нийгэмд бугшиж байгаа гэмт хэргийн шинжтэй байж болох, луивар булхайтай үйлдлийн талаар нийгмийн өмнө хүлээсэн үүргээ эр зоригтой гүйцэтгэж, мэргэжлийн сэтгүүл зүйн хүрээнд нийтэд мэдээлсэн гэж МСНЭ-ийн Орхон аймгийн салбар үзэж байна” гэжээ.

Тус хэргийг шалгаж байгаа Орхон аймгийн Цагдаагийн газрын Хэрэг бүртгэх тасгийн дарга цагдаагийн дэд хурандаа Я.Мөнхдэлгэр “энэ хэргийг эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлээр зүйлчилсэн нь маш буруу гэж би үзэж байгаа, яагаад гэвэл сэтгүүлч гэдэг ажил мэргэжил, хийсэн ажилтай нь холбогдуулан эрх чөлөөнд нь халдсан гэдгийг тогтоогоогүй байхад шууд ингэж зүйлчлэх шаардлага огт байхгүй, харин эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйл буюу Танхайрах гэмт хэргээр зүйлчилж болох байсан, одоогоор манай цагдаагийн байгууллагын зүгээс уг хэргийг илрүүлэхийн тулд гүйцэтгэх ажлын шугамаар тодорхой ажиллагаанууд хийж байгаа, хэрэг гарсны дараахан хохирогчийг заналхийлсэн Эрдэнэс брокерийн пүүсийн захирал асан Амаржаргалыг уг хэрэгт сэргэж тодорхой хугацаагаар хорьж saatuulan шалгасан боловч түүнийг хэрэгт холбогдолтой эсэхийг тогтоож чадаагүй” гэлээ.

Хуульч Д.Мөнхбүрэн, Г.Даваахүү

### **Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэгт хийсэн судалгаа**

**International  
Federation  
of Journalists**

**International  
Federation  
of Journalists**

International  
Federation  
of Journalists

Хавсралт № 3.1

Хэргийн судалгаа

Г.Дашрэнцэн,  
“Дээдсийн хүрээлэн” сонин,

“Дээдсийн хүрээлэн” сонины Ерөнхий эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч, “Өдрийн сонин” сонины улс төрийн тоймч Г.Дашрэнцэнг буддын шашны лам Г.Пүрэвбатыг “Дээдсийн хүрээлэн” сонины 2005 оны 10 сарын №31 (449)-т “**Монголын төрд Н.Энхбаярын хар толбо нүүсээр байна**” гарчигтай нийтлэл хэвлүүлснийх нь төлөө хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан бусдыг доромжилсон (Эрүүгийн хуулийн 110), гүтгэсэн (эрүүгийн хуулийн 111) гэмт хэрэг үйлдсэн хэмээн 2006 оны 6 сарын 14-ний өдөр БЗД-ийн шүүхээс 2 сая 167500 төгрөгийн торгох ял шийтгэсэн байна.

Их Монгол улс байгууллагдсаны 800 жилийн ойг тохиолдуулан 2006 оны 6 сарын 23-ны өдөр УИХ-аас баталсан Өршөөлийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан үндэслэлээр сэтгүүлч Г.Дашрэнцэн ялаас чөлөөлөгджээ.

Нэр төр, алдар хүндэд хүндэд халдсан гэх сэтгүүлчийн нийтлэлд **Номч ламд олдоогүй цол хэргэм ясчин ламд тохиож Пүрэвбат гавьяат лам болсон түүхийн товч** гэсэн хөмсөг дор “Н.Энхбаяр ерөнхийлөгч болоод шоуч лам Пүрэвбатыг гавьяат лам болгосон. Н.Энхбаярын холбогдсон байж болох авилгын хэргүүд сонин телевизээр дэлгэгдэхэд шоуч лам Пүрэвбат улс төрд түүний сонгуульд оролцон Н.Энхбаярыг амьд бурхан мэт өргөмжлөн, бүх баримтуудыг гүтгэлэг гэж зарлан гавьяа байгуулсны хүчинд анхны гавьяат лам болсон. Пүрэвбатын бас нэг том гавьяа бол үй олноор нь нэг дор хоморголон устгасан түүхэн баримтыг үгүй хийсэн явдал юм. Тасганы овооноос олдсон үй олноор нь устгасан коммунист дэглэмийн гэрч болсон ар дагзаараа буудуулсан олон зуун лам

нарын гавлын яс одоо хaa ч байхгүй. Тэр олон зуун лам нарын гавлын ясыг музей болгоё, эдэн дотор эд эсийн шинжилгээ явуулж хэний хэн болохыг тогтооё гэж түүхч асан И-г хэлэхэд энэ цогцсуудыг гурил болгон суврага босгохгүй бол намын нэр хүндэд, цаашлаад миний нэр хүндэд халтай гэж Энхбаяр дарга хэлсэн гээд аймшигт аллагын түүхэн баримтыг гурил болгон устгасан гэж түүхч И ярьсан байдаг. Пүрэвбат гэдэг ясчин лам гавъяат болсон 2 дахь учир энэ буюу. Уг нь шарын шашны ёсоор номч лам нарыгаа хүндэлж зэрэг дэв олгодог ажээ. Чой хамба зэрэг номч ламд олдоогүй зэрэг дэв, цол хүндлэл ясчин ламд тохиосны учир олдож ерөнхийлөгчид зөвлөх боллоо...” гэх мэтээр бичжээ.

Үүний улмаас Г.Пүрэвбатын өмгөөлөгч Д.Оросоо 2005 оны 11 сарын 10-ны өдөр БЗД-ийн шүүхэд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд сэргээлгэх тухай нэхэмжлэл гаргасан байна. Улмаар 2005 оны 12 сарын 20-ний өдөр нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлж, дээрх нийтлэлийн улмаас Г.Пүрэвбатад учирсан гэм хорын хохиролд 30 сая төгрөг гаргуулахаар шаардсан байна.

Дараа нь 2006 оны 01 сарын 11-нд бурханч лам Г.Пүрэвбат өөрийн нэрээр дээрх нийтлэл нь **намайг доромжилж гүтгэсэн эрүүгийн гэмт хэрэг мөн гэж би үзэж байна гэж Цагдаагийн байгууллагад гомдол гаргажээ. Уг гомдолд “Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаярын нэр төрийг гутаан доромжлох, улс төрийн зорилгодоо төрийн хэргээс ангид жирийн нэгэн ламтан намайг хоморголон хямруулж, миний нэр төр, ажил үйлсийг санаатайгаар доромжлон гутааж байгааг миний эсрэг үйлдэж буй эрүүгийн гэмт хэрэг гэж үзэж байна.**

А) Пүрэвбат улс төрд түүний сонгуульд оролцон Н.Энхбаярыг амьд бурхан мэт өргөмжлөн, бүх баримтуудыг гүтгэлэг гэж зарлан гавъяа байгуулсны хүчинд анхны гавъяат лам болсон гэж миний нэр төр, алдар хүнд, хийсэн бүтээсэн хөдөлмөрийг үгүйсгэж мушгин гүйвуулжээ. Иймд хэрэв би төрд үнэлүүлэхүйц юм хийгээгүй байж нэг хүнийг магтсан гэдгээр гавъяат цол хүртсэн байгаа бол үүний үнэн мөнийг шалгуулан тогтоолгох нь зүйтэй.

Б) Пүрэвбатын бас нэг том гавъяа бол үй олноор нь нэг дор хоморголон устгасан түүхэн баримтыг үгүй хийсэн явдал юм. Тасганы овооноос олдсон үй олноор нь устгасан коммунист дэглэмийн гэрч болсон ар дагзаараа буудуулсан олон зуун лам нарын гавлын яс одоо хaa ч байхгүй. Тэр олон зуун лам нарын гавлын ясыг музей болгоё, эдэн дотор эд эсийн шинжилгээ явуулж хэний хэн болохыг тогтооё гэж түүхч асан И-г хэлэхэд энэ цогцсуудыг гурил болгон суврага босгохгүй бол намын нэр хүндэд, цаашлаад миний нэр хүндэд халтай гэж Энхбаяр дарга хэлсэн гээд аймшигт аллагын түүхэн баримтыг гурил болгон устгасан гэж түүхч И ярьсан гэж оп үндэсгүй гүтгэсэн байна. Иймд Н.Энхбаяр хэзээ хэнд үүрэг өгсөн болох, түүнийг нь би хэрэгжүүлж түүхэн баримтыг устгасан гэх гүтгэлгийг үнэн бодтоор нь шалгуулах шаардлагатай гэж үзэж байна” гэжээ.

Хавтаст хэргийн 76 дугаар хуудсан дахь сэтгүүлч Г.Дашрэнцэнгээс анх 2006 оны 1 сарын 27-ны өдөр асууж авсан тайлбарт “...өөрийн үзэл

бодлоо илэрхийлэн 1937 оны их хэлмэгдүүлэлтийн талаар хувийн дүгнэлтээ хийж бичсэн нь үнэн. Тэрнээс биш бурханч лам Г.Пүрэвбатын ажлын алдар хүнд, нэр төрд нь халдаж санаатайгаар доромжилсон үйлдэл огт биш бөгөөд улс төрийн нийтлэл юм. Хэрэв бурханч лам Пүрэвбатын нэр төрд халдаж доромжилсон гэж үзэж байгаа бол “Дээдсийн хүрээлэн” сониноор сэтгүүлчийн хувиар албан ёсоор учлалт гүйхад хэзээ ч бэлэн байна. Миний хувьд бурханч лам Г.Пүрэвбатыг урьд өмнө огт танихгүй, уулзаж учирч байгаагүй, хувийн ямар нэгэн өш хонзон байхгүй, харин зураач хүнийх нь хувьд залуу сайн зураач, уран бүтээлч гэж хүндэтгэж явдаг юм“ гэсэн байна. Энэ тайлбар нь дараа дараагийн сэжигтнээр байцаагдсан болон яллагдагчаар байцаагдсан мэдүүлгүүдэд энэ тайлбараа дахин давтан хэлж, улмаар учлалт гүйж байсан байна.

Энэ хэрэг дээр анх 2006 оны 02 сарын 01-ний өдөр Эрүүгийн хуулийн 110-ын 1 дэх “Доромжлох” гэсэн зүйлээр эрүүгийн хэрэг үүсгэжээ. Улмаар 2006 оны 02 сарын 22-ны өдөр Эрүүгийн хуулийн 111-ийн 2 дахь хэсэг “Гүтгэх” гэсэн зүйлийн гэмт хэрэг үйлдсэн хэмээн ял сонсгож яллагдагчаар татсан, дараа нь 2006 оны 4 сарын 13-ны өдөр Эрүүгийн хуулийн 110-ын 110.1 (доромжлох)-ийг нэмж ял сонсгосон байна. Ингэх болсон үндэслэл нь 2006 оны 02 сарын 23-ны өдөр Хэрэг бүртгэх газраас Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл Зохиолын хүрээлэнд хандаж “Ясчин гэдэг үг нь ямар зүйлийг илэрхийлж, ямар утга санааг агуулдаг, хэл шинжлэлд хэрхэн тайлбарладаг талаар тодорхойлж өгнө үү” гэсэн №291-82 тоот албан бичиг явуулсан. Үүний хариу 2006 оны 02 сарын 26-нд “...яс барих хэмээх нь хүндэтгэлийн утгатай бөгөөд ясчин гэж хар ярианд хэрэглэгдэнэ. ... Ясчин хэмээх үг нь олон салаа утгатай боловч түүнд доромж найруулгын өнгө аяс үгүй байна” гэжээ. 2003 оны 3 сарын 22-нд Г.Пүрэвбатын өмгөөлөгч Д.Оросоо хавтаст хэрэгт авагдсан “ясчин” гэдэг үгийг хэл шинжлэлийн хүрээлэнгээс гаргуулж авсан тайлбар нь албан ёсны шинжээчийн дүгнэлт бус жирийн нэг лавлагаа байна. Шинжээчийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 155, 157, 162 дугаар зүйлүүдэд заасан журмын дагуу хангаж албан ёсоор томилж өгөхийг хүссэний дагуу 2006 оны 3 сарын 27-нд ШУА-ийн Хэл Шинжлэлийн Хүрээлэн, Төрийн хэлний зөвлөл гэсэн хоёр байгууллагаас Хэл бичгийн ШУ-ны доктор, профессор Ш.Чоймаа, Л.Хүрэлбаатар, М.Базаррагчаа нарыг хамтран шинжилгээ хийлгэхээр томилжээ. Ийнхүү томилогдсон шинжээчид нь 2006 оны 4 сарын 6-нд дүгнэлтээ гаргаж “ясчин” гэдэг үг нь уг нийтлэлд орохдоо доромжилсон утгыг илэрхийлсэн байна гэжээ.

2006 оны 6 сарын 14-ний өдөр БЗД-ийн Шүүхэд уг хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцээд шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт “... Н.Энхбаяр бусдад үүрэг өгч аллагын түүхэн баримтыг гурил болгон устгасан гэж түүхч И ярьсан байдаг” гэсэн гутгэлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд тараасан гэмт хэргийг, ...ясчин лам гэж нийтийн өмнө хэвлэл мэдээллээр доромжилсон гэмт хэргийг үйлдсэн болох нь хавтаст хэрэгт цугларсан шүүхийн хэлэлцүүлгээр шинэчлэн судалсан нотлох баримтуудаар хөдөлбөргүй нотлогдож байна. Шүүгдэгч нь анх удаа хөнгөн, хүндэвтэр хэрэг үйлдсэн, үйлдсэн гэмт хэрэгтээ гэмшин хохирогч Г.Пүрэвбатаас учлал

гүйсан, биеийн эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан ял оногдуулах нь зүйтэй” гэсэн байна.

Гүтгэх гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлд томъёолоходоо “**хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол...**” гэсэн байна. Эндээс харахад “...нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор...” гэсэн энэ хэрэг нь Эрүүгийн хуулийн 26-ын 26-2 дугаар зүйлд заасан гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр үйлдэгдсэн байхыг шаардаж байна. Гэм буруугийн шууд санаатай хэлбэр гэдгийг “**Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж, түүний улмаас нийгэмд аюултай хор уршиг учрах нь зайлшгүй, эсхүл учрах боломжтойг урьдчилан мэдсэн атлаа хүсэж үйлдсэн бол...**” гэж заасан байдаг.

Эдгээрээс дүгнэн үзэхэд сэтгүүлч Г.Дашрэнцэнгийн үйлдэлд Эрүүгийн хуулийн Гүтгэх гэмт хэргээр зүйлчлэн ял оноосон үйлдэл эргэлзээтэй байна. Өөрөөр хэлбэл, гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр үйлдэгдсэн гутгэлэг гэж үзэхийн тулд Г.Дашрэнцэнгийн нийтлэл нь Г.Пүрэвбатын нэр төрд халдаж гэм хор учруулахыг хүсэж үйлдсэн гэдгийг нотлох шаардлагатай байхад зөвхөн нийтлэл нь үнэн бодит байдалд нийцэхгүй байна гэдгээр нь гүтгэх гэмт хэрэг үйлдсэн гэж ял шийтгэсэн маш буруу байна.

Гэвч Ардчилсан нийгэм дэх хэвлэлийн эрх чөлөөг хамгаалж гүтгэх болон доромжлох гэмт хэрэгт эрүүгийн хуулиар ял шийтгэхийн эсрэг Үзэл бодол, түүнийг илэрхийлэх эрх чөлөөний талаархи НҮБ-ийн тусгай илтгэгч, OSCE-хэвлэлийн эрх чөлөөний төлөөлөгч, OAS-ийн хэвлэлийн эрх чөлөөний тусгай илтгэгч нарын баталсан хамтарсан тунхаглалд “...эрүүгийн хуулиас гутгэлгийн эсрэг заалтуудыг хасч иргэй хуулиар зохицуулах хэрэгтэй”, “нэг талын гутгэгдсэн гэх гомдлын шаардлага нь эргэлзээтэй, нотлох баримт бүрэн бус, бол хэнийг ч гутгэлгийн эсрэг хуулиар ял тулгаж болохгүй”, “хорих, ял тэнсэх, аль нэг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр үзэл бодлоо илэрхийлэх, сэтгүүл зүйн болон бусад мэргэжлээр ажиллахыг түр түдгэлзүүлэх, хэт их тorgууль тавих буюу эрүүгийн бусад хатуу ял шийтгэл хариуцлагыг гутгэлгийн гэмт хэрэгт оногдуулахгүй, зөвшөөрөхгүй” гэсэн байдаг. Манай улсад цаашид хууль тогтоомжоо дээрх шаардлагад нийцүүлэн өөрчлөх шаардлага тулгарч байна.

Хуульч Г.Даваахүү

Хавсралт № 3.2

## Хэргийн судалгаа

Шийтгүүлсэн:	Д.Ганхуяг
Хохирогч:	О.Чулуунбаатар (Монгол банкны өрөнхийлөгч)
Дурдагдсан хүмүүс:	Н.Энхбаяр, одоогийн өрөнхийлөгч
Хэрэг үүсгэсэн огноо:	О.Цолмон, Энхбаярын эхнэр
Шийдвэрлэсэн огноо:	2005 оны 05 сарын 02-ны өдөр
Шийдвэрлэсэн акт:	2006 оны 07 сарын 08-ны өдөр
Шүүхийн харьялал:	Шийтгэх тогтоол, №60А
Хэргийн дугаар:	Чингэлтэй дүүргийн шүүх
Хэргийн зүйл хэсэг:	20539374
	111.2. Гүтгэх

Судлаач Дашцэвэгийн Ганхуяг нь “Монгол таймс” сонини 2005 оны 3 дугаар сарын 8 дугаарт Монгол улсаас Оросын Холбооны Улсад төлсөн их өрийн асуудлыг хөндөж, “**Их өр ..., 8 сая\$ ...., О.Цолмон?!**” нийтлэл бичсэнийхээ төлөө бусдын нэр төрийг гутаах зорилгоор илт худал гужирдлэгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд тараасан буюу эрүүгийн хуулийн 111-р зүйл (**гүтгэх**)-ийн 111.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдож, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 75 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу **3000000 /гурван сая/ төгрөгийн тортогх ялаар** шийтгүүлсэн. УИХ-ас 2006 оны 6 сарын 23-ний өдөр батлан гаргасан Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалтыг баримтлан Д.Ганхуягт оногдуулсан **ялыг өршөөн хэлтрүүлсэн** байна.

Уг нийтлэлд “**Их өрийн төлбөр хийгдэж байх яг тэр үеэр АНУ руу 8 сая ам.доллар** Монгол банкнаас шилжсэн байна. ... Хамгийн хачирхалтай бөгөөд сэжиг бүхий явдал нь энэхүү найман сая долларыг нэр дээрээ гүйвуулан авсан хүмүүсийн жагсаалтад тэр үеийн өрөнхий сайд одоогийн УИХ-ын дарга **Н.Энхбаярын эхнэр Цолモンгийн** нэр дурайтал бичигдсэн байх ажээ” гэж бичсэн.

**Монгол Банкны өрөнхийлөгч О.Чулуунбатын** “үнэн бодит байдалд нийцэхгүйгээр үл барам, миний нэр хүндийг санаатайгаар худал гүтгэн

гужирдэж, олон нийтэд тараасан байна” гэсэн **гомдоор** 2005 оны 05 сарын 02-ний өдөр эрүүгийн хэрэг үүсгэсэн. Үүнд улсын яллагчаас “гүтгэх” зүйл ангиар яллагчаар татах тогтоол дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Чингэлтэй дүүргийн шүүхээс 2006 оны 2 сарын 7-ний өдөр анхан шатны шүүх хуралдаанаар гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож **Цагаатгах тогтоол** гаргасан.

Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрч **улсын яллагч эсэргүүцэл бичсэнээр** хэргийг Нийслэлийн шүүх давж заалдах шатны журмаар дахин авч хэлэлцэж, **Цагаатгах тогтоолыг хүчингүй болгож**, нэмэлт мөрдөн байцаалт хийн, хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлүүлэхээр буцаасан. Хэрэг бүртгэлийн албанаас нэмэлт мөрдөн байцаалт хийсний дараа прокурор яллагдагчаар татах тогтоол үйлдэн Чингэлтэй дүүргийн шүүхэд шилжүүлсэн.

Ийнхүү 2006 оны 07 сарын 08-ны өдөр Чингэлтэй дүүргийн шүүхээс хэргийг **анхан шатны журмаар** хянан шийдвэрлэж, дээрх шийдвэрийг гаргасан байна.

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Д.Ганхуяг мэдүүлэхдээ: “Би арван хэдэн жил судалгааны ажил хийж, нотлох баримттай зүйл бичиж байсан. “Монгол таймс” сонины 8 дугаарт тэргүүн хатагтай О.Цолмонгийн тухай бичсэн болохоос биш **О.Чулуунбаттай холбоотой үг, үсэг байхгүй.** ... УИХ-ын гишүүн, сайдаас дээш албан тушаалтууд гарцаагүй 8 сая ам.долларыг гадагш гаргасан. Гэтэл **О.Чулуунбаатар заргалдаад 1 жил 3 сар гаруй болж байна.** Судлаачийн хувьд эрт үеэс одоог хүртэлх санхүүгийн булхайг уудалсан. Үүнийг **шалгах газар байхгүй**”. Засгийн газар их өрийг төлсөн асуудлыг ил тод байлгахгүй байгаа нь ихээхэн эмзэглэл төрүүлж байна”. Эндээс харахад хэргийг шийдвэрлэсэн байдал нь хэд хэдэн шатны шүүхээр орж, хугацааг сунжуулсан төдийгүй, олон нийтийн анхаарал татсан асуудлыг хөндөж бичснийг харгалзан үзээгүй байна.

О.Чулуунбат мэдүүлэхдээ “... нийтлэлд ЗХУ-д төлөх их өрийг төлж байх явцад **Монгол банкнаас 8 сая долларыг АНУ-руу шилжсэн** гэж бичсэн байсан нь зөвхөн миний **нэр төрийг ч биш Монгол банкны нэр төрийг унагаж байгаа** учраас хууль хяналтын байгууллагад хандсан юм. Энэ бол гүтгэлэг. Монгол банкнаас АНУ-руу 8 сая доллар шилжүүлээгүй, хувь хүнд **Монгол банк үйлчилдэггүй**. Монгол банкны санхүүгийн тайланг жил бүр олон улсын нэр хүндтэй аудитын байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулдаг. Их өрийг төлөгдөж байх үед банкны үйл ажиллагааг хянаж Эрист энд Янг компани дүгнэлтээ гаргасан байгаа” гэжээ. Эндээс харахад нийтлэлд **Ерөнхий сайд байсан Энхбаяр, түүний гэргий Цолモン нарын тухай нэр дурьдагдсан** байхад Монгол банкны ерөнхийлөгч “**зөвхөн миний ч биш Монгол банкны нэр хүндийг дэлхийн давцанд унагаж байгаа**” гэх гомдол гаргаж шийдвэрлүүлж байгаа нь нэг талаар өөр хүнийг шүүмжилсэн байхад гомдол гаргасан, нөгөө талаар төрийн албан байгууллага, түүнийг удирдагчийн хувьд гүтгэх гэмт хэргийн хохирогч гэж үзэх нь олон улсын жишгийн үүднээс буруу хандлага юм.

Монгол банкны бүртгэл тооцоо, мэдээллийн технологийн газрын захирал Б.Л өмнө нь гэрчийн мэдүүлэг өгөхдөө “Арилжааны банк биш учраас аж ахуйн нэгж, иргэдэд үйлчилдэггүй. Сургалтын төрийн сангаар дамжиж, гадаадад сурч байгаа оюутнуудын сургалтын тэтгэлгийн **бага дүнтэй гүйлгээ цөөхөн гардаг**” гэсэн байдаг. Энэ мэдүүлэг нь дээрх хувь хүнд үйлчилдэггүй гэсэнтэй зөрчилдэж байна. Мөн ЭБШХ-ийн 45.1-д “Хэргийн талаар ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа, тухайн хэрэгт холбогдолгүй хүнийг гэрч гэнэ” гэж тодорхойлсон байдаг. Гэрч Монгол Банкны хуулийн хэлтсийн мэргэжилтэн Т.Н нь мэдүүлэгтээ “энэ худал **нийтлэлийн хортой үр дагавар** нь зөвхөн нэг иргэнийг гутаасан биш, **улс орны эрх ашиг, мөнгөний бодлогод сөрөг нөлөө авчирч** байгаа юм” гэжээ (х.х-4). Гэтэл дээрх гэрчээр татагдсан этгээдүүд нь Монгол банкны ерөнхийлөгчийн шууд удирдлаган дор ажилладаг хүмүүс байжээ. Мөн олон нийтийн анхаарал татсан мэдээлэл бөгөөд иргэдийн татварын мөнгийг хэрхэн зарцуулж байгаа нь ил тод байх ёстой.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, прокурор нь хэд хэдэн удаа **мэдээллийг хаанаас авсан, эх сурвалжаа бидэнд гаргаж өг** хэмээн шаардаж байсан нь хавтаст хэрэгт авагдсан материалын шуудад байна. Мөн шүүх хуралдааны явцад улсын яллагч нь “Та хэлээч өөр баримт байгаа юу? Нэр устай нь хэлэх хэрэгтэй шүү дээ” гэсэн бөгөөд шүүгдэгч Д.Ганхуяг “**Судлаач хүн мэдээлэгч хүний нэрийг хэлдэггүй** юм. Цагдаа прокурорын хүрээнд ганц ч удаа миний хүсэлтийг хүлээн аваагүй” гэсэн нь, 2006.04.26-нд яллагдагчаар байцаасан тэмдэглэлд Д.Ганхуяг “**Мэдээллийн эх сурвалжийн аюулгүй байдал арилаагүй байгаа...**” гэсэн нь тус тус тэмдэглэгдсэн байна. Улсын яллагч 2006.07.08-ний өдрийн шүүх хуралдааны үеэр “**Ганхуяг нь эх сурвалжаа өөрөө гаргаж өгөх үүрэгтэй** Ганхуяг өөр хэдэн сонин авчраад шалга гэсэн. Энэ хэрэгт шалгах шаардлагагүй гэж үзсэн”, мөн прокурорын эсэргүүцэлд “**нийтлэлийнхээ эх сурвалжийг ... гаргаж өгөөгүй**” гэжээ. Энэ нь ЭБШХ-ийн 16.2-т “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардах эрхгүй” гэсэн заалттай зөрчилджээ.

Судлаач Д.Ганхуяг **Шударга шүүхээр асуудлаа шүүлгэх тухай** хүсэлтийг УДШ-ийн Ерөнхий шүүгчид 2 удаа тавьсан. 2006.01.18-ний өдрийн хүсэлтэд Д.Ганхуяг “**Намайг итгэл үнэмшлийн гэмт хэрэгтэй болгож, Их өр, түүнийг төлсөнтэй холбогдох олон сонин таамгийн дотроос өөрт олдсон ноцтой мэдээллийг олон нийтэд ил болгосны төлөө нийгмээс тусгаарлахаар зарим нэг хуульчид дарга нарынхаа дээрээс өгсөн үүрэг даалгавраар бараг бүтэн жилийн турш улайrsaар байна (х.х-147) гэж бичжээ. Хүсэлтийн хариуд “Монгол Улсад шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа шүүхүүд нь Монгол улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан үндэслэл, зарчмаар байгуулагдсан учраас эдгээр шүүхүүд нь “**шударга шүүх**” мөн бөгөөд энэ үндэслэлээр Чингэлтэй дүүргийн шүүхийг шударга шүүх гэж үзэх нь зүйд нийцнэ” гэсэн хариу хүлээн авсан. Мөн Д.Ганхуягийг 2005.05.10-нд яллагдагчаар байцаасан тэмдэглэлд “**Нэмж хэлэхэд хэрэг****

**бүртгэлтийн ажиллагаа дуусаагүй байхад хууль зүйн дотоод хэргийн сайд Ц.Нямдорж энд **миний өгсөн мэдүүлгийг тэр чигээр** нь ярьж байна. Энэ асуудлыг гайхаж байгаагаа хэлэх байна” гэжээ (х.х-29). Хэргийн материалд авагдсан 2006.03.23-ний өдрийн Шүүх хуралдааны тэмдэглэлд өмгөөлөгч С.Нарангэрэл “**Монголын шүүх хараат бус шударгаар байна гэдгээ харуулах хэрэгтэй**. Бидэнд байгаа мэдээллээр анхан шатны шүүхийн хуралдаан дууссаны дараа (Цагаатгах тогтоол гарсны дараа - бичиглэгч энэ тайлбарыг нэмэв) **Ерөнхийлөгчийн тамгын газар дээр Алтантуяа шүүгчийн хувийн хэргийг тэнд татаж үзэж байсан** гэсэн мэдээлэл байгаа. Энэ бол баттай мэдээлэл. Хэрвээ ингэж дээрээс нь дарамт учруулж байгаа бол **давж заалдах шатны шүүх бас шударга шийдвэр гаргана гэдэгт эргэлзэж байгаа**” гэж хэлсэн нь тэмдэглэгдсэн байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 16.14-т шударга шүүхээр шүүлгэх эрхтэй гэж баталгаажуулсан бөгөөд хэрэв шүүгчийн хувийн хэргийг татан үзэж байсан гэдэг нь тогтоогдсон бол энэ шүүхийн бие даасан байдалд хангагдахгүй байна гэж үзэх үндэслэлтэй болно. Мөн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед хаваст хэрэгт авагдсан мэдээллийн нууц хадгалагдсан эсэх нь эргэлзээтэй болж байна.**

Хаваст хэргийг судлан, үндэсний болон олон улсын хэм хэмжээ, жишиг стандартуудтай харьцуулж **ДҮГНЭХЭД**:

**Нэг.** Уг гэмт хэргийн бүрэлдэхүүнийг, ялангуяа **шууд санаатай үйлдсэн субъектив талыг** сайн тогтоогоогүй байна.

Дэлхий дахинд Үзэл бодлоо илэрхийлэх эрхийн төлөө кампанит ажил явуулдаг 19-р зүйл байгууллага “Гүтгэлгийг тодорхойлох нь: Үзэл бодлоо илэрхийлэх ба хүний нэр төрийг хамгаалах тухай зарчмууд” /цаашид “ГТХЗ” гэх/-ын 4 дэх зарчимд “**нэг талын нэр төр гүтгэгдсэн гэх гомдол шаардлага нь эргэлзээтэй, нотлох баримт бүрэн бус бол** хэнийг ч гүтгэлгийн эсрэг хуулиар **ял тулгаж болохгүй**”. Нэр төр гутаасны эсрэг үүсгэсэн шүүх ажиллагааг онцгой зарим нэг шалтгаанаас бусад бүх тохиолдолд 1 **жилийн дотор хянан** үзэж шийдвэрлэнэ. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд сөрөг нөлөө үзүүлэхийг хязгаарлах зорилгоор нэр төр гутаасны эсрэг үүсгэсэн шүүх ажиллагааны **үе шат бүрийг зохистой хурдан явуулахад шүүх анхаарах ёстой**<sup>2</sup> гэсэн зарчмуудыг зөрчсөн байна.

**Хоёр.** Олон улс оронд хэн нэгний нэр төрийг хамгаалах нь гол төлөв буюу бүхэлдээ хувь хүний ашиг сонирхол гэж үздэг. Гүтгэлгийг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэх нь хүний нэр төрийг хамгаалахад онцын шаардлагагүй байдаг бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарладаг учраас хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. “Хувь хүн, хуулийн этгээд гүтгэлгийн тухай нэхэмжлэл гаргах эрхтэй боловч энэ нь **төрийн байгууллагад хамаарах ёсгүй**<sup>3</sup> гэсэн ОУ-ын стандартыг мөн зөрчжээ.

Хүний эрхийн Европын шүүхээс ч ардчилсан нийгэмд Засгийн газар, төрийн байгууллагыг чөлөөтэй шүүмжлэх боломжтой байх нь чухал гэж

<sup>2</sup> ГТХЗ, зарчим-5.

<sup>3</sup> ГТХЗ, зарчим-3.

үздэг. Түүнчлэн төрийн албан хаагч, албан тушаалтан нь нийгэмд гүйцэтгэж буй үүргээсээ хамаарч байнга бусдын хараанд өртдөг онцлогтой бөгөөд бусадтай харьцуулахад **шүүмжлэлийг илүү тэсвэрлэх** ёстай. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн чөлөөт урсгал, олон нийтийн ашиг сонирхолд хамааралтай асуудлаар хувь хүнийг ил тод нээлттэй шүүмжлэн хэлэлцэх нь хувь хүний хөгжил, түүний нэр хүнд, ажил үйлст төдийгүй нийгмийн сайн сайхан, дэвшлийг хурдаасгаж, бусад хүмүүсийн үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэх боломжийг бүрдүүлдэгээрээ ардчилсан нийгэмд чухал ач холбогдолтой юм.

**Гурав.** “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн чөлөөт урсгал, санаа бодлын асуудал дэлхийн олон оронд хямралт байдалд ороод байна. Энэ нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэх явцад нь сэтгүүлчид болон бусад хүмүүсийг дайран давшлах (цензурдэх), гутгэлэг, доромжлолын хязгаарлагдмал хуулиар хохироо зэрэг хоёр хэлбэрийн түгшүүрээр илэрч байна” хэмээн онцлон дурьдаад “Гишүүн орнууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний эрхийг үл хязгаарлах байдлыг хангахын тулд гутгэлгийн эсрэг хуулиа эргэн нягталж, үүнийгээ олон улсын өмнө хүлээсэн үүрэгтээ нийцүүлэхийг” сануулсан.

Зарчмын хувьд **эрүүгийн хуулиас гутгэлгийн эсрэг заалтыг хасч, иргэний хуулиар зохицуулах хэрэгтэй**<sup>4</sup>. Одоог хүртэл гутгэлгийн эсрэг эрүүгийн хуультай улс орон энэ зарчмыг хэрэгжүүлэх алхам хийх хэрэгтэй.

**Дөрөв.** Нийтийн санаа зовоосон асуудлаар хэвлэгдсэн нийтлэл худал байсан ч гэсэн ач холбогдолтой бол хамгаалагдах ёстай гэж ГТХЗ-ийн 9-д заасан. Олон нийтийн санаа зовоосон асуудал гэдэгт олон нийтийн хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой бүх асуудал орно. Үүнд: төрийн “турван өндөрлөг”, төрийн зүтгэлтэн, албан тушаалтан, улс төр, нийгмийн сонирхол, эдийн засаг, соёл урлагийн асуудал хамаарна гэж үздэг. Иймд уг мэдээллийн нууц эх сурвалж, мэдээлэгчийг хамгаалах нь чухал болдог. Их өрийн асуудал нь “олон нийтийн анхаарал татсан асуудал” мөн учраас хамгаалагдах ёстай.

**Тав.** 19-р зүйл байгууллагын ГТХЗарчмын З-рт “Сэтгүүлч болон хэн ч эх сурвалжийн нууц байдлыг найдвартай хадгалж олон нийтийн эрх ашгийн үүднээс мэдээлэл тараах, мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхтэй. Энэ эрхийг ямар ч нөхцөлд гутгэлгийн хэрэгт халах, хязгаарлах ёсгүй. Энэ зарчмын дагуу гутгэлгийн хэрэгт мэдээллийн эх сурвалжаа илчлэхээс татгалзсанаас хэн ч хохирол амсах ёсгүй” гэсэн зарчим, Үндсэн хуулийн 16.14 дэх хэсэгт заасан гэм буруугүйгээ нотлохыг шаардахыг хориглосон заалтыг мөн зөрчсөн ажиллагаа явагдсан байна.

**Зургаа. Шударга шүүх** гэдэг нь (*Fair Trail*) хүний материаллаг болон процедурын эрх. Хүн бүхэн олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн шүүхийн шаардлагыг хангасан иргэний болон эрүүгийн шүүн таслан ажиллагаагаар хэргээ таслуулах эрхтэй. Ийм шүүхийн ажиллагаа нь гэрч

<sup>4</sup> Үзэл бодол, түүнийг илэрхийлэх эрх чөлөөний талаархи НҮБ-ийн тусгай илтгэгч, OSCE-хэвлэлийн эрх чөлөөний төлөөлөгч, OAS-ийн хэвлэлийн эрх чөлөөний тусгай илтгэгч нарын баталсан хамтарсан тунхаглалд

дуудах, шударга бөгөөд хараат бус шүүгчээр хэргээ шийдүүлэх, шүүхийн шийдвэр нь олон улсын шударга шүүхийн жишигт нийцсэн байх зэрэг шаардлагыг хангасан байна<sup>5</sup> гэж. Мөн Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пактийн 14-р зүйлд “**хүн бүр өөрт тулгарсан эрүүгийн хэргийг** ... эрх бүхий, хараат бус, тал үл харах **шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй**” гэж заасан байдаг. Түүнчлэн Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэмийн 17-р зүйлд Олон Улсын эрүүгийн шүүхийн **Авч үзэх асуудлыг** тодорхойлсон ба энэ нь шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангах агуулгатай юм. Иймд Үндсэн хуулийн 16.14 дэх хэсгийн шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангахын тулд хавтаст хэрэгт авагдсан өмгөөлөгчийн үгэнд байгаа “шүүгчийн хувийн хэргийг татаж үзсэн” мэдээллийг шалгаж тогтоогоогүй байна.

Хууль зүйн магистр Д.Мөнхбүрэн

### Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооны мэдэгдлүүд

**Хавсралт № 4.1**



International  
Federation  
of Journalists

**Хэвлэлийн мэдэгдэл: Монгол**

**2006.03.13**

<sup>5</sup> Хүний эрхийн Олон Улсын нэр томъёоны гарын авлага, Х.Виктор Кондэ, 1999, тал 54

## **Монголын сэтгүүлчид хуулийн илүү таатай орчинд ажиллах ёстойг Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо анхааруулж байна**

Монгол улсад засаг захиргааны ажилтнууд сэтгүүлчдийг цагдан хянах, сүрдүүлсэн нэлээд хэдэн хэрэг гарсантай холбогдуулан Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо Монголын сэтгүүлчид хуулийн илүү таатай орчинд ажиллах ёстойг анхааруулан мэдэгдэж байна.

2006 он гарснаас хойш сэтгүүлчдийг цагдан хянасан, мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг шаардсан арван тохиолдол бүртгэгдсэнийг Монголын хэвлэл мэдээллийн төлөө ажилладаг “Глоб Интернэшнл” ТББ мэдээлсэн юм.

“Монгол улсад сэтгүүлчдийг цагдан хянах, дарамт шахалт үзүүлэх, сүрдүүлэх явдал цаашид өсөх хандлагатай байгаад бид ихээхэн сэтгэл зовниж байна” гэж Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооны ерөнхийлөгч Кристофер Уоррен мэдэгдэв.

“Сэтгүүлч мэдээллийн эх сурвалжаа хамгаалах эрх Монгол улсад хуулиар баталгаажаагүй байгаа энэхүү нөхцөл байдлыг яаралтай авч үзэх шаардлагатай” гэж Варрен мэдэгдсэн юм.

2005 оны 12-р сарын 31-ны өдөр, Монголын Баруун хойд бүсийн Завхан аймгийн засаг дарга, орон нутгийн “Завхан” сонинг 2005 оны 12-р сарын 20-ны өдрийн дугаартаа нийтэлсэн тус аймгийн зочид буудлыг дуудлага худалдаанд оруулахтай холбоотой албан тушаалтны эрх ашгийг хөндсөн мэдээллээ залруулахгүй бол хаахаар сүрдүүлжээ. Мөн түүнчлэн Засаг дарга сонины эрхлэгч Б.Идэрийг чухал мэдээлэл нийтлэхээс өмнө зөвшөөрөл аваагүй гэж тэр өдөр загнаж дарамталсан байна.

Улсын төсвөөс санхүүжүүлж буй Чингис хааны хөшөө бүхий дурсгалын цогцолбор босгох барилга угсралтын төслийн мөнгө шамшигдсан талаар 2006 оны 1-р сарын 26-нд үндэсний хэмжээний өдөр тутмын “Үнэн” сонинд эрэн сурвалжилсан нийтлэл бичсэн тус сонины сурвалжлагч эмэгтэй Ш.Отгонжаргалыг Тагнуулын Ерөнхий газрын тусгай төлөөлөгч сүрдүүлж дарамталсан өөр нэгэн хэрэг гарчээ. Тусгай төлөөлөгч мэдээлэл олж авсан эх сурвалжаа хэлэхгүй бол сурвалжлагч эмэгтэйг баривчлахаар сүрдүүлсэн байна.

Улаанбаатар Ховдын хооронд нислэг хийдэг “Айро Монгол” агаарын тээврийн хувийн пүүсийн Ховд дахь төлөөлөгч нислэгийн тийзийг байнга илүү үнээр зардаг тухай 2006 оны 1-р сарын 1-нд нийтлэл бичсэний улмаас Ховд аймгийн Ховдын мэдээ сонины сэтгүүлч дарамт шахалтанд өртсөн байна. “Айро Монгол” пүүсийн Ховд дахь төлөөлөгч Б.Бүжинлхам мэдээлэл өгсөн хүмүүсээ хэлэхгүй бол сэтгүүлчийг шүүхэд өгөхөөр заналхийлжээ.

“Сэтгүүлчдийг энэхүү дарамт шахалтаас ангижуулж, улмаар хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалахын тулд сэтгүүлч мэдээллийн эх сурвалжаа нууцлах явдлыг хуульчлан баталж өгөхийг бид Монголын эрх баригчдад хандан уриалж байна” гэж Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооны ерөнхийлөгч мэдэгдэв

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл ОУСХ-ны Ази Номхон далайн бүсийн салбарын +61 2 9333 0919 утсанд хандаж болно.

*Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо нь дэлхийн 100 гаруй орны  
500000 гаруй сэтгүүлчдийг төлөөлөн ажилладаг.*

Хавсралт № 4.2

**Хэвлэлийн мэдэгдэл: Монгол**

**2006.07.13**



International  
Federation  
of Journalists

### **Монголын телевизийн сэтгүүлчид халджаэ**

Орхон аймгийн “Номин” телевизийн редактор Б.Цэвэгмид 7-р сарын 6-нд гэрийнхээ орцонд үл мэдэгдэх этгээдүүдэд зодуулж, гэмтсэний улмаас эмнэлэгт хүргэгдсэн тухай мэдээллийг Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо /ОУСХ/ цочирдсон хүлээн авч, эгдүүцэж байна.

ОУСХ-ны Ерөнхийлөгч Кристоффер Варрен хэлэхдээ, “Энэ балмад халлага нь мөн чанарын хувьд хамгийн ноцтой бөгөөд гэмт этгээдүүдэд зохих шийтгэлийг нь ногдуулах ёстой. Ажил үүргээ гүйцэтгэж байгаа хэн нэгний эрүүл мэндэд халдахыг хүлцэж, хүлээн зөвшөөрөх аргагүй билээ” гэсэн байна.

Орхон аймгийн Номин телевиз 6-р сарын 11-нд Эрдэнэтийн Уулын Баяжуулах Үйлдвэрийн 9000 ажилчны их хувьчлалын эрхийн бичгийн тухай “Үзэхийг хориглоно” нэвтрүүлэг эфирээр цацсан юм. Телевизийн нэвтрүүлэг эфирт гарахаас өмнө болон хойно сэтгүүлч эмэгтэй Б.Цэвэгмидийг үл мэдэгдэх Хүмүүс утсаар заналхийлснээс гадна тус үйлдвэрийн ажилчдын их хувьчлалын эрхийн бичгийг хадгалж байсан “Эрдэнэст” брокерийн пүүсийн захирал асан Амаржаргал “Та нар бодит мэдээлэл цацах ёстой, хамаагүй юм мэдээлж байж алуулав, энэ чинь их хэцүү асуудал шүү” хэмээн нэвтрүүлгийн үеэр сэтгүүлчид анхааруулжээ.

“Санаанд багтамгүй энэ балмад халдлагыг үйлдсэн гэмт этгээдүүдийг илрүүлж, хууль хяналтын байгууллагад шилжүүлэхийг ОУСХ Монголын цагдаагийн газарт уриалж байна.”

“Монголын сэтгүүлчдэд хадлагад өртөх айдас хүйдэсгүй ажил үүргээ гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлэхийн тулд тэднийг дэмжиж, эрхийг нь хамгаалахыг ОУСХ уриалж байна” гэж ОУСХ-ны Ерөнхийлөгч Кристоффер Варрен мэдэгджээ.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл ОУСХ-ны Ази Номхон далайн бүсийн салбарын +61 2 9333 0919 утсанд хандаж болно.

*Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо нь дэлхийн 100 гаруй орны 500 000 гаруй сэтгүүлчдийг төлөөлөн ажилладаг.*

Хавсралт № 4.3

Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооны мэдэгдэл



International  
Federation  
of Journalists

Хэвлэлийн мэдэгдэл: Монгол Улс  
2006 оны 6-р сарын 21

**Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо сэтгүүлчийн эрхийг хүндэтгэхийг  
Монголын эрх баригчдаас шаардаж байна.**

Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч нарт мэдээлэл өгөхөөс татгалздаг Монголын эрх баригчдыг Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо эрс шүүмжилж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүйн Зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Даштүдэв энэ оны 6-р сарын 12-ны өдөр Зөвлөлийн хуралдааны үеэр орон нутгийн радиогийн сэтгүүлчийн диктофоныг хоёр удаа өөрийн гараар унтрааж, улмаар тэнд байсан хоёр сэтгүүлчийг гарч явахыг шаардсан тухай Глоб Интернэшнл ТББ мэдээлсэн юм.

Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооны ерөнхийлөгч Христофер Варрен “Эрх баригчид сэтгүүлчдэд мэдээлэл өгөхөөс татгалзаж, хууль ёсоор гэрчлэх баримтыг үгүйсгэж байгаа нь олон нийт бодит үнэнийг судлан мэдэх боломжийг хааж, улмаар өөрсдийгөө хаацайлах, гэм зэмгүй өнгөрөх орчин бий болгохыг чармайж байгаа хэрэг” гэж үзэж байна.

Шохой боловсруулах “Цавчирт” болон бусад аж ахуйн нэгжүүд байгаль орчинд хор хөнөөл учруулж байгаа тухай нэвтрүүлэг явуулсан гэсэн шалтгаанаар Цавчирт компанийн удирдлага 2006 оны 5-р сарын 24-ний өдөр олон нийтийн мэдээллийн “ОРХОН” радиогийн сурвалжлагч Т.Баярцогтод мэдээлэл өгөхөөс татгалзан үйлдвэрлэлийн талбайдаа нэвтрэх зөвшөөрөл өгөөгүй тухай “Глоб Интернэшнл” ТББ мөн үүний өмнөхөн мэдээлж байсан билээ.

Монгол Улсын эрүүгийн хуулинд “Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд тараах, эсхүл тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийвэл гэмт хэрэг” гэж үздэг тухай Глоб Интернэшнл ТББ-ын мэдэгдэл дурдсан байна.

Сэтгүүлчдэд аливаа нэгэн хөндлөнгийн оролцоогүй, чөлөөтэй мэдээлэх боломж олгож, тэдний эрхийг хүндэтгэн хамгаалахыг Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо Монголын эрх баригчдад хандан уриалж байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл энэ хаягаар IFJ Asia Pacific +61 2 9333 0919 хандана уу.

Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо нь дэлхийн 110 гаруй орны 500 000 гаруй сэтгүүлчдийг төлөөлөн ажилладаг.

ОУСХ-ны мэдэгдэл

Хавсралт 4.4

Хавсралт № 5

Цагдан хяналтын эсрэг!!!

Уриалга

Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооны 21-р Их хурлаас баталсан “Ардчилсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн соёлын тунхаг”-т ардчилсан нийгэмд мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг онцгой өвөрмөц агаад тухайлсан үүргийг ухаарч сэхээрсэн тэр цагт ардчилал бүрнээ үнэ хүндтэй болох учиртай гэсэн байдаг. Мөн ОУСХ нь хэвлэлийн эрх чөлөө гэдгийг “хөндлөнгийн нөлөөлөл, оролцоноос чөлөөтэй байх явдал мөн” хэмээн тодорхойлсон.

Цагдан хяналт (цензур) бол үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж буйн тод илрэл бөгөөд хамгийн ноцтой хэлбэр юм. Монгол Улсад 1998 онд батлагдсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар цагдан хяналт (цензур)-ыг хориглосон. Гэвч “Глоб Интернэшнл” ТББ-аас 2004, 2005 онд сэтгүүлчдийн дунд явуулсан судалгаанд оролцогчид 100 хувь цагдан хяналт бодитой оршисоор байгааг хүлээн зөвшөөрч, бүх сэтгүүлч “өөрийгөө цагдан хянадаг” гэж хариулсан нь сэтгүүлчдэд мэргэжлийн ёс зүйгээ баримтлахад нь хүчтэй нөлөөлж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд түгшүүр төрүүлж байна.

“Глоб Интернэшнл” ТББ, “Зориг сан” хамтран Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тохиолдуулан зохион байгуулсан дугуй ширээний ярилцлагад оролцогчид бид 1987 оны 1-р сарын 16-18-ны өдрүүдэд Лондон хотноо болсон “Дэлхийн эрх чөлөөний дуу хоолой” цагдан хяналтын (цензур) эсрэг бага хурлын төлөөлөгч, 34 орны сэтгүүлчдийн баталсан

“Чөлөөт хэвлэлийн харти”, “Ардчилсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн соёлын тунхаг” зэрэг баримт бичгийг иш үндэс болгон энэхүү уриалгыг хэлэлцэн батлав.

Монгол Улсын хэмжээнд болон хилийн чанадад мэдээ, мэдээллийг саадгүй түгээх, сэтгүүлчийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд явуулах орчинг бүрдүүлэх, олон нийтийн үнэнийг олж мэдэх эрх ашгийг дээдлэн хүндэтгэхийн тулд:

**УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар, төрийн байгууллагын албан тушаалтнуудад:**

Нэгд: Шууд болон шууд бус аливаа хэлбэрийн цагдан хяналтыг (цензур) хориглосон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн заалтаа хэлбэрэлтгүй сахин биелүүлэх, мэдээллийг чөлөөтэй цуглуулах, түгээх эрхэд ноцтой хязгаарлалт тогтоосон Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Эрүүгийн хуулийг ардчилсан нийгмийн шалгуур зарчмуудад нийцүүлэх,

Хоёрт: Нийтлэл нэвтрүүлгийн агуулгад хөндлөнгөөс оролцох, мэдээллийн аливаа эх сурвалжид нэвтрэх боломжийг хязгаарлах оролдлогоо зогсоох, мэдээллийн нууц эх сурвалжаа хамгаалах үүргийг хуульчлан баталгаажуулах,

Гуравт: Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээлэл өгөхийг төрийн албан тушаалтнуудад үүрэг болгосон Мэдээллийн эрх чөлөөний хуулийг нэн даруй хэлэлцэж батлах,

**ХМХ-ийн эзэд, эрхлэгчдэд:**

Редакцийн цагдан хяналтыг хориглох, редакцийн хараат бус байдлыг хангасан гэрээг сэтгүүлчидтэйгээ нэн даруй байгуулж, тэдний өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож, дарамт шахалт үзүүлэхээ зогсоох,

**Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлд:**

Хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчдийн эрхийг хамгаалах үүрэг гүйцэтгэдэг хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тогтолцоог хөгжүүлэхэд онцгой анхаарахыг уриалж байна.

**Сэтгүүлчид ээ!**

Гагцхүү үнэнийг мэдэх гэсэн олон нийтийн эрх ашигт үйлчлэн, хүний эрхийг хүндэтгэн дээдэлж, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээгээ чанд баримтлан ажиллай.

УИХ-аас 2003 онд баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр”-ийн “Хүний суурь эрхийг хангах нь” хэмээх бүлгийн 2.2.5 хэсгийн заалтуудыг Монгол Улсын Засгийн газар эрчимтэй, үр дүнтэй хэрэгжүүлнэ гэдэгт бид итгэж байна.

“Цагдан Хяналтын Эсрэг!!!”

Дугуй ширээний ярилцлагад оролцогчид батлав  
2006 оны 05 сарын 02-ний өдөр

Улаанбаатар хот